

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2018 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.12.10

МӨРӨН

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсны Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол шийдвэр, 2018 онд Монгол Улсын Засгийн газрын тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрүүд, цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт, алсын хараа, зорилт, 2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шуурхай үйлчилгээг үзүүлж, үйл ажиллагаандаа иргэдийг өргөнөөр татан оролцуулж хөндлөнгийн хяналт бий болгох замаар хуулийн хэрэгжилтийг хангах ажиллах, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн Ерөнхий Газрын удирдлагаас өгсөн үүрэг, албан даалгавар, ажлын чиглэлийг хэрэгжүүлж Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, ил тод, шударга, шуурхай, хуульч ажиллагааг хэвшүүлэх зорилт хэрэгжүүлж, дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаа.

Нэг: Удирдлага зохион байгуулалтын
чиглэлээр

- Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр; /хөтөлбөр, төлөвлөгөө холбогдох бусад баримт бичгийн хэрэгжилтийг гарган хүргүүлсэн байдал/

Цагдаагийн Ерөнхий Газраас 2018 онд дэвшүүлсэн зорилт, Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний заалт, өмнөх онуудад зохион байгуулсан ажлын үр дүн болон дутагдалтай зүйлүүдэд дүгнэлт хийж ажлын төлөвлөгөөндөө тусган алба хаагчдын үйл ажиллагааны үр дүнгийн итгэл үнэмшлийг бий болгох, боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх бодлого барьж ажилласан болно.

Тасаг, хэсгийн дарга нар 7 хоног бүрийн Даваа гарагт хийсэн ажлаа цагдаагийн газрын даргад танилцуулж, ажлын чиглэл, үүргийг авч дараагийн 7 хоногт хийх ажлаа төлөвлөн ажиллаж байна.

Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар сар бүр Аймгийн Засаг дарга, Хууль эрх зүйн хэлтэс, сумдын Засаг дарга нарт санал мэдээлэл хүргүүлэн тэдний дэмжлэг туслалцааг авч байна.

Аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж цагдаагийн газрын судалгааны багаар 12 удаа хэлэлцүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж мэдээллийн санд шивилт хийж ажиллаж байна.

Энэ хугацаанд “Бурхан”, Ачааны авто машины бүрэн бүтэн байдал”, Архидалтын бууруулах”, “Шинэ жил, зорчигч тээвэрлэлт”, “Шинэ жил”, “Жагсаал” “Галт зэвсэг”, “Мотоцикль”, “Ноолуур”, “Төгсөлт”, “Архидалтыг бууруулах-2”, “Цонх”, “Камержуулалт” зэрэг 16 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн газрын дарга 6 тасгийн даргатай 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулав. 136 алба хаагчтай тасгийн дарга нар үр дүнгийн гэрээ байгуулж гэрээний биелэлтийг сар тутамд тооцож ажиллаа. Захиргааны удирдлагын тасгийн дарга хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа 3 ажилтантай хөдөлмөрийн гэрээг байгуулж ажилласан.

Энэ хугацаанд ажил дүгнэх шалгуур үзүүлэлт хангаж ажиллаж байгаа 192 алба хаагчийн албан тушаалын цалинг 5 хувиар, 44 алба хаагчийн цалинг 10 хувь, 2 алба хаагчийн цалинг 1 сарын хугацаагаар 15 хувиар, 70 алба хаагчийн цалинг нэг сарын хугацаагаар 20 хувиар тус тус хасч, 34 алба хаагчийн цалинг 5 хувиар, 65 алба хаагчийн цалинг 10 хувиар, 7 алба хаагчийн цалинг 15 хувиар, 52 алба хаагчийн

цалинг 20 хувиар, 1 алба хаагчийн цалинг 25 хувиар тус тус нэмэгдүүлж олгосон байна.

Цагдаагийн Ерөнхий Газрын Гадаад харилцааны хэлтээс ажлын чиглэл ирүүлсний дагуу “Гадаадын байгууллага, иргэнтэй харилцах /код 131/ журам”-д заасныг баримтлан Их Британи, Умард Ирландын Вант улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамнаас тус элчин сайдын яамны хэргийг түр хамаарагч Иан Кокс болон Консулын ажилтан С.Оюу нартай 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр, Америкын Нэгдсэн улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны Элчин сайдын Ерөнхий консул Жейсон Спэлбэрг, консулын ажилтан Т.Цэрэндавга, Б.Лхагважаргал нартай 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр тус тус уулзалт хийсэн. Уулзалтаар Цагдаагийн Ерөнхий Газрыг төлөөлж яриа хэлэлцээ хийгээгүй болно. Дүнг тухай бүрт нь Цагдаагийн Ерөнхий Газрын Гадаад харилцааны хэлтэст хүргүүлж ажилласан.

-Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаалын тоо-

Тус цагдаагийн газрын даргад 2018 онд байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон алба хаагчдаас 178 өргөдөл, гомдлыг гаргасан байна. Алба хаагчдаас 62 алба хаагч захиргааны чөлөө хүссэнийг 2-5 хоногийн чөлөөг ээлжийн амралтаас тооцож олгосон. Цэргийн байнгын тэтгэвэрт гарах, нэг удаагийн тэтгэмж авах хүсэлт гаргасан 26 алба хаагчийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. 2018 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон алба хаагчдаас 178 өргөдөл гомдол ирүүлснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба үүнээс 41 буюу 24.5 хувь нь ажилд орох, суралцахыг, 9 буюу 5.0 хувь нь ажилд дахин орох, 13 буюу 7.3 хувь нь шилжин ажиллах, 62 буюу 34.8 хувь захиргааны чөлөө хүссэн, 26 буюу 14.6 хувь нь орон сууц, тэтгэвэр, тэтгэмж хүссэн, Мөн 11 нь Цагдаагийн газрын үйл ажиллагаа болон цагдаагийн алба хаагчтай холбоотой 11-11 төвөөс 1 буюу 0.5 хувь, Хууль зүй дотоод хэргийн яаманд 1 буюу 0.5 хувь, Цагдаагийн Ерөнхий Газарт хандсан 7 буюу 3.9 хувь, Цагдаагийн газрын даргад хандсан 2 буюу 1.0 хувь өргөдөл гомдол гаргасанд тухай бүрт нь албаны шалгалтыг хийж шийдвэрлэж хариуг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнд мэдэгдэж ажилласан. Иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд үйлчилж ажилласан байна. Өргөдлийн мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгож Цагдаагийн Ерөнхий Газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлж хэвшсэн.

Тус цагдаагийн газрын даргын зөвлөлийн 17 удаагийн хурлаар 160 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажилласан байна. Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлыг авч үзвэл: Алба хаагчдын ажлын үр дүнг тооцсон 12, шилжин болон дэвшин томилох асуудал 14, албаны шалгалтын дүнг хэлэлцэж шийдвэрлэсэн асуудал 30, Цагдаагийн албаны тухай хуулийн 89.2-т заасны дагуу 30 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгуулах асуудал 10, Цагдаагийн цол олгуулах асуудал 24, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох асуудал 10, бусад 90 асуудлыг тус тус хэлэлцэж холбогдох алба, нэгжүүдэд хүргүүлж шийдвэрлүүлсэн байна.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын тушаал гаргах /код 136/ журам”-ыг баримталж 2018 оны эхний 12 сарын байдлаар цагдаагийн газрын даргын “А” тушаал 94, “Б” тушаал 172-г боловсруулж гаргасан байна.

-Хүний нөөцийн талаар-

Тус Цагдаагийн газар нь одоо 78 офицер, 64 ахлагч, 4 гэрээт цагдаа, 3 энгийн бүгд 149 алба хаагчтай ажиллаж байгаагаас эрэгтэй 125, эмэгтэй 18 алба хаагчтайгаар аймгийн төвд 6 тасагтай, 23 суманд тасгийн дарга 2, сум дахь төлөөлөгч 21, цагдаа 25 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Одоогоор тус цагдаагийн газарт Эргүүлийн цагдаа 1, цагдаа-жолооч-1, Эрүүлжүүлэх, саатуулах байрны жижүүрийн цагдаа, Цагаан-Үүр сум дахь хэсгийн

төлөөлөгч, Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн бүгд 5 ажлын сул байр байна. Ажил хавсарч гүйцэтгэж байгаа алба хаагч байхгүй.

Энэ хугацаанд Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Найрамдалын Эрхэмбаяр Тосонцэнгэл сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Цагдаагийн ахлах ахлагч Доржийн Сэнгэравдан Арбулаг сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Сундуйн Бат Замын цагдаагийн зохицуулагчаар, Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Алтангэрэлийн Дашцоож Цагаан-Уул сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Дагийн Отгонбаяр Хүний нөөцийн мэргэжилтнээр дэвшин томилогдож цагдаагийн дэслэгч цол олгогдсон.

Жижүүрийн офицер, цагдаагийн ахмад Б.Алтанцог жижүүрийн ахлах офицeroор, Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад А.Гантунгалаг Мэдээлэл, судалгааны мэргэжилтнээр, Цагаан-Уул сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч Р.Эрдэнэбат Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтнээр, Мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Мөнхдаваа Хэв журмын журмын ажил хариуцсан ахлах байцаагчаар, Мөрдөгч, цагдаагийн ахмад Н.Ганзориг Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгчөөр, Замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн хошууч А.Мөнх-Эрдэнэ Замын цагдаагийн ахлах зохицуулагчаар, Жижүүрийн ахлах офицер, цагдаагийн хошууч Г.Батсайхан Хатгал тосгоны цагдаагийн хэсгийн даргаар, Замын цагдаагийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч А.Эрдэнэзул Замын цагдаагийн тасгийн даргаар, Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргаар, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Оргилболд тус цагдаагийн газрын Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр, Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа Б.Бат-Өлзий Тариалан сум дахь сум дундын цагдаагийн тасгийн даргаар, Арбулаг сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч Ц.Булганбаатар Ховд аймаг дахь цагдаагийн газрын Эрүүгийн мөрдөгчөөр, Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Ананд Булган аймаг дахь цагдаагийн газарт Мөрдөгчөөр, Нярав-цагдаа, цагдаагийн дэд ахлагч П.Отгонбаяр Ховд аймаг дахь цагдаагийн газарт бичиг хэргийн эрхлэгчээр тус тус шилжин томилогдсон.

Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Энхбаяр, замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Нямбат, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Энхбаяр, Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Ганчимэг, Мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Алтанзул, Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ц.Тунгалагтэс нар цэргийн байнгын тэтгэвэрт гарсан.

Төрийн тусгай албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтанд тэнцсэн иргэн Ж.Гантөрийг Алаг-Эрдэнэ сумын хэсгийн цагдаагийн, Б.Нямдавааг Харуулын цагдаагийн, Г.Бямбадоржийг Тариалан сумын цагдаагийн хэсгийн цагдаа-жолоочийн, Ч.Энхболдыг Рэнчинлхүмбэ сумын хэсгийн цагдаагийн, Х.Мягмарсүрэнг нярав цагдаагийн, Ж.Пүрэвдоржийг эргүүлийн цагдаагийн, Н.Баяндалайг цагдаа-жолоочийн, Б.Эрхбаярыг харуулын цагдаагийн албан тушаалд томилуулах зөвшөөрлийг Цагдаагийн Ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтсээс авч албан тушаалд томилон ажлуулж байна.

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны төгсөлтөөс цагдаагийн дэслэгч Ц.Билгүүн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч О.Гал-Эрдэнэ мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Жанлавцогзол мөрдөгч, цагдаагийн дэслэгч М.Батхолбоо Улаан-Уул сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Даваадорж хэсгийн байцаагчаар тус тус томилогдсон.

Алба хаагчдын талаарх мэдээллийг цахим санд бүрэн оруулж, ахлагч бүрэлдэхүүний хувийн хэрэгт цалин нэмсэн болон хассан, сахилгын шийтгэл оногдуулагдсан, ажлын байр өөрчилсөн, удаан жилийн нэмэгдэл олгосон, шагнал урамшилд тодорхойлогдсон, шагнагдсан, ажлын үр дүнг тооцсон, урт болон богино хугацааны сургалтад хамрагдсан, сургууль, дамжаа төгссөн, нөөцөд авагдсан зэрэг мэдээллийн талаарх баяжилт тухай бүртээ хийгдсэн.

Цагдаагийн Ерөнхий Газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст 9 удаа 415 хуудас материалыг хувийн хэрэгт баяжилт хийлгэхээр хүргүүлсэн.

Цагдаагийн газрын алба хаагчдаас Хууль сахиулах их сургуулийн бакалаврын сургалтыг Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч А.Энхбаяр, Их-Уул сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч П.Нямдорж нар тус тус төгсч, бакалаврын дипломыг гардан авсан.

Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч А.Баянмөнх, Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч Д.Баярсайхан, цагдаагийн ахлагч Д.Отгонхуяг, Сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч Ё.Шижиртуяа, Эрүүлжүүлэх, баривчлах байрын эмч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Дашпүрэв, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мягмардорж, цагдаагийн ахлах дэслэгч Э.Пүрэвжаргал, Чандмань-Өндөр сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Л.Батпүрэв, Тосонцэнгэл сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Л.Тод-Эрдэнэ, Ахлах нягтлан бодогч, цагдаагийн ахмад Б.Энхчимэг нарын 10 алба хаагч суралцаж байна.

Энэ хугацаанд Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Д.Алтанзул Эрүүгийн цагдаагийн албаны “Баярын бичиг”-ээр, Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Ганням Батлан хамгаалах яамны “Дайчин алдар”-3, Банкны гэрээт цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Х.Цогтгэрэл “Эх орны төлөө”-1 медаль, Жаргалант сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Д.Энхтүвшин Аймгийн Засаг даргын “Хүндэт жуух”, Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мягмардорж Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Баярын бичиг”-ээр, Мөрдөн байцаах албаны “Баярын бичиг”-ээр Мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Энхтүвшинг, “Санхүү аж ахуйн албаны “Баярын бичиг”-ээр Хатгал тосгон дахь Цагдаагийн тасгийн цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Т.Отгондавааг, Эрүүгийн цагдаагийн албаны “Баярын бичиг”-ээр, Тариалан сум дахь Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Бат-Өлзий нар тус тус шагнагдлаа.

Банкны гэрээт цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Мягмарсүрэнгийн Батхолбоо, Цагаан-Үүр сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Мягмаржалбуугийн Энхболд, Бүрэнтогтох сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Төмөрбаатарын Жавхлан, Түнэл сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Барнямын Нэргүй нар Цагдаагийн Ерөнхий Газрын “Хүндэт жуух”, Мэдээлэл, хүлээн авагч цагдаа, цагдаагийн сургагч ахлагч П.Хатанбаатар, Цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Чойжамцын Маналсүрэн, Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад А.Гантунгалаг, Аж ахуйн офицер, цагдаагийн ахмад Я.Мөнхмөрөн, Галт сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Наранбаатар, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн нар Цагдаагийн Ерөнхий газрын “Цагдаагийн гавъяа” тэмдэгээр тус тус шагнагдсан.

Ахлах нягтлан бодогч, цагдаагийн ахмад Б.Энхчимэг, Хэв журмын ажил харицсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Г.Мөнхдаваа, Ахлэх мөрдөгч, цагдаагийн ахмад Х.Гантулга, Эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Балжинням, Хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Б.Мөнгөнзагас, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Ю.Одгэрэл, Ренчинлхүмбэ сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Ч.Энхбат, Зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн ахлах ахлагч Б.Цэцэгмаа, Цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Т.Энхбаяр, Их-уул сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч П.Нямдорж нарыг Цагдаагийн Ерөнхий Газрын “Албаны төлөө-3” медалиар,

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн, Жижүүрийн офицер, цагдаагийн ахмад Б.Нямрэнцэн, Цэцэрлэг сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Бат-Очир, Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч А.Гантунгалаг, Цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Б.Чинзориг, Мэдээлэл хүлээн авагч цагдаа, цагдаагийн сургагч ахлагч П.Хатанбаатар, Банкны гэрээт цагдаа, цагдаагийн ахлах ахлагч М.Батхолбоо, Ренчинлхүмбэ сумын хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ч.Энхболд нарыг Цагдаагийн Ерөнхий Газрын “Албаны төлөө-2” медалиар,

Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч А.Мөнх-Эрдэнэ, Цагаан-уул сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч Р.Эрдэнэбат, Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Алтанзул, Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ц.Эрдэнэбат, Банкны гэрээт цагдаа, цагдаагийн

ахлах ахлагч Х.Цогтгэрэл нар Цагдаагийн Ерөнхий Газрын “Албаны төлөө-1” медалиар,

Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа Жамъяндоржийн Чинзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух”, Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа Дагвадоржийн Баатар “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ц.Эрдэнэбат, Цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Т.Бөхболд нар “Цэргийн хүндэт” медалиар, Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Уртбаяр “Цэргийн гавъяаны одон”-гоор тус тус шагнагдсан.

Шагнал урамшуулалд тодорхойлохдоо Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Шагнал, урамшуулал олгох /код 925/ журам”-ыг баримталж ажилласан бөгөөд шагнал урамшуулалтай холбоотойгоор алба хаагч нараас санал гомдол гараагүй эрхэлсэн ажилдаа гаргасан амжилтыг үнэлж шагналд тодорхойлж цагдаагийн газрын даргын зөвлөл, хамт олны саналаар шийдвэрлэх ажлыг тогтмолжуулсан.

Цагдаагийн байгууллагад анх орж ажиллахаар хүсэлтээ гаргасан иргэдийг судлах, шалгаруулах, томилох, албан тушаалд дэвшүүлэхдээ Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны А/248 дүгээр тушаал батлагдсан “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх” журмыг чанд мөрдөж ажиллаж байгаа бөгөөд шинээр томилогдсон алба хаагчдаас дутагдлаар халагдсан алба хаагч байхгүй.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Албан тушаал дэвшүүлэх” журам /код 909/-ын 909.7-д заасны дагуу тус газрын алба хаагчдаас офицерын нөөцөд 6, ахлахын нөөцөд 4, тасаг, хэсгийн даргын нөөцөд 5, хэлтэс, газрын даргын нөөцөд 2 алба хаагчийг бүртгүүлэхээр холбогдох материалыг хүргүүлж ажилласан.

Цагдаагийн албаны тухай Монгол Улсын хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам”-д заасан болзол шаардлагыг хангасан 11 алба хаагчид хугацааны цагдаагийн ахлах ахлагч цол, 1 алба хаагчид цагдаагийн хугацааны ахлах дэслэгч цол, 7 алба хаагчид цагдаагийн хугацааны хошууч цол, 10 алба хаагчид цагдаагийн хугацааны ахмад цол, 1 алба хаагчид хугацааны цагдаагийн дэд хурандаа цолыг тус тус олгуулсан.

-Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр
дотооддоо зохион байгуулсан сургалт-

Цагдаагийн газрын хэмжээнд зохиогдох албаны сургалтыг Цагдаагийн Ерөнхий Газрын Хүний нөөц, сургалтын хэлтсээс ирүүлсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулж цагдаагийн газрын даргын тушаалаар сургалтын төлөвлөгөөг батлуулан тасгууд өөрсдийн чиглэлээр, бие бүрэлдэхүүн нэгдсэн байдлаар явуулав.

Алба хаагч нарын хууль эрх зүй, албаны мэдлэг чадвар зэвсэг техник, бие бялдар, гадаад хэл, компьютер болон сахилга ёс зүйг дээшлүүлэх зорилгоор сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж байна. Алба хаагчдад явуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж 7 хоног бүрийн Даваа гарагийн 15-16 цагийн хооронд сургалтыг зохион байгууллаа.

Цагдаагийн Ерөнхий Газраас зохион байгуулсан давтан болон мэргэшүүлэх сургалтанд Цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн, цагдаагийн ахмад Г.Оргилболд, цагдаагийн ахмад Б.Бат-Амгалан, цагдаагийн ахлах дэслэгч Б.Батзаяа, цагдаагийн ахлах дэслэгч Г.Мягмарсүрэн, цагдаагийн дэслэгч Э.Шагдарсүрэн, цагдаагийн дэслэгч Б.Бямбалхам, цагдаагийн дэд ахлагч Э.Мягмаржалбуу, цагдаагийн дэд ахлагч Б.Балдан-Очир, Саатуулах байрны дарга-эмч, цагдаагийн ахмад О.Мөнхсайхан, Цагааннуур сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч М.Энхбаатар, цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Г.Дамдинрагчаа, Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Бат-Амгалан, Их-Уул сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Батзаяа, Шүүх, шүүгчийн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа Д.Баатар, Замын цагдаагийн ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад А.Эрдэнэзул, зохицуулагч, цагдаагийн ахмад А.Мөнх-Эрдэнэ, Түнэл сумын хэсгийн

цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Нэргүй, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн хошууч Д.Бадмаа, Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Ганням, Мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Мөнхтөр, Хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн хошууч Н.Баттөмөр, цагдаагийн хошууч Б.Нямдорж, цагдаагийн ахлах дэслэгч Б.Далайцэрэн, цагдаагийн ахмад Б.Балжинням, цагдаагийн дэслэгч Б.Даваадорж, цагдаагийн дэслэгч Я.Мөнхмөрөн, цагдаагийн дэслэгч Д.Сэнгэравдан, цагдаагийн дэслэгч Ц.Билгүүн, цагдаагийн дэслэгч М.Батхолбоо, цагдаагийн дэслэгч Н.Эрхэмбаяр, цагдаагийн дэслэгч А.Дашцоож, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мягмардорж нарын 47 алба хаагчид оролцлоо.

Мөн төвөөс зохион байгуулагдсан ёс зүйн төлбөртэй сургалтанд цагдаагийн хошууч Б.Гантөмөр, цагдаагийн хошууч Д.Мөнхжаргал, цагдаагийн ахмад А.Эрдэнэзул, цагдаагийн ахмад Д.Мөнхтулга, цагдаагийн ахлах ахлагч Б.Цэцэгмаа, цагдаагийн ахлагч Г.Уранцэцэг нар хамрагдсан. Цагдаагийн Ерөнхий Газрын Дотоод аюулгүй байдлыг хангах газар, Хүний нөөц, сургалтын хэлтсээс зохион байгуулсан цахим сургалтанд 16 алба хаагч хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын тушаалаар батлагдсан, цагдаагийн байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх журам, заавар, шийдвэрийг алба хаагчдад хүргэх, судлуулах, хэвшүүлэх зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар шинэчилэгдэн батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 1-9 дүгээр бүлгийн 234 гаруй код журмуудаар алба хаагчдад сургалтыг тус тус зохион байгуулав

Долоо хоног бүрийн Мягмар гарагийн сургалтын цагаар нийт бие бүрэлдэхүүнд, Баасан гараг бүрт тасгуудын сургалтын цагаар хэсэгчилсэн хэлбэрээр хууль тогтоох, хэрэгжүүлэх байгууллагаас шинээр гаргасан тушаал шийдвэрүүдийг танилцуулж хэвшлээ.

Алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой, нэн шаардлагатай зарим тушаал шийдвэрийг хувилж олшруулан тарааж судлуулах ажлыг зохион байгуулж байна.

2018 онд тус цагдаагийн газрын 149 алба хаагч нарт 126 удаагийн сургалтыг зохион байгуулж, 12 сургалтын хөтөлбөр боловсруулж, 12 сарын сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Энэ хугацаанд сургалтанд алба хаагчид давхардсан тоогоор 13455 алба хаагч хамрагдлаа. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг 12 удаа шинэчилж, сургалтын видео кино, бичлэг 13 удаа үзүүлж, 42 материалыг хуулбарлан тарааж, сургалтын зардал, алба хаагчдын сургалтанд хамрагдах үеийн хоолны зардалд 300.000 төгрөгийг зарцууллаа.

Тус цагдаагийн газарт нэгдсэн сургалтыг 11 удаа 145 цагийн хугацаатай зохион байгуулж 1024 алба хаагч, шинээр батлагдсан хууль тогтоомжийн сургалтыг 19 удаа 19 цагийн хугацаатай зохион байгуулж 2197 алба хаагч, бусад хууль тогтоомжийн сургалтыг 14 удаа 14 цагийн хугацаатай зохион байгуулж 1526 алба хаагч, алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг 9 удаа 9 цагийн хугацаатайгаар зохион байгуулж 1526 алба хаагч, дадлагажуулах сургалтыг 9 удаа 9 цагийн хугацаатайгаар зохион байгуулж 960 алба хаагч, бие бялдарын бэлтгэлжилтийг хангах сургалтыг 36 удаа 72 цагийн хугацаатайгаар зохион байгуулж 6288 алба хаагч, ажлын байрны сургалтын хөтөлбөрт сургалтыг 19 удаа зохион байгуулж 19 алба хаагч хамрагдлаа.

Энэ хугацаанд сургагч багшаар цагдаагийн дэд хурандаа Д.Уртбаяр, цагдаагийн дэд хурандаа Д.Баатар, цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн, цагдаагийн дэслэгч Ё.Шижиртуяа нар бэлтгэгдэж 5 алба хаагч 12 удаа 20 сэдвийг 782 алба хаагч нарт сургалтыг зохион байгуулж, 35 тест бодлогыг ажлуулсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлэх, шинээр батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилттэй танилцах, сургалтыг зохион байгуулах ажлын хэсэг Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газарт 5 хоногийн хугацаатайгаар ажиллаа.

Цагдаагийн Ерөнхий Газрын Хэрэг бүртгэх албаны дарга, цагдаагийн хурандаа А.Амгалангаар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт ажиллаж, тус аймгийн иргэдээс цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээтэй холбоотойгоор санал, хүсэлтийг хүлээн авч, аймгийн төр захиргааны байгууллага, хамтын ажиллагаатай байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийж тэдгээрийн санал хүсэлтийг сонсох арга хэмжээг зохион байгууллаа.

Мөн Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчдын мэргэшлийн түвшинг шалгаж үнэлж, алба хаагчдаас удирдлагын арга барилын талаар санал асуулгыг авч нэгтгэн дүгнэлээ. Алба хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдаж, 80.7 буюу “Сайн” үнэлгээтэйгээр амжилттай дүн үзүүллээ.

Эрх зүйн болон бусад мэдлэгийн шалгалтанд 127 алба хаагч хамрагдаж “А” буюу “Маш сайн” үнэлгээтэй 4 алба хаагч, “В” буюу “Сайн” үнэлгээтэй 15 алба хаагч, “С” буюу “Хангалттай” үнэлгээтэй 32 алба хаагч, “D” буюу “Дутагдалтай” үнэлгээтэй 39 алба хаагч, “F” буюу “Хангалтгүй” үнэлгээтэй 37 алба хаагч шалгагдлаа.

Бие бялдрын бэлтгэлжилтийн шалгалтанд 127 алба хаагч хамрагдаж “А” буюу “Маш сайн” үнэлгээтэй 49 алба хаагч, “В” буюу “Сайн” үнэлгээтэй 25 алба хаагч, “С” буюу “Хангалттай” үнэлгээтэй 17 алба хаагч, “D” буюу “Дутагдалтай” үнэлгээтэй 29 алба хаагч, “F” буюу “Хангалтгүй” үнэлгээтэй 7 алба хаагч шалгагдлаа.

Эзэмшсэн дадлага, чадварын шалгалтанд 127 алба хаагч хамрагдаж “А” буюу “Маш сайн” үнэлгээтэй 3 алба хаагч, “В” буюу “Сайн” үнэлгээтэй 29 алба хаагч, “С” буюу “Хангалттай” үнэлгээтэй 39 алба хаагч, “D” буюу “Дутагдалтай” үнэлгээтэй 45 алба хаагч, “F” буюу “Хангалтгүй” үнэлгээтэй 11 алба хаагч шалгагдлаа.

Мэргэжлийн түвшин тогтоох шалгалтанд дутагдалтай, хангалтгүй дүн үзүүлсэн, шалгалтанд хамрагдаагүй эрх зүйн болон бусад мэдлэгийн шалгалтанд 94 алба хаагч хамрагдаж “А” буюу “Маш сайн” үнэлгээтэй 4 алба хаагч, “В” буюу “Сайн” үнэлгээтэй 36 алба хаагч, “С” буюу “Хангалттай” үнэлгээтэй 52 алба хаагч, “D” буюу “Дутагдалтай” үнэлгээтэй 2 алба хаагч, “F” буюу “Хангалтгүй” үнэлгээтэй алба хаагч байхгүй.

Бие бялдрын бэлтгэлжилтийн шалгалтанд 58 алба хаагч хамрагдаж “А” буюу “Маш сайн” үнэлгээтэй 6 алба хаагч, “В” буюу “Сайн” үнэлгээтэй 8 алба хаагч, “С” буюу “Хангалттай” үнэлгээтэй 44 алба хаагч, “D” буюу “Дутагдалтай”, “F” буюу “Хангалтгүй” үнэлгээтэй алба хаагч байхгүй.

Эзэмшсэн дадлага, чадварын шалгалтанд 56 алба хаагч хамрагдаж “А” буюу “Маш сайн” үнэлгээтэй 6 алба хаагч, “В” буюу “Сайн” үнэлгээтэй 32 алба хаагч, “С” буюу “Хангалттай” үнэлгээтэй 18 алба хаагч, “D” буюу “Дутагдалтай” үнэлгээтэй, “F” буюу “Хангалтгүй” үнэлгээтэй алба хаагч байхгүй.

Төрийн албаны тухай хууль тогтоомжоор Цагдаагийн Ерөнхий Газрын Хуулийн хэлтсээс бэлтгэж ирүүлсэн сургалтын материалыг алба хаагч нарт танилцуулж сургалтын зохион байгуулж ажилласан.

Аймгийн Прокурорын газар, Сум дундын шүүхтэй хамтарч 1 цагийн сургалтыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарт зохион байгуулж ажилласан.

Орхон аймагт зохион байгуулагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдэвт хангайн бүсийн сургалт, зөвлөгөөнд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Ю.Одгэрэл, Хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Г.Хуншагай, цагдаагийн дэслэгч Б.Цэрмаа, Сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч Ё.Шижиртуяа, цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Т.Бөхболд нар оролцсон.

Орхон аймагт зохион байгуулагдсан “Замын тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт хангайн бүсийн аймгуудын зөвлөгөөнд цагдаагийн газрын дарга, замын цагдаагийн тасгийн дарга нар оролцож, мэдээлэл хийсэн.

Архангай аймаг дахь цагдаагийн газарт Эрүүгийн цагдаагийн албанаас зохион байгуулсан сургалтанд Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа Ж.Чинзориг, Эдийн засгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Нямдорж нар хамрагдсан.

Төрийн албаны тухай хууль тогтоомжоор Цагдаагийн Ерөнхий Газрын Хуулийн хэлтсээс бэлтгэж ирүүлсэн сургалтын материалыг алба хаагч нарт танилцуулж сургалтын зохион байгуулж ажилласан. Аймгийн Прокурорын газар, Сум дундын шүүхтэй хамтарч 1 цагийн сургалтыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарт зохион байгуулж ажилласан.

Аймгийн төрийн алба хаагчдын дунд зохион байгуулагдсан “Эх хэл-бидний бахархал 2018” үндэсний бичгийн олимпиадад оролцсон 49 багаас 10 дугаар байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн албаны үнэ цэнэ” сэдэвт Ардын их хурлын депутат ахмадууд, тэргүүний залуу төрийн алба хаагч нар оролцсон илтгэл, мэдээлэл хийх уулзалтанд цагдаагийн газрын 40 алба хаагчийг оролцуулсан.

Мөн аймгийн Засаг даргын санаачлагаар зохион байгуулсан “Алдар гавъяа-Амжилтын буухиа” сэдэвт арга хэмжээнд тус цагдаагийн газрын 20 алба хаагчийг оролцуулсан.

Төрийн соёрхолт, түүхийн ухааны доктор, түүхч Д.Өлзийбаатарын “Тусгаар тогтнолын үнэ цэнэ” лекцийг цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд уншиулсан.

Аймгийн Залуу төрийн алба хаагчдын клубын гишүүн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Д.Бямбадоржоор “Хувь хүний төлөвшил” сэдэвт сургалтыг 1 цагийн хугацаатайгаар хамт олонд зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн Ерөнхий Газрын дэд даргын “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 3/2861 дугаартай албан бичгийн дагуу дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Хууль сахиулахын их сургуульд суралцаж байгаа алба хаагчдаас ирүүлж байгаа хүсэлтийн дагуу алба хаагчдаас санал, асуулгыг авч нэгтгэн дүгнэж хүргүүлж хэвшсэн.

Цагдаагийн Ерөнхий Газрын, Хууль сахиулахын их сургуулийн захирлын хамтарсан дадлага хийлгэх тушаалын дагуу дадлагын удирдагчийг томилж, дадлагыг хийлгэж үр дүнг тооцож хэвшсэн.

Цагдаагийн газраар зочилж байгаа эрдэмтэн багш, сонсогчдыг байгууллагын “Алдарын танхим”-ыг сонирхуулах ажлыг зохион байгуулж хэвшсэн. Энэ хугацаанд тус сургуулийн 12 төлөөлөл, уг танхимыг үзэж сонирхсон.

Эрүүгийн цагдаагийн албаны Эрэн сурвалжлах хэлтсийн Эрүүгийн ахлах мөрдөгч Б.Чинбаатар цагдаагийн газрын алба хаагч нарт Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны А/262 дугаар тушаалаар батлагдсан “Эрэн сурвалжлах ажил /код 229/ журам”-аар 2 цагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.

Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр тус цагдаагийн газарт Цагдаагийн Ерөнхий Газрын урьдчилан сэргийлэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Батзориг, ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Цэнгэлбаяр нар 2 өдрийн 10 цагийн сургалтыг зохион байгуулсан.

-Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулагдсан сургалт уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд алба хаагчдыг хамруулсан байдал-

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн албаны үнэ цэнэ” сэдэвт Ардын их хурлын депутат ахмадууд, тэргүүний залуу төрийн алба хаагч нар оролцсон илтгэл, мэдээлэл хийх уулзалтанд цагдаагийн газрын 40 алба хаагчийг оролцуулсан.

Мөн аймгийн Засаг даргын санаачлагаар зохион байгуулсан “Алдар гавъяа-Амжилтын буухиа” сэдэвт арга хэмжээнд тус цагдаагийн газрын 20 алба хаагчийг оролцуулсан.

Төрийн соёрхолт, түүхийн ухааны доктор, түүхч Д.Өлзийбаатарын “Тусгаар тогтнолын үнэ цэнэ” лекцийг цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд уншиулсан.

Аймгийн Залуу төрийн алба хаагчдын клубын гишүүн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Д.Бямбадоржоор “Хувь хүний төлөвшил” сэдэвт сургалтыг 1 цагийн хугацаатайгаар хамт олонд зохион байгуулж ажилласан.

“Архигүй амгалан” хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 05 дугаар сарын 05-ны мөн сарын 12-ны өдрүүдэд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтарч Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчилан хамба лам Д.Чойжамц, мөн хийдийн гавж н.Нямсамбуу, н.Од, н.Баяраа нарыг урьж “Зөв амьдрахуй” сэдэвт цуврал лекцийг өдөрт 2 удаагийн давтамжтай төрийн болон төр захиргааны байгууллагуудын ажилтан алба хаагчид, иргэд олон нийтэд үнэ төлбөргүй хүргэсэн нь тэдний эрэлт, таашаалд нийцсэн арга хэмжээ болсон. Уг арга хэмжээнд 14528 алба хаагч иргэд хамрагдсан. Тус цагдаагийн газрын 62 алба хаагч сургалтанд хамрагдсан.

-Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил,
арга хэмжээ -

Цагдаагийн газрын хэмжээнд зохиогдох соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж цагдаагийн газрын даргын тушаалаар сургалтын төлөвлөгөөг батлуулж тасгууд өөрсдийн чиглэлээр, бие бүрэлдэхүүн нэгдсэн байдлаар явуулав.

Алба хаагчдад эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор биеийн тамир спортын уралдаан тэмцээний хуваарыг цагдаагийн газрын даргаар батлуулж энэ хугацаанд Цагдаагийн газрын аварга шалгаруулах Сагсан бөмбөг, гар бөмбөг, Ширээний теннис, шатар, дардас зэрэг 16 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулахаар төлөвлөж 12 төрлийн тэмцээнийг зохион байгуулж 1124 алба хаагч давхардсан тоогоор оролцсон.

Монгол цэргийн өдөр, Монгол Улсад шинэ цагийн зэвсэгт хүчин үүсч байгуулагдсны 97 жилийн ойг тохиолдуулан Хөвсгөл аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын олон төрөлд тэмцээн амжилттай зохион байгуулагдаж тэмцээний нийлбэр дүнгээр Цагдаагийн дэд хурандаа Ц.Адъяацэрэн даргатай Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн 25 оноогоор дэд байрт шалгарч “Өргөмжлөл” үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

Тэмцээний сагсан бөмбөгийн “Эрэгтэй” төрөлд Цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн ахлагчтай баг “Тэргүүн байр”, “Эмэгтэй” төрөлд цагдаагийн хошууч Ц.Тунгалагтэс ахлагч баг “Тэргүүн байр”, “Үндэсний шагайн харваа”-ны төрөлд Цагдаагийн ахлах ахлагч П.Нямдорж ахлагчтай баг “Дэд байр”, “Дартас”-ын төрөлд цагдаагийн дэд хурандаа Д.Буяндалай “Дэд байр”, “Хүчний гурван төрөлт”-ийн +75 кг-ийн жинд цагдаагийн ахлах дэслэгч Н.Гантулга “Дэд байр”, “Гар бөмбөг”-ийн “Эрэгтэй” төрөлд цагдаагийн ахлах дэслэгч Б.Түмэнбат ахлагчтай баг “Гутгаар” байр, “Ширээний теннис”-ийн “Эмэгтэй төрөлд Цагдаагийн ахмад О.Мөнхсайхан “Гутгаар” байр, “Модон моринд харайх” багийн төрөлд Цагдаагийн дэслэгч Э.Шагдарсүрэн, цагдаагийн дэслэгч Г.Хуншагай “Гутгаар” байрт тус тус шалгарч спортын өндөр амжилт гаргасан.

Цагдаагийн Ерөнхий Газрын “Хүч” спорт хорооны аварга шалгаруулах сагсан бөмбөгийн төрөлд цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэнгээр ахлуулсан баг тамирчид тэргүүн байр эзэлж алтан медаль хүртсэн.

Цагдаагийн газрын алба хаагчдын хүүхдүүдийн “Эх үрсийн баяр”-ын арга хэмжээг Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчид зохион байгуулж, оролцогчдын дунд азтан шалгаруулах сугалаа, унадаг дугуйн уралдааныг 3 насны ангилалаар, арга хэмжээ хэмжээнд оролцогчдоос хамгийн үзэсгэлэнтэй гүнж, ханхүүг шалгаруулах ажлыг зохион байгуулсан. 2018 оны хичээлийн жилийн шилдэг сурагчаар цагдаагийн дэд хурандаа Д.Баатарын хүү Б.Амгаланбаатар, Цагдаагийн ахмад М.Баттулгын хүү Б.Дөлгөөнмөрөн нар шалгарч “Уран дөш” зусланд амрах эрхийн бичгээр шагнагдсан.

“Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулж Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Манлайлагч гэр бүл”-ийн зөвлөгөөнд Эрүүлжүүлэх, саатуулах байрны жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Энхтөр, Мэдээлэл хүлээн авагч цагдаа, цагдаагийн ахлагч Г.Уранцэцэг нар оролцсон.

Хил хамгаалах ерөнхий газрын “Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга”-ын гоцлол дуучин Монгол Улсын гавъяат жүжигчин н.Ганчимэгийн уран бүтээлийн цэнгүүн, “Маш нууц 2” уран сайхны кино, Хилийн 0257 дугаар ангийн бие бүрэлдэхүүний тайлан тоглолт зэрэг уран бүтээлийн цэнгүүний үйл ажиллагааг цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн гэр бүлийн гишүүдийн хамт 15 удаа үзэж давхардсан тоогоор 1692 алба хаагч гэр бүлийн оролцсон сонирхсон байна.

Цагдаагийн газрын алба хаагч бүрийн илтгэх ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр өглөөний хоногийн мэдээллийн дараа алба хаагчид батлагдсан хуваарийн дагуу мэдээллийг хийж хэвшсэн. Уг арга хэмжээг 32 удаа зохион байгуулж 2240 алба хаагч хамрагдсан.

Монгол улсын гавъяат багш Д.Цогтоотой “Манлайлагч байх чадвар” сэдэвт ярилцлагыг, Цагдаагийн бэлтгэл хурандаа П.Мягмарсүрэнтэй “Удирдагч байхын зарчим” сэдэвт ярилцлагыг тус тус зохион байгуулж 232 алба хаагч давхардсан тоогоор оролцсон.

“Гэрч хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал”, “Сахилга храиуцлагыг сайжруулахад анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулж 162 алба хаагч оролцсон.

Архангай аймаг дахь цагдаагийн газарт болсон “Хангайн бүсийн цагдаагийн байгууллагын спортын наадам”-д цагдаагийн дэд хурандаа Д.Уртбаяраар ахлуулсан 30 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй баг тамирчид оролцсон.

“Сагсан бөмбөг”-ийн эрэгтэй төрөлд цагдаагийн ахлах дэслэгч Б.Эрдэнэдалай ахлагчтай баг дэд байрт шалгарч “Мөнгөн медаль”, эмэгтэй төрөлд цагдаагийн ахлагч Г.Уранцэцэг ахлагчтай баг дэд байрт шалгарч “Мөнгөн медаль”, тэмцээний шилдэг тамирчинаар цагдаагийн ахлагч Г.Уранцэцэг шалгарсан.

Хүчний 3 төрөлтийн 76 кг-ын жинд цагдаагийн ахлагч Х.Хишигдаваа таталтын төрөлд гутгаар байрт шалгарч “Хүрэл медаль”, -93 кг-ын жинд цагдаагийн дэд ахлагч А.Батбаатар таталтын төрөлд гутгаар байрт шалгарч “Хүрэл медаль”, шахалтын төрөлд тэргүүн байрт шалгарч “Алтан медаль”, нийлбэр дүнгээр гутгаар байрт шалгарч “Хүрэл медаль”, +93 кг-ын жинд цагдаагийн ахлах дэслэгч Н.Гантулга суултын төрөлт дэд байрт шалгарч “Мөнгөн медаль”, таталтын төрөлд тэргүүн байрт шалгарч “Алтан медаль”, шахалтын төрөлд тэргүүн байрт шалгарч “Алтан медаль”, нийлбэр дүнгээр тэргүүн байрт шалгарч “Алтан медаль”-иар тус тус шагнагдсан.

Цагдаагийн газрын албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд явган аялалыг Мөрөн сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Хийморийн овоо”-ны чиглэлд хийсэн.

Цагдаагийн Ерөнхий Газрын “Сүүж-Уул” нөхөн сэргээх амралтанд цагдаагийн дэд хурандаа Д.Буяндалайгаар ахлуулсан 10 алба хаагч 2 өндөр настны хамт 5 хоногийн хугацаатайгаар амраах ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн ахмад М.Баттулга, цагдаагийн дэд ахлагч Б.Балдан-Очир, цагдаагийн ахлагч Ц.Эрдэнэбаяр нар “Уран зохицуулагч-2018” тэмцээнд оролцсон. Өмгөөллийн байгууллагын 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан гар бөмбөгийн тэмцээнд баг тамирчид амжилттай оролцож дэд байрт шалгарсан. Хүүхэд гэр бүл, хүүхэд залуучуудын газраас зохион байгуулсан “Бид хоймор нутгийн залуус” спортын арга хэмжээний сагсан бөмбөгийн тэмцээнд дэд байр, ширээний теннисний эмэгтэй төрөлд Мэдээлэл хүлээн авагч цагдаа, цагдаагийн ахлагч Г.Уранцэцэг дэд байр, хөлбөмбөгийн төрөлд гутгаар байрт шалгарч багийн дүнгээр тэргүүн байрт шалгарч цом, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан. “Шилдэг мөрдөгч” цогцолбор тэмцээнд мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Даваацэрэн оролцсон.

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас алба хаагчдын сургалт, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Намар-Эрүүл цагдаа” арга хэмжээг Бүрэнтогтох сумын Туяа багийн нутаг дэвсгэрт 2018 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд алба хаагчдын гэр бүлийн гишүүд оролцсон. Оролцогчид Цагдаагийн газраас Бүрэнтогтох сумын Туяа багийн нутаг дэвсгэрт байрлах “Оросын тосгон”-ны чиглэлд дугуй аялалыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд алба хаагчид 2018 онд зохион байгуулагдах спортын уралдаанд тэмцээнд оролцохоор хуваагдсан 6 багийн тамирчид “Олс таталт”, “Буухиа” “Гир өргөлт”, “Дугуйн уралдаан”, “Сумо бөх” зэрэг 5 төрлийн өрсөлдөж дүнгээ гаргалаа. Арга хэмжээнд оролцсон алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд өөрсдийн бэлтгэж ирсэн хоол хүнсний зүйлээр үдийн зоог идэж, чөлөөт цагаа боловсон өнгөрүүлээ. Тэмцээний нийлбэр дүнгээр Цагдаагийн ахлах ахлагч Ц.Эрдэнэбат ахлагчтай дүгээр баг 14 оноогоор тэргүүн байр, Цагдаагийн ахмад Б.Алтанцог ахлагчтай 1 дүгээр баг 20 оноогоор дэд байр, Цагдаагийн дэслэгч С.Бат ахлагчтай 3 дугаар баг 24 оноогоор гутгаар байрыг тус тус эзэлсэн амжилтыг үзүүлсэн.

Цагдаагийн Ерөнхий Газрын “Хүч” спорт хорооны аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээний эмэгтэй төрөлд цагдаагийн ахлах ахлагч Г.Уранцэцэг ахлагчтай баг тамирчид дэд байрт шалгарч “Өргөмжлөл” мөнгөн медалиар шагнагдсан.

-Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран
ажилласан байдал-

“Мөрөөдлийн мөрөн-101,5” FM радиотай хамтран хулгайлах гэмт хэрэг, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн сэрэмжлүүлгийг өдөр бүр байнгын давтамжтайгаар, орон нутгийн “Хөвсгөл”, “ЛХА” “Мөрөн”, телевизүүдээр тодорхой төрлийн /орон байр, мотоцикль, мал хулгайлах, архи тамхины хор уршиг, учрал золгүй байдал, согтуугаар гэмт хэрэгт өртөж амь нас эрүүл мэндээрээ хохирох,

гол усны үерийн аюул, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болон тухайн цаг үе, үйл явдалтай холбогдуулан сэрэмжлүүлэг яриа, мэдээ мэдээллийг 302 удаа /давхардсан тоогоор 395 удаа/ иргэд олон нийтэд хүргэж ажиллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 удаагийн телевизийн нэвтрүүлэг, 46 мэдээлэл, 4 ярилцлага, сонинд 2 ярилцлага, 24 мэдээлэл, 1 нийтлэл, мэдээллийн сайтад ярилцлага 1, мэдээ 24, 1 нийтлэл, радиод 12 ярилцлага, 24 мэдээ, 6 нэвтрүүлэгийг явуулж иргэдэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

-Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн-

Тус Цагдаагийн газар 2018 онд Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх” журам /код 109.6/ дахь заалтын дагуу Монгол улсын Авлигын тухай хууль, “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих Цагдаагийн байгууллагын зөвлөлийн өгсөн үүрэг, жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах салбар зөвлөлийг газрын даргаар ахлуулан 7 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж 4 бүлэг, 19 хэсэг, 48 заалт бүхий заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж тогтоосон хугацаанд биелэлт үр дүнг тооцон хяналт шинжилгээ хийж ажилласан. Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн гишүүд хамт олноо төлөөлөн авилгаас ангид байх, шудрага ёсыг эрхэмлэн авилгатай тууштай тэмцэж ажиллахаа газрын нийт бие бүрэлдэхүүний өмнө илэрхийлж баталгаа гаргаж баталгаажуулж ажилласан. Авлигад өртөж болзошгүй алба хаагчдын судалгааг 4 төрлөөр гаргасан. Цагдаагийн газрын алба хаагчдыг авилгал хээл хахуулиас ангид байлгах, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай, харилцааны өндөр соёлтой үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор газрын иргэдийн хүлээлгийн өрөөнд “Санал хүсэлтийн дэвтэр”, “Санал авах хайрцаг”, цагдаагийн алба хаагчийн хүнд суртал, авилгал хээль хахуулийн талаарх мэдээллийг хүлээн авах 126 утасны дугаар бүхий зурагт хуудас зэргийг иргэдийн нүдэнд харагдахуйц газарт байрлууллаа. Энэ хугацаанд алба хаагчийн хууль бус үйлдэл авлига хүнд суртлын талаарх санал хүсэлт гомдол уг хайрцаганд ирээгүй.

“ХАСХОМ”-ийн цахим санд тус цагдаагийн газрын 76 алба хаагчийн холбогдох материалыг хугацаанд нь оруулж ажилласан. Мөн энэ хугацаанд шинээр томилогдсон 2 алба хаагчийн “ХАСХОМ”-ийн цахим санд оруулсан. Хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагч одоогоор байхгүй.

Мөн энэ хугацаанд шинээр томилогдсон 31 алба хаагчийн “ХАСХОМ”-ийн цахим санд оруулсан. Тайлангийн хугацаанд тус цагдаагийн газрын алба хаагчдаас 22 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэгийг Авилгатай тэмцэх газраар хянуулахаар холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, ухуулга сурталчилгааны материалыг албан хаагч нарын өрөө, иргэдийг хүлээн авах танхим, коридоруудад байршуулсан. Яриа таниулга, уулзалт, өдөрлөг зохион байгуулахдаа иргэдэд тарааж үйлчилсэн байна. Цагдаагийн газрын удирдлага нь алба хаагч бүрт бүр авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон, тохиолдолд бүрийг холбогдох албан тушаалтанд заавал илтгэж танилцуулдаг байхыг үүрэг болгож өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд алба хаагч нарт авилгал өгсөн, өгөхөөр завдсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

2018 онд Цагдаагийн газрын алба хаагчид болон байгууллагаас бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хандив авсан тохиолдол байхгүй.

Тайлангийн хугацаанд тус цагдаагийн газрын алба хаагчдаас 4 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэгийг Авилгатай тэмцэх газраар хянуулахаар холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Авилгатай тэмцэх газар, Цагдаагийн Ерөнхий Газрын 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг алба хаагч нарт танилцуулж хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй цагдаагийн газрын ажлын байр, албан тушаалыг тодорхойлох судалгааны ажлын дүгнэлтийг цагдаагийн газрын алба хаагч нарт сургалтын үеэр танилцуулж ажилласан.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, анхаарах асуудлаар Цагдаагийн газрын алба хаагчдын дунд сургалтыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Уртбаяр 4 удаа 8 цагийн хугацаатайгаар зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн цахим хуудасны авилгын эсрэг үйл ажиллагааны хэсэгт “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Авилгын эсрэг хууль”, “Авилгын шалтгаан хор хөнөөл”, “Авилга хээл хахууль, хүн сурталын талаар мэдээлэл авах утас” сэдэвт ухуулга сурталчилгааны материалыг байршуулж иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдаас албан үүрэг гүйцэтгэж байхдаа иргэн, хуулийн этгээдээс бэлэг хандив санхүүгийн туслалцаа авах асуудлаар хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн алба хаагч байхгүй.

Цагдаагийн Ерөнхий Газрын 2018 Авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 94.9 буюу 4.75 үнэлгээгээр үнэлж дүгнэж Цагдаагийн Ерөнхий Газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

-Байгууллагын санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар
хийсэн ажил, арга хэмжээ-

Санхүү аж ахуйн чиглэлээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хөтлөгдвөл зохих анхан шатны бүртгэл маягтуудыг хөтлөн НББОУС-г мөрдөн, Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд дэвшүүлсэн зорилтод ажлын хүрээнд сар, улирал, жилээр төлөвлөгөө гарган ажлаа дүгнэн цагдаагийн газрын санхүү, аж ахуйн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Санхүү аж ахуйн чиглэлээр алба хаагчдын тав тухтай орчинд ажиллах орчинг бүрдүүлэх, цагдаагийн газрын гадаад дотоод орчныг засварлах, сүүлийн үеийн дэвшилтэд техник хэрэгслээр хангах чиглэлээр бодлого боловсруулан ажилласан бөгөөд Тус цагдаагийн газар нь 2018 оны 11 дүгээр сарын байдлаар урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1.700.809.900 төгрөг, цалинд 1.680.162.327 төгрөг, НДШ-д 29.495.652 төгрөг, гэрэл цахилгааны зардалд 8.509.486 төгрөг, түлш халаалтын зардалд 27.276.851 төгрөг, цэвэр бохир усны зардалд 4.751.296 хоолны зардалд 17.780.772 төгрөг, бичиг хэргийн зардалд 17.172.500 төгрөг, тээвэр шатахууны зардалд 89.063.314 төгрөг, шуудан холбооны зардалд 6.304.064 төгрөг, томилолтын зардал 17.678.400 төгрөг, эд хогшил худалдан авах 11.161.510 төгрөг, урсгал засварын зардалд 11.161.510 төгрөгийг тус тус зарцуулж ажилласан. 2019 оны төсвийн төсөлд тооцооллыг хийн хүргүүлж иргэдийг хүлээн авах танхимд мэдээллийн самбарыг байрлуулж иргэдэд ил тодоор мэдээллийг хүргүүлж байна. 2019 оны төсвийн төсөлд тооцооллыг хийн хүргүүлж иргэдийг хүлээн авах танхимд мэдээллийн самбарыг байрлуулж иргэдэд ил тодоор мэдээллийг хүргүүлж байна.

2019 оны төсвийн төсөлд тооцооллыг хийн хүргүүлж иргэдийг хүлээн авах танхимд мэдээллийн самбарыг байрлуулж иргэдэд ил тодоор мэдээллийг хүргүүлж байна.

-Шилэн дансны ил тод байдлыг хангах чиглэлээр зохион
байгуулсан ажил, арга хэмжээ-

Тус цагдаагийн газар нь 2018 онд 140.476.500 төгрөгийн түлш шатах тослох материал худалдан авах, 14.600.000 төгрөгний 24 цагаар ажилладаг 8 алба хаагчдад өдөр бүр олгох 5000 төгрөгний үнэ бүхий халуун хоол цайгаар үйлчлэх, 6.600.000 төгрөгний захиргааны журмаар баривчлагдсан хүмүүсийн хоолны материал худалдан авах нийт 21.200.000 төгрөгний хоолны зардлын багцын тендер, 22.000.000 төгрөгний барилгын материал болон машины сэлбэг худалдан авах багцын тендерүүдийг Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газраар зарлуулсан. Түлш шатах тослох материал худалдан авах тендерт НИК ХХК хөвсгөл салбар 143.379.700 төгрөгийн үнийн санал, “Магнай трейд” ХХК 141.477.750 төгрөгний үнийн саналтай, “Сод Монгол” ХХК 134.281.565 төгрөгний үнийн саналтайгаар оролцсон. Сод монгол ХХК захиалагчийн ирүүлсэн тоо хэмжээнээс А-80 1095 литр, дизель түлш 594 литр, АИ-92

200 литр хассан нь ТӨОЗ-ын 7.3-д заасан захиалагчийн техникийн тодорхойлолт хангаагүй, Магнай трейд ХХК нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлээгүй нь ТӨОЗ-ын 18.1 /б/ хангаагүй нь тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27-р зүйлийн 27.1.2 дахь заалтын дагуу дээрх захиалагчийн тендерээс татгалзах үндэслэл боллоо. “НИК” ХХК-ын ирүүлсэн тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтыг үндэслэн хэлэлцээр хийж, дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтуудыг хангаж байгаа үндэслэлээр тендерт шалгарсан ба 2018.04.01-ны өдрөөр гэрээ хийн тус цагдаагийн газарт түлш, шатах тослох материалыг цаг тухай бүрт нийлүүлэн ажиллаж байна. Дараа оны тендер зарлах хүртэл гэрээг хийсэн ба гэрээ дууссны дараа гэрээг дүгнэх болно. Хоолны багцад “Тамирбулаг” ХХК 14.600.000 төгрөгөөр, Хүнс мах махан бүтээгдэхүүн худалдан авах багцад “Жанст ундрам” ХХК 6.408.050 төгрөгөөр, барилгын засварын материалын багцад “Уу жалга” ХХК 9.900.000 төгрөгөөр нийлүүлэх санал ирүүлэн оролцож, хуулийн 28.7.4-ийг хангаж байгаа тул тендерт шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Автомашины сэлбэг нийлүүлэх тендерт аж ахуйн нэгж санал ирүүлэн оролцоогүй учир дахин зарлаж, “БУМНЗ ХХК” 12.000.000 төгрөгөөр нийлүүлэх санал ирүүлэн хуулийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гэрээ байгуулан ажиллаж байна.

2018 оны эхний 11 сарын байдлаар шилэн дансны цахим системд 95 мэдээлэл оруулах ёстойгоос 93 мэдээллийг хугацаанд нь оруулж, хугацаа хоцроосон мэдээлсэн 2 мэдээлэл байна. Сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон орон тоонд орсон өөрчлөлт, батлагдсан төсөвт орсон өөрчлөлт, төсвийн зарлагын хэтрэлт, хэмнэлтийн тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ зэргийг хавсаргах файлын хамт цаг тухай бүрт нь цахим санд шивсэн. 5 саяаас дээш төгрөгний цалингийн зардлаас бусад орлогын 11 гүйлгээ 1.824.717.000 төгрөг, зарлагын 25 гүйлгээ 337.433.146 төгрөг, 5 саяаас дээш төгрөгний үнийн дүн бүхий бараа ажил үйлчилгээ худалдан авсан гэрээний санхүүжилт өссөн дүнгээр 11 байгууллага руу шилжсэн 89.757.695 төгрөгний гүйлгээг тухай бүрт цахим системд байршуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу тендер шалгаруулалтанд оролцож, гэрээ байгуулсан 5 аж ахуйн нэгжийн гэрээг PDF файл хэлбэрээр байршуулсан. Мөн цагдаагийн байгууллагын мэдээллийн самбарт сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, улирлын тайлангууд зэргийг мэдээлж хэвшсэн.

-Алба хаагчдын ажиллах нөхцөл байдал, нийгмийн асуудлыг
дээшлүүлэх чиглэлээр-

Цагдаагийн газрын алба хаагчдаас нэн ядуу амьдралтай 22 алба хаагч байна. Цагдаагийн газарт өрх толгойлсон 2 эмэгтэй алба хаагч байна. Одоогийн байдлаар цагдаагийн газрын алба хаагчдаас 8 алба хаагч өөрийн гэсэн орон гэргүй түрээсийн байранд амьдарч байна.

Цагдаагийн газарт өрх толгойлсон 3, олон хүүхэдтэй 5, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 27 алба хаагчийг судалгааг гаргаж ажилласан. Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өрх толгойлсон 4 эмэгтэй алба хаагчид тус бүрт 500.000 төгрөгний буцалтгүй тусламжийг Аймгийн Засаг даргаас олгуулах ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн газрын алба хаагч нарт орон сууц бариулах чиглэлээр холбогдох газарт судалгааг хүргүүлж 40 алба хаагчийн хүсэлтийг хүлээн авсан. Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах байраар ашиглаж байсан газрын зориултыг өөрчилүүлж алба хаагчдын орон сууцыг барих талаар Аймгийн Засаг даргад хүсэлтээ хүргүүлж газрын асуудлыг шийдвэрлүүлж барилгыг улсын комисс хүлээн авсан.

Тус цагдаагийн газраас орон сууцны хөнгөлөлттэй зээлд 8 алба хаагчийг хамруулсан.

Монгол улсын засгийн газрын 2014 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн алба хаагчдад мөнгөн урамшил олгох журам”-ын 2 дахь хэсэг, “Цагдаагийн алба хаагч аймгийн төвөөс бусад нэг буюу хэд хэдэн суманд тасралтгүй

60 сар ажилласан бол таван жил тутамд нэг удаа мөнгөн урамшил олгоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж тус цагдаагийн газрын Шинэ-Идэр сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Идэрцэнгэл, Ханх сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Мөнхтулга, Эрдэнэбулган сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Түвшинжаргал, Чандмань-Өндөр сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Л.Батпүрэв, Рашаант сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Ц.Батсүх, Тосонцэнгэл сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Л.Тод-Эрдэнэ, Хатгал тосгоны цагдаагийн тасгийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Олзвой, Цэцэрлэг сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Х.Хишигдаваа, Улаан-Уул сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Ч.Мөнх-Очир, Жаргалант сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Д.Энхтүвшин, Тосонцэнгэл сумын Замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч Б.Түмэнбат нарт мөнгөн урамшуулал олгуулсан.

-Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ-

Цагдаагийн газрын 144 алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрагдсан алба хаагчдаас 8 алба хаагч цаашид нарийн мэргэжлийн шинжилгээнд хамрагдах шаардлагатай. Үзлэгээр 4 алба хаагчид эмчилгээ, сувилгаа хийлгэсэн. Нарийн шинжилгээнд хамруулах шаардлагатай алба хаагчдаас 12 алба хаагчийг элэгний биохимийн, зүрх судасны шинжилгээнд 3, хурууны рентген зураг авахуулах алба хаагч 1 байсныг шинжилгээ оношлогоонд хамруулсан. Цагдаагийн газрын нийт 142 алба хаагчдын эрүүл мэндийн судалгааг гаргаж 94 алба хаагчид томуугийн В хүрээний урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан.

“Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарч цагдаагийн алба хаагч, ажилтнуудад ажлын байрны осол гэмтэлд өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Б.Саранчимэгээр 1 цагийн сургалтыг зохион байгуулж, сүүлийн 3 жилийн байдлаарх алба хаагчдын өвчлөлийн талаарх судалгааг гаргасан. Засгийн газрын 2015 оны 259 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу цагдаагийн газрын даргын тушаалаар 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй орон тооны бус байнгын комиссыг томилж ажлуулж байна. Энэ хугацаанд орон тооны бус байнгын комиссоос гаргасан шийдвэр байхгүй.

Алба хаагчдаас 20 алба хаагчид малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцинд хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоод цэргийн командлагчийн 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/135 дугаар тушаалаар баталсан “Эрүүл цагдаа” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулж, биелэлтийг хангуулах чиглэлээр ажиллаж байна.

Хөтөлбөрийн нээлтийг орон нутаг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газарт 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрүүдэд ажилласан.

Арга хэмжээний хүрээнд Цагдаагийн Ерөнхий газрын “Хүч” спорт хорооны биеийн тамир, эмчилгээний арга зүйч, цагдаагийн ахмад Б.Даваасамбуу, “Сүүж-Уул амралт, сэргээн засах сувилал”-ын уламжлалт анагаах ухааны эмч, цагдаагийн дэслэгч Н.Ариунтуяа, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн сэтгэл зүйч, дэслэгч О.Сангачамаа нар цагдаагий алба хаагч, ажилчдад “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, эрүүл мэндийн сургалт зохион байгуулсан.

Цагдаагийн Ерөнхий Газраас алба хаагчдын мэргэжлийн түвшинг тогтоож байгаатай холбогдуулж 136 алба хаагчийг эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулсан.

Цагдаагийн Ерөнхий газрын тушаалаар хэрэгжиж буй “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хүрээнд тус Цагдаагийн газрын сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч Ё.Шижиртуяа Нэгдсэн эмнэлэгийн мэдрэлийн тасгийн эрхлэгч Ч.Батхишигтэй хамтран алба хаагчдад 4 төрлийн үзлэг, оношилгоо хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Тус үзлэгт Цагдаагийн газрын 85 алба хаагч хамрагдсан. Алба хаагчдад түгээмэл тохиолдож байгаа зовиур нь зүрх дэлсэх, цусны даралт ихсэх, нойрны өөрчлөлт, 10

алба хаагчийн стрессийн түвшин ихсэх хандлагатай буюу дунджаас дээш стрессийн үзүүлэлттэй гарсныг цагдаагийн газрын даргад танилцуулж ажлын чиглэл авч ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын ахлагчийн зөвлөлөөс санаачилж алба хаагчдыг “Витаминжуулалтын аян”-г зохион байгуулж 60 литр аарц, 40 литр халуун шүүсээр үйлчилгээ үзүүлж давхардсан тоогоор 2760 алба хаагч хамрагдсан.

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас алба хаагчдын сургалт, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Намар-Эрүүл цагдаа” арга хэмжээг Бүрэнтогтох сумын Туяа багийн нутаг дэвсгэрт 2018 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд алба хаагчдын гэр бүлийн гишүүд оролцсон. Оролцогчид Цагдаагийн газраас Бүрэнтогтох сумын Туяа багийн нутаг дэвсгэрт байрлах “Оросын тосгон”-ны чиглэлд дугуй аялалыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд алба хаагчид 2018 онд зохион байгуулагдах спортын уралдаанд тэмцээнд оролцохоор хуваагдсан 6 багийн тамирчид “Олс таталт”, “Буухиа” “Гир өргөлт”, “Дугуйн уралдаан”, “Сумо бөх” зэрэг 5 төрлийн өрсөлдөж дүнгээ гаргалаа. Арга хэмжээнд оролцсон алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд өөрсдийн бэлтгэж ирсэн хоол хүнсний зүйлээр үдийн зоог идэж, чөлөөт цагаа боловсон өнгөрүүлээ. Тэмцээний нийлбэр дүнгээр Цагдаагийн ахлах ахлагч Ц.Эрдэнэбат ахлагчтай дүгээр баг 14 оноогоор тэргүүн байр, Цагдаагийн ахмад Б.Алтанцог ахлагчтай 1 дүгээр баг 20 оноогоор дэд байр, Цагдаагийн дэслэгч С.Бат ахлагчтай 3 дугаар баг 24 оноогоор гутгаар байрыг тус тус эзэлсэн амжилтыг үзүүлсэн

-Сэтгэл зүйчийн ажлын талаар-

Цагдаагийн газрын алба хаагчдын түгшүүр, стрессийн түвшинг тогтоож, түүний шалтгаан нөхцөлийг илрүүлэх, бие хүний сэтгэл зүйн онцлогт тохирсон арга, аргачлалаар сэтгэл зүйн тусламж үзүүлэх, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагдад зөрчил гаргахад нөлөөлж буй сэтгэл зүйн хүчин зүйлсийг тогтоох зорилгоор сар бүр алба хаагчдаас стресс, түгшүүрийн сорил авч боловсруулан үр дүнг Цагдаагийн газрын даргад танилцуулан ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Үйл ажиллагааны судалгаа, хэтийн төлөвлөгөө боловсруулах /код 107/ журам”-ын 107.3.3, “Цагдаагийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /код 110.4/-д заасны дагуу 500 иргэнээс санал асуулга авч “Хэрэглэгчийн үнэлгээний тайлан”-г Цагдаагийн Ерөнхий газрын Дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн газрын 80 алба хаагчаас ажиллах орчин, сургалтын чанар, удирдлагын үйл ажиллагааны талаар санал асуулга авч нэгтгэн, алба хаагчдаас гарсан саналыг Цагдаагийн газрын даргад танилцуулж, Цагдаагийн Ерөнхий газрын Дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэв.

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн албадан сургалт”-ыг тус Цагдаагийн газрын албадан саатуулах байранд саатуулагдсан 10 иргэнд 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 01 дүгээр сарын 12-ны өдрийн хугацаанд зохион байгуулж, сургалтын тайлан, үр дүнг Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэст хүргүүлж ажиллаа.

Цагдаагийн Ерөнхий газраас ирүүлсэн хуудсын дагуу 59 алба хаагчаас байгууллагын үйл ажиллагаа, удирдлагын арга барил, зорилтыг хэрэгжүүлж буй байдлыг үнэлэх санал асуулгыг авч нэгтгэн хүргүүлсэн.

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн албадан сургалт”-ыг тус Цагдаагийн газрын албадан саатуулах байранд саатуулагдсан иргэдэд 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулж нийт 245 иргэдэд сургалтыг зохион байгуулж байна.

Цагдаагийн байгууллагад ажиллах хүсэлт гаргасан 5 иргэнтэй уулзаж ярилцлага хийн тэмдэглэл үйлдэж Цагдаагийн Ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэв.

Сар бүр сахилга, ёс зүйн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаар орох алба хаагчдын нэрсийг хуралд танилцуулан, тэмдэглэл хөтөлж, нийт алба хаагчдад Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дугаар зүйл “Цагдаагийн алба хаагчид хориглох зүйл”-ийг танилцуулах баталгааны хуудас танилцуулж ажиллаа.

Шинээр томилогдсон алба хаагчдыг “Дасан зохицуулах ажлын төлөвлөгөө” –г боловсруулж, 14 алба хаагчдаас бие хүний сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох EPI болон MBTI, стрессийн түвшин тогтоох сорил авч, сэтгэл зүйн карт нээж, нийт алба хаагчдын сэтгэл зүйн картанд баяжилт хийж, 6 алба хаагчид ганцаарчилсан, үе шаттай сэтгэл зүйн зөвлөгөө өгч, гэмт хэргийн гэрч хохирогч болсон насанд хүрээгүй 3 хүүхэд, 3 иргэнд сэтгэл зүйн дүгнэлт гаргаж ажиллаа.

2017 оны Сахилгын дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаж, алба хаагчид болон тэдний гэр бүлтэй уулзаж, зөрчил гаргасан шалтгааны талаар илтгэх хуудас болон зөрчил гаргаж болзошгүй алба хаагчдын талаар судалгаа гаргаж Цагдаагийн газрын даргад танилцуулж ажиллаа.

Цагдаагийн газрын 21 алба хаагчаас Хууль сахиулах их сургуулийн төгсөгчдийг үнэлэх санал асуулгын дагуу авч нэгтгэн алба хаагчдаас гарсан саналыг Цагдаагийн газрын даргад танилцуулж, Цагдаагийн Ерөнхий газрын Дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэв.

2017 оны албаны шалгалт хийгдсэн алба хаагчдын сэтгэл зүйн тодорхойлолт хийж, 9 албаны шалгалтын материалд тэмдэглэл хийж, 2018 онд албаны шалгалт хийгдсэн болон зөрчил гаргасан 37 алба хаагчийн сэтгэл зүйчийн дүгнэлт, тэмдэглэл хийн, мөрдөн байцаалтанд хохирогчоор татагдсан насанд хүрээгүй 1 хүүхдэд сэтгэл зүйн дүгнэлт хийн ажиллаа.

Сахилга, ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэх материал бэлтгэж, сахилга ёс зүйн зөвлөлийн ажиллах журамд оруулах саналыг гишүүдээс авч нэгтгэн журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Тасаг бүрийн алба хаагчдын сэтгэл зүйн байдлын талаар, удирдах алба хаагчдын алба хаагчидтай анхаарах асуудлын талаар танилцуулга бичиж тасгийн дарга нарт өгч ажиллаа.

Замын цагдаагийн тасгийн алба хаагчдын сэтгэл зүйн картад баяжилт хийж, алба хаагч бүрийн сэтгэл зүйн тодорхойлолт, сэтгэцийн байдлын талаарх судалгааг тасгийн даргад гаргаж өгсөн.

Шинээр томилогдсон 3 алба хаагчдаас бие хүний сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох EPI болон MBTI, стрессийн түвшин тогтоох сорил авч Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх /код 938/ журам”-д заасны дагуу сэтгэл зүйн карт нээж, нийт алба хаагчдын сэтгэл зүйн картанд баяжилт хийсэн.

Цагдаагийн газрын 1 дүгээр улирлын нэгдсэн сургалт, зөвлөгөөний үеэр хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт тараах материал тарааж, “Гэр бүлийн мод” сэтгэл зүйн тест ажиллуулж, Хэсгийн мөрдөгч нарын цугларалтаар алба хаагчдын сэтгэл зүйн тодорхойлолтыг гарган таницуулж, Леонгардын зан төлвийн хурцдалыг оношилох асуулга болон стрессийн түвшин тогтоох сорил авч нэгтгэлээ.

Захиргааны удирдлагын тасаг болон Мөрдөн байцаах тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдад “Байгууллагын соёлыг төлөвшүүлэх нь” сэдэвт хичээлийг тус бүр зохион байгуулж, алба хаагчдаас депрессийн болон хамт олны нягтралыг тодорхойлох сорилууд авч нэгтгэлээ.

Сургалтын төлөвлөгөөний дагуу “Байгууллагын соёлыг төлөвшүүлэх нь”, “Цагдаагийн алба хаагчдад тулгамдаж буй сэтгэл зүйн асуудал” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, тараах материал 280 ширхэг сургалтын материал, сэтгэл зүйн зөвлөмж хэвлэж тараан үр дүнг Цагдаагийн газрын даргад танилцуулан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, ажлын чиглэл авлаа.

Алба хаагчдын сахилгын ёс зүйн зөрчлийг бууруулах чиглэлээр “Сахилга хариуцлага дээшлүүлье” аяны үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж дүнг сар тутамд гаргаж цагдаагийн газрын даргад танилцуулж, хяналтын самбарыг баяжуулсан.

4 алба хаагчаас бие хүний сэтгэл зүйн онцлогийг сорил авч, сэтгэл зүйн карт нээж, 35 алба хаагчид зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.

Цагдаа танд баярлалаа” сарын аяныг зохион байгуулж, Төрийн тусгай албаны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан 10 иргэнээс EPI, сэтгэн бодох чадвар, сэтгэлгээний хурд тодорхойлох сорилууд авч, дүгнэлт бичин Цагдаагийн Ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвд хүргүүлээ.

Сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч Ё.Шижиртуяа 244 алба хаагчид 15 минутаар нийт 3660 минут алжаал тайлж, булчин суллах массажны сандлаар үйлчилсэн.

Алба хаагчид хоорондын эерэг харилцааг дээшлүүлэх чиглэлээр “Хамт олон дахь бага бүлгийн харилцаа” сэдэвт сургалтыг 5 тасгийн алба хаагчдад зохион байгуулж, бүлгийн уур амьсгал, эв нэгдлийг тандах “Бүлгийн сэдэлжүүлэлтийн түвшин” тогтоох сорил авч боловсруулан, хамт олны дунд эерэг харилцааг дээшлүүлэх чиглэлээр “Халуун сандал” бүлгийн тоглоом, “Цагдаа танд баярлалаа” аяныг тус тус зохион байгуулсан.

-Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр
зохион байгуулсан ажил, арга хэмжээ-

Тус цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нар 7 хоногоор ажлаа төлөвлөж хэвшсэн. 7 хоногт хийсэн ажлын тайланг Даваа гараг бүрийн 10 цагт, тухайн хугацаанд өгсөн ажлын чиглэл, үүрэг даалгаврын хамт тооцож хэвшсэн.

Цагдаагийн газрын даргаас тасаг, хэсгийн дарга, алба хаагч нарт ажил сайжруулах зааварчлага 22-ыг бичиж, биелэлт үр дүнг тооцсон.

2018 оны цагдаагийн газрын даргаас тасгийн дарга нар болон алба хаагч нарт ажлын чиглэл, ажил сайжруулах чиглэлээр 588 үүргийг өгч биелэлт үр дүнг тухай бүрт нь тооцсон байна. Үүргийг хэрэгжүүлээгүй биелүүлээгүй алба хаагч байхгүй байна. Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний дагуу цагдаагийн газрын тасгуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 8 зааварчлага, 1 зөвлөмжийг бичиж биелэлт үр дүнг тооцсон. Ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажлаагүй тасгийн даргаар ажиллаж байгаа 24 алба хаагчийг цалинг 5-20 хувиар бууруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж ажиллаж байгаа 18 тасгийн даргын цалинг 5-20 хувиар нэмэгдүүлж олгосон. Үүргийг хэрэгжүүлээгүй биелүүлээгүй алба хаагч байхгүй байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангах чиглэлээр цагдаагийн газрын эд мөрийн баримтын өрөөг завсарлах ажлыг өөрсдийн нөөц боломжийг ашиглаж хийж дуусгаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлэх, шинээр батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилттэй танилцах, сургалтыг зохион байгуулах ажлын хэсэг Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газарт 5 хоногийн хугацаатайгаар ажилласан.

Цагдаагийн Ерөнхий Газрын Хэрэг бүртгэх албаны дарга, цагдаагийн хурандаа А.Амгалангаар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт ажиллаж, тус аймгийн иргэдээс цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээтэй холбоотойгоор санал, хүсэлтийг хүлээн авч, аймгийн төр захиргааны байгууллага, хамтын ажиллагаатай байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийж тэдгээрийн санал хүсэлтийг сонсох арга хэмжээг зохион байгуулсан.

Мөн Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчдын мэргэшлийн түвшинг шалгаж үнэлж, алба хаагчдаас удирдлагын арга барилын талаар санал асуулгыг авч нэгтгэн дүгнэсэн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрүүдэд “Галт санаачлага-2018” арга хэмжээнд Аймгийн 24 сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан орон нутагтаа санаачлагатай, ажиллаж байгаа Цэцэрлэг, Чандмань-Өндөр сумдын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл”-ийн ажлын туршлагыг сурталчлах ажлыг зохион байгуулж салбар зөвлөл тус бүрийг “Хүндэт өргөмжлөл” 200.000 төгрөгөөр тус тус шагнаж урамшууллаа. Арга хэмжээний явцыг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж, цахим хаягт байршуулж, иргэдэд сурталжлах ажлыг зохион байгууллаа.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр орон нутгийн төр захиргааны байгууллагын удирдлагад ажил, нөхцөл байдлын талаар танилцуулгыг тухай бүрт хүргүүлж ажиллаж байна. Гаргасан санал, хүсэлтийн дагуу Аймгийн Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Арбулаг,

Бүрэнтогтох, Галт, Цэцэрлэг, Цагааннуур, Түнэл, Төмөрбулаг, Шинэ-Идэр сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт 8 ширхэг мотоцикль, Замын цагдаагийн тасагт хөдөлгөөнт эргүүлийн приус 20 маркын бүрэн тоногдсон тээврийн хэрэгсэл 2, зөөврийн компьютер 1, Ханх сум дахь хэсгийн төлөөлөгчийг торгуулийн машин, тандагч багаж, 1 сум дахь тасгийн байрт засвар үйлчилгээ хийх хөрөнгийн асуудлыг тус тус шийдвэрлүүлээ.

-Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай /гэрээ, санамж бичиг байгуулсан, хамтран ажилласан байдлын талаарх мэдээлэл/-

Энэ хугацаанд тус цагдаагийн газраас төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахаар гэрээ, санамж бичиг байгуулсан асуудал байхгүй.

-Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар-

2018 онд байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон алба хаагчдаас 178 өргөдөл, гомдлыг гаргасан байна. Алба хаагчдаас 62алба хаагч захиргааны чөлөө хүссэнийг 2-5 хоногийн чөлөөг ээлжийн амралтаас тооцож олгосон. Цэргийн байнгын тэтгэвэрт гарах, нэг удаагийн тэтгэмж авах хүсэлт гаргасан 26 алба хаагчийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. 2018 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон алба хаагчдаас 178 өргөдөл гомдол ирүүлснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба үүнээс 41 буюу 24.5 хувь нь ажилд орох, суралцахыг, 9 буюу 5.0 хувь нь ажилд дахин орох, 13 буюу 7.3 хувь нь шилжин ажиллах, 62 буюу 34.8 хувь захиргааны чөлөө хүссэн, 26 буюу 14.6 хувь нь орон сууц, тэтгэвэр, тэтгэмж хүссэн, Мөн 11 нь Цагдаагийн газрын үйл ажиллагаа болон цагдаагийн алба хаагчтай холбоотой 11-11 төвөөс 1 буюу 0.5 хувь, Хууль зүй дотоод хэргийн яаманд 1 буюу 0.5 хувь, Цагдаагийн Ерөнхий Газарт хандсан 7 буюу 3.9 хувь, Цагдаагийн газрын даргад хандсан 2 буюу 1.0 хувь өргөдөл гомдол гаргасанд тухай бүрт нь албаны шалгалтыг хийж шийдвэрлэж хариуг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнд мэдэгдэж ажилласан.

Иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд үйлчилж ажилласан байна. Өргөдлийн мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгож Цагдаагийн Ерөнхий Газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлж хэвшсэн. Иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд үйлчилж хэвшлээ.

-Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн-

Тус Цагдаагийн газрын дотоод журмыг мөрдөх, Цагдаагийн Ерөнхий Газраас гаргасан “Цагдаагийн үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжилтийн байдалд өдөр бүр ёс журмын эргүүлийн тавих хяналтыг өндөржүүлсэнээс гадна гэмт хэрэг зөрчлийг шалгаж байгаа алба хаагчдад тасаг, хэсгийн дарга нараас тавьж байгаа хяналт шалгалтыг сайжруулж ажиллаж байна. Цагдаагийн газрын алба хаагчдын ажлыг долоо хоног, сар, улирлаар дүгнэж улирлаар Цагдаагийн газрын даргын зөвлөлөөр албан хаагчдын ёс зүйн төлөвшил, гаргасан зөрчлийн талаар зөвлөгөө өгч шинээр Цагдаагийн байгууллагад орж байгаа алба хаагчийн халамжлан хүмүүжүүлэгчийг нэр зааж тушаалаар томилон ажиллаж байна.

Алба хаагчдын сахилга ёс зүй, цэрэгжилт жагсаалч дүрэмч ажиллагааг сайжруулах зорилгоор 14 хоногт 1 удаа жагсаалын үзлэг бэлтгэлийг хийлгэж, зөрчил гаргасан алба хаагчийг тухай бүр дутагдлыг нь арилгаж байна.

2018 онд цагдаагийн газрын алба хаагчдаас гэмт хэрэгт холбогдсон алба хаагч байхгүй.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын өгсөн үүргийг алба хаагч бүрт танилцуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Цагдаагийн Ерөнхий Газрын даргын өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тасаг, нэгж бүр боловсруулж биелэлтийг тухай бүрт нь тооцож ажиллаж байна. Сахилгын зөрчил гаргаж байгаа алба хаагчдын гаргасан шалтгаан нөхцөл судалж хор уршгийг арилгах арга хэмжээг тухай бүрт нь авч ажилласан байна.

Сахилгын зөрчил гаргаж байгаа алба хаагч бүрт шат дараалсан арга хэмжээг авч дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар баталгаа авч үр дүнг тооцож, сахилгын зөрчил гаргаж байгаа алба хаагчдад ажил сайжруулах болон сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байх талаар ажлын чиглэл зааварчилга бичлээ.

Сахилгын зөрчил гаргаж байгаа алба хаагч бүрт шат дараалсан арга хэмжээг авч дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар баталгаа авч үр дүнг тооцож, сахилгын зөрчил гаргаж байгаа алба хаагчдад ажил сайжруулах болон сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байх талаар ажлын чиглэл зааварчилга бичлээ.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийг алба хаагч бүрт танилцуулж, 4 цагийн сургалтыг зохион байгуулж, алба хаагч нэг бүрээс баталгааг гаргуулж авч ажилласан.

Сахилга хариуцлагын зөвлөгөөнийг газрын хэмжээнд 4 удаа хийж зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд “Сахилга ёс зүйн зөвлөл” хяналт тавьж, сар бүрийн 15-ны өдөр хуралдааныг зохион байгуулж, зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын талаарх мэдээллийг цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанд 3 удаа хүргүүлж, зөрчил дутагдал гаргасан алба хаагч нарт хариуцлага тооцож хэвшлээ.

2018 онд сахилга ёс зүйн зөрчил гаргасан нийт 40 алба хаагч, үүнээс 30 офицер, ахлагч 10 байна. Бүртгэгдсэн сахилгын зөрчлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал: Нийт зөрчил 13-аар буюу 25.0 хувиар буурчээ. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдыг албан тушаалаар ангилвал: Тасаг, хэсгийн дарга 2, Эрүү, эдийн засгийн мөрдөгч 3, хэсгийн төлөөлөгч 13, ахлах хэрэг бүртгэгч 1, хэв журмын ахлах офицер 1, хэсгийн байцаагч 3, замын цагдаагийн зохицуулагч 2, бусад офицер 5, хэв журмын цагдаа 4, цагдаа-жолооч 1, бусад цагдаа 4 байна. Зөрчлийн хэлбэрээр нь авч үзвэл: Ажлын хариуцлага алдсан 12, хууль ёс хүний эрх зөрчсөн 11, Архидан согтуурсан зөрчил 8, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн 6, Бусад хууль тогтоомж зөрчсөн 2, Бусад зөрчил 1 тус тус бүртгэгджээ. Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийг нь авч үзвэл: Хувь хүний буруутай үйл ажиллагаа 36, Хууль дүрэм, журам зааврын мэдлэг дутмаг, мэргэжлийн ур чадвар сул 4 тус тус сахилгын зөрчил гарахад нөлөөлсөн байна. Ноогдуулсан шийтгэлээр авч үзвэл: Цалин бууруулсан 29, сануулсан 6 алба, цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах 3, албан тушаал бууруулах 1, цагдаагийн цол бууруулах шийтгэл ногдуулагдсан 1 алба хаагч байна. Зөрчил гаргагчдын 27-ыг дотоодын хяналтаар, 4 зөрчлийг гадны хяналтаар, 9-ийг иргэд болон төрийн буса байгууллагаас ирүүлсэн албан бичиг, материалын дагуу илрүүлж хариуцлага тооцон ажилласан байна.

Прокурорын шаардлагыг 6 удаа хүлээн авснаас Эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны 4, эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаатай холбоотой шаардлага 2 тус тус иржээ. Нийт ирсэн 6 шаардлагад 12 зөрчил заагдаж 6 алба хаагч уг зөрчлийг гаргаж 6 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна. Аймгийн Прокурорын газраас ирүүлсэн шаардлага бүрт албаны шалгалтыг зохион байгуулж дүнг цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж хариуг хүргүүлж ажиллаж байна. Шаардлагад заагдсан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх чиглэлээр 6 цагийн сургалтыг зохион байгуулж, алба хаагч нарт тавих хяналтыг сайжруулахыг Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Г.Оргилболд, Хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн хошууч Н.Баттөмөр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн нарт үүрэг болгосон. Аймгийн Прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг 12 удаа зохион байгуулж ажилласан.

2018 онд тус цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасагт прокурорын

шаардлага, арга хэмжээ тооцуулах албан бичиг ирээгүй. Тус цагдаагийн газрын бусад алба, алба хаагчидтай холбоотой прокурорын шаардлага, Мөрдөн байцаах албанаас ирүүлсэн прокурорын шаардлагад дурдагдсан зөрчил дутагдалтай холбоотой үүрэг ажлын чиглэлийг алба хаагчдад танилцуулж зөрчил дутагдал гаргахаас сэргийлж ажилласан. Хууль хэрэглэх явцад алдаа зөрчил гаргахаас сэргийлэх зорилгоор долоо хоног бүр нэг алба хаагчаар хичээлийн сэдэв бэлтгүүлэн тасгийн хэмжээнд сургалт зохион байгуулж байна. Гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн болон цагдан хорих зэрэг хуулийн хугацаа хэтрүүлдэг, хэрэгт эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах, шилжүүлэх журмыг зөрчих, прокурорын даалгаврыг бүрэн биелүүлэхгүй байх зөрчил гаргуулахгүй байх зорилгоор алба хаагчдын үйл ажиллагаанд бүртгэлээр болон биечлэн тогтмол хяналт тавьж хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт явуулж буй материалуудыг уншиж танилцан 215 хэрэгт даргын зааварчлага бичиж биелэлтийг тооцсон.

-Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ-

Авилга хээл хахууль авах, өгөх, зуучилах, шан харамж авах, харъяаллын бус хэрэг маргаанд хөндлөнгөөс оролцох, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх талаар алба хаагч нэг бүрт танилцуулж ажилласан. Авлигын эсрэг явуулж байгаа үйл ажиллагааг үнэлэх аргачилалын дагуу цагдаагийн газрын даргаар удирдамж батлуулан шалгалтыг хийж танилцуулга бичлээ. Хэрэг материалыг үндэслэлгүйгээр шийдвэрлэсэн байж болох үндэслэл илэрсэн тохиолдол бүрт албаны шалгалтыг явуулж байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын хамтарсан зөвлөгөөнийг сар бүр хийж, алба хаагч нарт аюулгүй байдлын мэдлэг олгож, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, шударгаар ажиллах боломж нөхцлийг бүрдүүлж ажиллаж байна.

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнээс “Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх баталгааг авч, тээврийн хэрэгсэлтэй алба хаагчдын судалгааг шинээр гаргасан байна. Цагдаагийн газрын хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцтгэх үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж удирдамжтай 6 удаагийн шалгалтыг хийж илэрсэн зөрчлийн талаар газрын даргад танилцуулж ажилласан.

Онц хүнд, бүлэг зохион байгуулалттай, хохирол ихтэй, олон нийтийн анхаарал татсан гэмт хэрэг шалгаж байгаа ажлын хэсэгт орсон алба хаагчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд гэмт хэрэг шалгаж байгаа алба хаагчдаас халдлагад өртсөн алба хаагч байхгүй.

Цагдаагийн газрын алба хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа бүх компьютерийг нууц кодтой болгох ажлыг зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд эвдрэл гэмтэл гарсан нөхцөлд цагдаагийн газрын холбоо мэдээллийн инженер завсар үйлчилгээг хийх ажлыг хэвшүүлээд байна.

Алба хаагч нарын ажил үүрэгтэй нь холбогдсон албаны хариуцлага, сахилга батын байдалд анхаарч хүний нэр төр, алдар хүндэд халдаж болзошгүй мэдээ баримт сэлтийг санаатай санамсаргүй байдлаар тараах, хаяж үрэгдүүлэхгүй байхад анхаарч ажилласан. Энэ хугацаанд дээрх төрлийн зөрчил дутагдал гаргасан алба хаагч байхгүй болно

Нягтлан бодох бүртгэлийн болон төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулиудыг мөрдлөгө болгон төсвийн хөрөнгийг зарцуулж байгаа байдал, үнэт цаасний хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад байнгын хяналт шалгалтыг хийж ажилласан.

Үнэт цаасны хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд байнгын хяналт тавьж гэнэтийн тооллого хийх ажлыг зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд үнэт цаас олгохдоо үнэт цаас хүлээлгэн өгсөн тэмдэглэлийг үйлдэж байх явдлыг хэвшүүлж ажиллаж байна.

Галт зэвсэг, тусгай хэрэгслийн хадгалалт хамгаалалтын байдалд хагас жилээр тооллого үзлэгийг цагдаагийн газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд илэрсэн зөрчил дутагдал байхгүй.

Галт зэвсгийн зориулалтын сейфэнд сумыг цагдаагийн няравын өрөөнд тусгай шүүгээнд хадгалж хяналт тавьж байна.

Галт зэвсгийг Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагчийн ажлын өрөөнд тусгайлсан хамгаалалт бүхий сейфэнд хадгалж зэвсэг алба хаагч нарт олгох асуудлыг цагдаагийн газрын даргын зөвшөөрлөөр олгож байна.

Аймгийн Онцгой байдлын хэлтсийн Гамшигаас хамгаалах улсын хяналтын байцаагч, онцгой байдлын хошууч Л.Бямбасүрэн цагдаагийн газрын барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/техникийн шаардлага,барилга байгууламж тоног төхөөрөмж, техникийн ерөнхий шаардлага /MNS 4628-98/, аж ахуйн нэгж, байгууллага, байгууламжинд гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэлийн зайлшгүй байх шаардлага норм /MNS 5566:2005/, гамшгаас хамгаалах болон гал түймрийн хяналтын дүрэм,стандарт,техникийн норм, норматив, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-113,125/ журмын хэрэгжилтийг шалгаж заавар, зөвлөмж авч ажилласан.

-Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн
байдал /код-110/-

Цагдаагийн Ерөнхий Газраас ирүүлж байгаа шийдвэр бүрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулж, алба хаагч бүрт танилцуулах ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тогтоосон хугацаанд дүгнэж ажиллаж байна. Цагдаагийн Ерөнхий Газрын даргын “Жагсаалт батлах тухай” 2018 оны А/94 дугаар тушаалын хавсралтын дагуу хяналт, шинжилгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтын дагуу тогтоосон хугацаанд тооцож холбогдох алба, нэгжүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

-Байгууллагын эрсдэлийн удирдлагын
талаар-

Эрсдлийн үнэлгээг гаргахдаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх /код 137/ журам”, Хууль зүйн сайдын 2013 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагын эрсдэлийг үнэлэх аргачлал”-ыг мөрдлөг болгон Цагдаагийн Ерөнхий Газрын Дотоод аюулгүй байдлыг хангах газрын алба хаагчдаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа

Энэ хугацаанд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, жагсаал цуглааныг албадан тараах үед цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй болон учирсан эрсдлийг тодорхойлж Цагдаагийн Ерөнхий Газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын 2017 оны эрсдлийн үнэлгээний тайлан, өгсөн зөвлөмжийг алба хаагч нарт танилцуулж, сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн газрын 2018 оны эрсдлийн үнэлгээг гаргаж Цагдаагийн Ерөнхий Газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

-Хяналт шалгалт, албаны шалгалтын талаар-

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг 38 асуудлаар төлөвлөж биелэлтийг хагас жилээр тооцож ажиллаа. Мөн цагдаагийн газрын тасаг, хэсгүүдэд хэсэгчилсэн шалгалт явуулах удирдамжийг батлуулж, төлөвлөгөөний дагуу холбогдох шалгалтуудыг хийж ажилласан. Хийгдсэн шалгалтын дүнг цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж ажлын зааварчлага өгч, биелэлтийг хангуулж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах үүрэг бүхий ёс журмын эргүүлийг 24 цагийн хугацаатайгаар томилж ажиллуулж байна.

Алба хаагчдын цаг ашиглалтын байдал, хариуцсан сум, нутаг дэвсгэрт ажиллаж байгаа байдлыг өдөрт 3 удаа бүртгэлээр хяналт тавьж, мэдээ ирүүлээгүй алба хаагч нарт тооцох хариуцлагыг чангатгаж ажиллаж байна.

Алба хаагчдын цаг ашиглалтын байдал, хариуцсан сум, нутаг дэвсгэрт ажиллаж байгаа байдлыг өдөрт 3 удаа бүртгэлээр хяналт тавьж, мэдээ ирүүлээгүй алба хаагч нарт тооцох хариуцлагыг чангатгаж ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн гишүүдээр ахлуулсан 8 ажлын хэсэг 23 сум дахь хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын үйл ажиллагааг шалган зааварчлах ажлыг зохион байгуулж дүнг цагдаагийн газрын даргад танилцуулсан.

Цагдаагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу тус цагдаагийн газрын Удирдлага, Захиргааны удирдлагын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, Хэрэг бүртгэх тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалтыг явуулж, дүнг цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар баталгаажуулав.

Алба хаагчдын албаны бэлэн байдал, үүрэг гүйцэтгэлтийн байдалд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр “Ц-111” дохиогоор 4 удаа ажиллаж дүнг цагдаагийн газрын даргад танилцуулж, ажлын чиглэл авч ажилласан.

Энэ хугацаанд 53 алба хаагчид холбогдох 28 асуудалд албаны шалгалтыг Цагдаагийн дэд хурандаа Д.Уртбаяр, цагдаагийн дэд хурандаа Д.Буяндалай, цагдаагийн дэд хурандаа Ч.Нямбат, цагдаагийн дэд хурандаа Д.Энхбаяр, цагдаагийн дэд хурандаа А.Энхбаяр, цагдаагийн хошууч Б.Пүрэвсүрэн, цагдаагийн хошууч А.Эрдэнэзул, цагдаагийн хошууч Г.Оргилболд нар явуулж албаны шалгалт явуулсан дүнгийн тухай мэдээг Цагдаагийн газрын Хүний мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч А.Гантунгалаг бичиж Дотоод аюулгүй байдал, хяналт шалгалтын хэлтэст хүргүүлж хяналт шалгалтын программд мэдээллийг тухай бүрт нь оруулж ажилласан.

Албаны шалгалт явуулах үндэслэлийг ангилан үзвэл: Иргэд, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнаас мэдээлсэн 12, Удирдах албан тушаалтны шийдвэрээр 6, Дотоод хяналт шалгалтаар 8, өөрийн хүсэлтээр 1 асуудалд явуулжээ.

Холбогдсон зөрчлийн байдлаар нь ангилан үзвэл: хэрэг материал дутуу шалгасан 7, алба хаагчийн харилцааны соёл, ёс зүй зөрчсөн 3, Ажлын хариуцлага алдсан 2, Архидан согтуурсан 2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн 2, Ажлын цагийг тасалсан 8, Эрүүлжүүлэх баривчлах байрны журам зөрчсөн 1, Торгуулийн тасалбар үрэгдүүлсэн 1, энгэрийн тэмдэг, албаны үнэмлэх үрэгдүүлсэн 1 асуудалд албаны шалгалтыг явуулж, 41 офицер, 12 ахлагч алба хаагч холбогджээ.

Холбогдсон алба хаагчдыг албан тушаалаар нь ангилвал: Тасаг, хэсгийн дарга 2, Эрүүгийн ахлах төлөөлөгч 4, эрүү, эдийн засгийн төлөөлөгч 5, мөрдөн байцаагч 1, ахлах хэрэг бүртгэгч 1, хэсгийн төлөөлөгч 13, Хэсгийн байцаагч 5, Хэв журмын офицер 2, Замын цагдаагийн ахлах байцаагч, байцаагч 2, бусад офицер 6, эргүүлийн цагдаа 2, цагдаа-жолооч 1, бусад цагдаа 9 алба холбогджээ. Холбогдсон алба хаагчдыг боловсролоор нь авч үзвэл: Дээд боловсролтой 48, Тусгай дунд боловсролтой 2, Бүрэн дунд боловсролтой 3 алба хаагч байна. Ажилласан жилээр нь авч үзвэл: 1-5 жил ажилласан 13, 6-10 жил ажилласан 19, 11-15 жил ажилласан 10, 16-20 жил ажилласан 7, 21-25 жил ажилласан 4 алба хаагч байна.

Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлөөр нь авч үзвэл: Хувь хүний буруутай үйл ажиллагаанаас 25, хяналт шалгалт сул 3, Хууль, дүрэм, журам, зааврын мэдлэг дутмаг, мэргэжлийн ур чадвар сул байдлаас шалтгаалсан зөрчил 5 зөрчил бүртгэгджээ. Бүртгэгдсэн албаны шалгалтын 11 зөрчил нь нотлогдоогүй, нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан 7, 24 алба хаагчийг цалинг бууруулах, 2 алба хаагчийг тухайн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах, 6 алба хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Цагдаагийн газрын удирдлага алба хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан шалтгаан нөхцлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар гомдол мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэж байгууллагын болон алба хаагчийн нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллав.

Цагдаагийн газрын иргэдийн хүлээлгийн танхимд санал хүсэлтийн хайрцагийг байрлуулж ажилласан бөгөөд уг хайрцаганд алба хаагчдын талаар ямар нэгэн санал

хүсэлт ирээгүй боловч цагдаагийн газрын даргын нэр дээр алба хаагч нарын үйл ажиллагаатай холбоотой 1 гомдол, мэдээлэл ирүүлсэнд холбогдох шалгалтыг хийж хариуг хүргүүлж ажилласан байна.

Цагдаагийн газрын төв, орон нутгийн алба хаагчдын сургалт, зөвлөгөөний үеэр 2 удаа сахилгын зөвлөгөөнийг хийж холбогдох материалыг Цагдаагийн Ерөнхий Газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлж сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан алба хаагч бүрийг хэлэлцэж баталгаа гаргуулж ажиллаж байгаа.

Цагдаагийн Ерөнхий Газрын дэд даргын “Үүрэг, ажлын чиглэл хүргүүлэх тухай” 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 3/3533 дугаартай албан бичгийн дагуу дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд. Алба хаагч нэг бүрээс ажлын цагаар албаны интернет сүлжээгээр олон нийтийн сүлжээ, онлайн тоглоом, видео сан бүхий сайтад хандахгүй байх, албаны бичиг баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулахгүй байх талаар баталгааг гаргуулж ажлын чиглэл өгсөн.

Цагдаагийн Ерөнхий Газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 5/49 дугаартай үүрэг, ажлын чиглэлийг алба хаагч бүрт танилцуулж, алба хаагч нэг бүрийн facebook хуудсыг шалгаж, илэрч байгаа зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулж байна.

Тус цагдаагийн газраас зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Энэ хугацаанд тус цагдаагийн газраас зохион байгуулсан ажил арга хэмжээний талаарх 62 мэдээллийг байгууллагын цахим хаяганд болон “Хөвсгөл аймгийн цагдаагийн газар” facebook хуудсаар сурталчлах ажлыг зохион байгуулсан. Цагдаагийн газрын албан ёсны цахим хуудсаар нийтэлж байгаа мэдээ, мэдээллийн агуулга, ач холбогдол, үнэн бодит байдлыг Захиргааны удирдлагын тасгийн дарга хянаж, Холбоо, мэдээллийн инженер нийтэлж хэвшсэн. Хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтарч ажиллах алба хаагчаар Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ц.Тунгалагтэс, цагдаагийн хошууч Р.Эрдэнэбат нарыг томилж ажлуулж байна. Алба хаагчаас энэ хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, шалгагдаж байгаа хэрэг материалын талаар буруу ташаа мэдээлэл тараасан алба хаагч байхгүй болно.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрх зүйн мэдлэг, мэдээлэл хүргэх зорилготой цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийг алба хаагч бүр түгээх ажлыг зохион байгуулж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

-Нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээ-

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа сургуулийн насны хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа “school police” арга хэмжээнд цагдаагийн газрын алба хаагчдыг ажлаас нь чөлөөлж, эцэг, эхийн үүргийн дагуу эргүүл, жижүүрт ажлуулж байна.

Хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах чиглэлээр Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Улаан-Уул, Эрдэнэбулган, Рэнчинлхүмбэ сум дахь хэсгийн төлөөлөгч нарыг “Тэнхлэг” “Ямаха” маркын шинэ мотоциклээр хангасан.

Мөрөн суманд 14 олон нийтийн цагдаагийн ажилтан ажлуулах урамшууллын зардал, хөдөлмөр, хамгааллын хувцсыг шинээр хийлгэж зардлын асуудлыг шийдвэрлэсэн.

Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр 6 багт хуваан хувиарлаж спортын уралдаан тэмцээн, хэлэлцүүлэг, семинар, зөвлөгөөн аливаа арга хэмжээнд оролцуулж байгаа нь хамт олныг эвсэг, нөхөрсөг, нэгнийгээ дэмжих хандлагыг өөрчлөх ажлыг зохион байгуулж байгаа үр дүнгээ өгч байна.

Тасаг, хэсгийн дарга нар 7 хоног бүрийн Даваа гарагт хийсэн ажлаа цагдаагийн газрын даргад танилцуулж, ажлын чиглэл, үүргийг авч дараагийн 7 хоногт хийх ажлаа төлөвлөн ажиллаж байна. Цагдаагийн газрын даргаас өгсөн чиглэл, үүргийн дагуу тасгийн дарга нар, эрүүгийн ахлах мөрдөгч, ахлах мөрдөгч нарыг багт хувиарлан сум, Мөрөн сумын багуудыг хувиарлан хариуцуулж, гэмт этгээд тогтоогдоогүй хэрэг бүрийг илрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

-Судалгаа, дүн шинжилгээ хийсэн

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газарт 2018 оны эхний 11 сард иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 2991 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан. Үүнээс 999 буюу 33.4 хувь нь гэмт хэргийн, 1992 буюу 66.6 хувь нь зөрчлийн талаарх гомдол мэдээлэл байна.

Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй 999 гомдол мэдээллийн 990 гомдол мэдээллийг шийдвэрлэсэн. Үүний 744 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 246 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал аймгийн прокурорт гаргаж хүргүүлж, 3 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт 2018 оны эхний 11 сард 744 үйлдэлд хэрэг үүсгэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулжээ. Хөвсгөл аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралтыг урьд оны мөн үетэй харьцуулахад 8 хэргээр буюу 1.1 хувиар өсчээ.

Бүртгэгдсэн нийт 744 хэргийн, 377 гэмт хэрэг нь аймгийн төвд, 367 гэмт хэрэг нь сумдад бүртгэгджээ.

Хэргийн илрүүлэлт 47.5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.8 хувиар өссөн байна. Илрүүлэлтийн түвшинг бусад аймаг, дүүргийн газар хэлтсүүдтэй харьцуулж үзвэл хангайн бүсийн аймгуудаас 4, 21 аймгаас 17, улсын хэмжээнд 18 дугаар байр эзэлж байгаа ба илрүүлэлтийн түвшин нь улсын дунджаас дээгүүр байна.

Хүний амьд явахын эрхийн эсрэг гэмт хэрэг 27 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 17 хэргээр буюу 61.3 хувиар, Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 50.0 хувиар, Хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 248 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 94 хэргээр буюу 61.0 хувиар, Мал хулгайлах гэмт хэрэг 95 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 32 хэргээр буюу 50.8 хувиар, Залилах гэмт хэрэг 28 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 9 хэргээр буюу 47.4 хувиар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 41 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 26 хэргээр буюу 173.3 хувиар, Хүчиндэх гэмт хэрэг 24 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 8 хэргээр буюу 44.4 хувиар тус тус өсч, Хүнийг санаатай алах гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 28.5 хувиар, Хүний эрүүл, мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 190 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 51 хэргээр буюу 21.2 хувиар, Дээрэмдэх гэмт хэрэг 4 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 14 хэргээр буюу 77.8 хувиар, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 24 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 25 хэргээр буюу 51 хувиар тус тус буурчээ.

Тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 39 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 27 хэргээр буюу 40.9 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 27 байгаа нь 5 буюу 22.7 хувиар өсч, Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 90 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 36 буюу 28.6 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 32 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3 буюу 8.6 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 126 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 58 буюу 31.5 хувиар тус тус буурсан байна.

Оны эхний 11 сарын байдлаар нийт 748 хүн гэмт хэрэгт өртөж хохирсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 51 буюу 7.3 хувиар, гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 2101.8 сая төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 26 сая төгрөг буюу 1.2 хувиар буурсан, 647.5 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 57.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Захиргааны зөрчлийн илрүүлэлтийг авч үзвэл 14183 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1798 буюу 14.5 хувиар өссөн, торгуулийн хэмжээ 530125.0 төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 56539 төгрөгөөр буюу 11.9 хувиар тус тус өссөн байна.

Мөн хугацаанд архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 331 жолоочийн эрхийг хассан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 111 буюу 33.5 хувиар, захиргааны журмаар баривчлагдсан хүн 261 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 113 буюу 43.2 хувиар тус тус өсч, эрүүлжүүлсэн хүн 1394 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 520 буюу 25.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Цагдаагийн газрын удирдлагын зүгээс өргөдөл гомдол шийдвэрлэлтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий албан тушаалтнууд шалгаж байгаа өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, хугацааны талаар

мэдээлэл судалгааны ахлах байцаагч хүн нэг бүрээр бүртгэлийн дэвтэр гаргаж, жижүүрийн шуурхай албаны хариуцлагатай жижүүрийн рапортанд тусгагдсан гомдол мэдээлэлийг шалгахаар цохогдсон албан тушаалтнаар маягтыг бичүүлж, тасгийн дарга, ахлахаар нь хянуулж, гарын үсэг зуруулж, тэмдэг даруулж баталгаажуулан бүрэн зөв, гүйцэд бичигдсэн үед гэмт хэргийн гомдол мэдээллийн санд шивж оруулахад компьютераас өгөгдсөн дугаарыг бичиж баталгаажуулан тухайн алба хаагчийн бүртгэл, хяналтын дэвтэрт үдэж, шийдвэрлэлтийн тухай газрын даргад танилцуулсанаар алба хаагчдад тодорхой үүрэг өгч, хугацаа алдаж болзошгүй байдлыг нэг бүрчлэн үзэж танилцаж, шаардлагатай унаа машин болон бусад шаардагдах арга хэмжээг авч ажилласнаар өргөдөл гомдлын шийдвэрлэлт хуулийн хугацаанд шалгагдаж байна. Гэмт хэргийн болон захиргааны зөрчлийн тухай өргөдөл мэдээлэл, ялангуяа хэсгийн төлөөлөгч, байцаагчдын хүлээн авсан өргөдөл мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүрэн хамруулах, хууль зүйн дагуу хугацаанд нь шийдвэрлэхэд онцгой анхаарч ажилласнаар өргөдөл мэдээллийг 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэсэн

-/Удирдлага зохион байгуулалтын шинжтэй бүхий л ажил,
арга хэмжээг тусгана/-

Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар сарын 15, 30-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга, Хууль зүйн хэлтэс, сумдын Засаг дарга нарт санал мэдээлэл хүргүүлэн тэдний дэмжлэг туслалцааг авч байна.

Энэ хугацаанд цагдаагийн газрын алба хаагчдын талаар иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас 3 санал, өргөдөл, гомдол хүлээн авч албаны шалгалт явуулан 3 өргөдөл нь нотлогдоогүй тул арга хэмжээ авахаас татгалзаж энэ тухай хариу мэдэгдэв.

Цагдаагийн газрын удирдлага алба хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан шалтгаан нөхцлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар гомдол мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэж байгууллагын болон алба хаагчийн нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллав.

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан удирдах ажилтны сургалт зөвлөгөөнд 3 хоногийн хугацаанд хамрагдаж, цагдаагийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэж ажилласан.

Цагдаагийн газартай хамтарч ажиллаж байгаа хууль хяналтын байгууллага, харилцан ажиллагаатай байгууллагуудын дарга, эрхлэгч, захирлуудтай уулзаж өөрийн ажлын чиглэл, цагдаагийн газрын үйл ажиллагааны талаар харилцан санал солилцож ажиллаа.

Энэ хугацаанд аймгийн онцгой комиссын хуралдаанд 3 удаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хуралдаанд 2 удаа оролцож цаг үеийн нөхцөл байдлын талаар тогтмол мэдээллийг өгч хамтарч ажилласан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.6 дахь хэсэгт заасны дагуу хариуцсан нутаг дэвсгэрийн оршин суугч иргэдэд үйл ажиллагааны тайланг танилцуулах, санал хүсэлтийг сонсох ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын дагуу цагдаагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсгүүд Аймгийн 23 сум 1 тосгонд 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс мөн оны 01 дүгээр сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллаа. Мөрөн сумын 14 багт цагдаагийн газрын зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд баг бүрт ажиллаж тайланг тавих ажлыг зохион байгуулсан. Тайлан тавих арга хэмжээний хүрээнд иргэдэд урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг 650 ширхэгийг тарааж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр ашиглагдаж багаж, техник хэрэгсэл, тусгай хэрэгсэл бүрийг байрлуулж ажилласан. Мөрөн сумын иргэдэд тайлан тавих ажиллагаанд хүрэлцэн ирсэн иргэдээс 12 асуулт гаргасанд хариултыг өгч, цагдаагийн газрын алба хаагчдын үйл ажиллагааны талаар 2 иргэнээс талархлыг хүргэж, 3 иргэн цагдаагийн

байгууллагын ажил үйлчилгээтэй холбогдуулсан саналыг гаргасан тул хүлээн авч үйл ажиллагааныхаа төлөвлөлтөнд тусгахаар холбогдох алба хаагч нарт ажлын чиглэл өглөө. Тайлан тавих ажиллагаанд хүрэлцэн ирсэн 140 иргэнээс, 22 сум 1 тосгонд ажилласан алба хаагчид 500 иргэнээс Цагдаагийн Ерөнхий Газраас ирүүлсэн санал асуулгыг авч дүнг цагдаагийн газрын Сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч Ё.Шижиртуяа нэгтгэж дүгнэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах, Аймаг, сумд хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан ажлаа цалгардуулсан, авилга, хээл хахуулын хэрэгт холбогдсон, хүнд суртал гаргасан ажлын байранд архидан согтуурсан, хадгалсан албан тушаалтантай хариуцлага тооцож ажилласан эсэхийг шалгах Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 255 дугаар тушаал, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/217 дугаар тушаалыг үндэслэн Хөвсгөл аймгийн Засаг даргын 2018 оны А/461 дугаар захирамж, Цагдаагийн газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/66 дугаар тушаалаар хяналт, шалгалт явуулах ажлын хэсгийг байгуулж ажиллалаа.

Батлагдсан удирдамжийн дагуу хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулсан шалгалтын ажлын хэсэгт Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын Ерөнхий Газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсийн алба хаагчдыг оролцууллаа.

Хяналт, шалгалтанд ажиллах алба хаагчдаас нууцын баталгааг Тагнуулын хэлтсийн алба хаагчид авч биелэлтэд нь хяналт тавьж ажиллалаа.

Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа Ц.Баатардоржоор ахлуулсан ажлын хэсэг Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Цагааннуур сумын чиглэлд 3 хоног, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Г.Гандэлгэрээр ахлуулсан ажлын хэсэг Түнэл, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр сумын чиглэлд 3 хоног, Аймгийн засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Ч.Уртнасангаар ахлуулсан ажлын хэсэг Галт, Шинэ-Идэр, Жаргалант, Төмөрбулаг сумын чиглэлд хоног, Мэргэжлийн хяналтын газрын Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга А.Үүрийнцолмонгоор ахлуулсан ажлын хэсэг Арулаг, Баянзүрх, Тосонцэнгэл сумын чиглэлд 3 хоног, Цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Г.Оргилболдоор ахлуулсан ажлын хэсэг Ханх, Алаг-Эрдэнэ, Хатгал тосгоны чиглэлд 3 хоног, Хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн хошууч Н.Баттөмөрөөр ахлуулсан ажлын хэсэг Рашаант, Эрдэнэбулган, Тариалан, Их-Уул сумын чиглэлд 4 хоног, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч А.Эрдэнэзулаар ахлуулсан ажлын хэсэг Цагаан-Уул, Цэцэрлэг, Бүрэнтогтох сумын чиглэлд 3 хоногийн хугацаанд ажиллаж хяналт, шалгалтыг явууллаа. Хяналт шалгалтын ажлаар томилолтоор ажилласан болон бусад ажлын хэсэгт ажилласан алба хаагчдаас иргэдтэй зүй бус харьцсан, сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргасан алба хаагч байхгүй.

Мөрөн суманд 14 ажлын хэсэгт 86 алба хаагч, 23 суманд 7 ажлын хэсэгт 34 алба хаагч ажиллаж, төрийн болон орон нутгийн өмчит 204 байгууллагын 6668 төрийн албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, сейф, ширээ сандал, хогийн сав зэрэгт үзлэг шалгалтыг хийлээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий Цагдаагийн газар, Хилийн 0257 дугаар анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шинжилгээ алба, Тагнуулын хэлтсийн байр байгууламж, алба хаагчдын өрөө тасалгаанд үзлэг шалгалтыг явуулж ажилласан.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

-Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр-

Тус цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасаг нь иргэд, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 587 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 512 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 11 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж хуулийн хугацаанд шалгаж, 64 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, шийдвэрлэсэн байна. Хэсгийн мөрдөгч нараас 245 зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар арга хэмжээ тооцож, Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэсэн байна. Эрүүгийн болон хэсгийн мөрдөгч нараас хэрэг бүртгэлтийн шатанд шалгагдсан 240 гэмт хэрэг илрүүлж, шүүхэд шилжүүлэх саналтай болон мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар Мөрдөн байцаах тасагт шилжүүлэн ажилласан байна.

Нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр “Тулгалт”, “Шийдвэрлэлт” “Сар, шинэ” “Илрүүлэлт, оргодол” “Отолт” “Мото” “Орон байр” “Сан тулгалт” “Орон нутаг”, “Маршрут” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцлоо. Мал мах бэлтгэн зах зээлд борлуулдаг 24 ченжийн судалгааг шинэчлэн гаргаж тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьж байна. Гэмт хэрэг үйлддэг, үйлдэж болзошгүй 4 бүлэглэл, нийт 32 сэжигтэй этгээдийг шинээр бүртгэж шилжилт хөдөлгөөн үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах ASAP сан”-гийн ашиглалтанд хяналт тавьж Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг тус санд нэвтэрч мэдээлэл авч байх өдөр тутмын ажилдаа санг ашиглаж хэвших ажлыг зохион байгуулж ажиллав. Мөн бусад төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэсээс ирүүлсэн эрэн сурвалжлуулсан оргодол, сураггүй алга болсон хүн, эд зүйлсийн талаарх мэдээллийг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан аймгийн хэмжээнд эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж ажилласан.

Эрэн сурвалжлах орон тооны бус зөвлөл сард 2 удаа эрэн сурвалжлах үйл ажиллагааны хяналт бүртгэлд үнэлэлт дүгнэлт өгч, алба хаагч бүрийн Эрэн сурвалжлах “ASAP” сангийн ашиглалт, бүрдүүлэлтэнд хяналт тавьж, үр дүнг сар бүр ажлын үр дүнд нь оруулан тооцож ажилласан. 2018 оны жилийн эцсийн байдлаар 256 мэдээллийг “ASAP” санд оруулж алба хаагчид бүрэн танилцсан байна.

Одоо “ASAP” сангаар эрэн сурвалжилж байгаа алга болсон хүн 7, Оргодол этгээд 2, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 7, тээврийн хэрэгсэл 9, галт зэвсэг 19, шүүхээс даалгасан бусад хүн 22, түүх дурсгалын үнэт зүйлс 3, мал 7, эд зүйл 121 гэсэн мэдээлэл бүртгэж хянасан байна.

“ASAP” сангаар нийт 83 эрэн сурвалжлагдаж байсан хүн, мал, эд зүйлийг олж тогтоож эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. Одоогоор хэн болох нь тодорхойгүй цогцос олдоогүй байна. Хэн болох нь тогтоогдоогүй цогцос, сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжилж, олж тогтоох ажлыг шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах зорилгоор “ASAP” сангийн сүлжээг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн холбогдох нэгжтэй холбон, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, амьтан, эд зүйлийн онцлого содон шинж тэмдгээр хайлт хийх зэргээр программ хангамжинд алба хаагч нараа ажиллах сургалт 2 удаа зохион байгуулан ажиллаж ахлагч бүрэлдэхүүнээс тестээр шалгалт авч, сургалт хамруулан ажиллаж байна.

Тус цагдаагийн газраас эрэн сурвалжлагдаж байгаа цогцос, тэсэрч дэлбэрэх болон химийн бодис, аман зургаар, интерполоор эрэн сурвалжлагдаж байгаа этгээд одоогоор байхгүй байна.

Улсын хэмжээнд болон аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг бусад албадтай хамтран зохион байгуулан үр дүнг тухай бүрд нь тоохон ажиллаж нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн хүрээнд тус цагдаагийн газраас эрэн сурвалжлагдаж буй оргодлууд, сэжигтэнээр тооцогдвол зохих этгээдүүдийн судалгааг гаргаж тэдний талаарх хууль зүйн мэдээллийг холбогдох байгууллагуудаас лавлагааг гаргуулж мөн байж болох, очиж болох хаягуудыг хяналтанд авч ажиллаж байна.

-Мөрдөн байцаах албаны
чиглэлээр-

Тасгийн даргаас мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй хэрэг материалд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай 45 материал, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын

ажиллагаа явуулсан 351 хэргийг уншиж танилцан мөрдөн байцаалтын 125, хэрэг бүртгэлтийн 113 хэрэгт бичгээр даалгавар бичиж биелэлтийг тухайн алба хаагчаар илтгэх хуудас бичүүлэн дүгнэж байлаа.

Ажлын хариуцлага сахилгыг сайжруулах, хууль тогтоомжийг нэг мөр зөв хэрэглэж, зөрчил гаргахгүй ажиллах чиглэлээр тасгийн даргаас 12 удаа бичгээр зааварчлага өгч биелэлтийг нь тогтмол тооцож байна. Мөн тасгийн нийт алба хаагчдаас “Авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх” чиглэлээр баталгаа гаргуулан авсан.

Мөрдөн байцаах албаны даргаас ирүүлсэн үүргийн дагуу 2018 оны 5 дугаар сараас алба хаагчид Цагдаагийн байгууллагын “ABLE” программыг ашиглан ажлаа төлөвлөж төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын тэмдэглэлтэй тасгийн дарга өдөр тутам танилцан үр дүнг тооцож ажиллаж байна.

Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн А/80 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримт, эд зүйлыг хураан авах, бэхжүүлэх, хүлээн авах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”-д заасан стандарт шаардлагад нийцсэн эд мөрийн баримтын өрөөг шинэчлэн байгуулж хадгалалт хамгаалалт, шийдвэрлэлтэнд нь сар тутам тооллого тулгалт хийж байна.

Цагдаагийн газрын даргын тушаалаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-306-д заасан “Хэрэг бүртгэх мөрдөн байцаах албаны мэргэжлийн зөвлөл”-ийг байгуулан ажлуулж, төлөвлөгөө гарган ээдрээ төвөгтэй болон хугацаа сунган удааширч байгаа 8 хэргийг хэлэлцэж мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн.

“Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны даргаас эрүүгийн хэрэгт хяналт тавих /код 328/ журам”-ын дагуу алба хаагчдын үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавьж уг журмаар батлагдсан албаны хэмжээнд болон мөрдөгч нарын хөтөлж ажиллавал зохих бүртгэл судалгааг бүрэн хөтөлж ажиллаа.

Сар тутам шалгаж шийдвэрлэх хэргийн графикийг гарган Цагдаагийн Газрын даргаар батлуулж биелэлтийг нь тооцож байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг, тэдгээрийн хуулийн хугацаа, хэргийн хөдөлгөөнийг Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд оруулж статистик мэдээнд тусган алба хаагчдын ажлыг дүгнэж хэвшээд байна.

Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг долоо хоног бүр мэдээлэл судалгааны албатай тулгалт хийн Цагдаагийн газрын даргад танилцуулж гомдол мэдээллийн шийдвэрлэлт, эрүү хэв журмын нөхцөл байдлыг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч байлаа.

Аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг 9 удаа зохион явуулж хуулийн хугацаа сунгагдсан болон үлдэгдэл хэрэг нэг бүрийг хэлэлцэн түргэн шуурхай шийдвэрлэх талаар хамтарсан ажил зохиох, мөрдөн байцаалтын шатанд гарч байгаа алдаа дутагдлын арилгах чиглэлээр хэлэлцэн шийдвэр гаргаж байсан.

Мөрдөн байцаах албанаас ирүүлсэн ажлын үүрэг чиглэлийн дагуу “Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай”, “Хүний амь нас хохирсон гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх тухай”, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” аянуудыг тус тус төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.

2018 онд тус тасагт иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас гэмт хэргийн шинжтэй 364 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 40 буюу 13.4 хувийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж 5 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 29 гомдол мэдээлэл буюу 7.9 хувийг шууд эрүүгийн хэрэг үүсгэж, буюу 276 гомдол мэдээлэл буюу 75,8 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгасан.

Мөн онд урд оны үлдэгдэл 16, шинээр нээсэн 276, Эрүүгийн цагдаагийн тасгаас шилжүүлж ирүүлсэн 168 нийт 460 хэрэг бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулсанаас 213 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан, 176 хэргийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж нийт 389 хэрэг бүртгэлтийн хэрэг буюу 84.5 хувийг нь шийдвэрлэсэн. Мөн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор 16 хэрэг бүртгэлтийн хэргийг хэрэг бүртгэх тасагт шилжүүлж, 10 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар эрүүгийн цагдаагийн тасагт шилжүүлж одоо ажиллагаанд 45 хэрэг бүртгэлтийн хэргийн үлдэгдэлтэй байна.

2017 оны жилийн эцсийн үлдэгдэл 29 хэрэг бүртгэлтийн хэргийг 100 хувь шийдвэрлэсэн.

Тайлангийн хугацаанд өмнөх оны үлдэгдэл 10 хэрэг, шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 213 хэрэг, урд онуудад хэрэгсэхгүй болгосноос сэргээн шалгасан 1 хэрэг, хэрэг бүртгэх тасгаас ирүүлсэн 12 хэрэг, эрүүгийн цагдаагийн тасгаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шилжүүлж ирүүлсэн 44 хэрэг, нийт 311 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасан. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн 291 буюу 93.5 хувийг нь шийдвэрлэсэн байна. Үүнээс 81.7 хувь буюу 238 хэргийг шүүхэд шилжүүлж, 17.1 хувь буюу 50 хэргийг өөр хэрэгт нэгтгэн шалгаж 3хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар шилжүүлсэн. 7 хэргийг хэрэг бүртгэх тасагт шилжүүлж 13 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас прокуророос нэмэлт мөрдөн байцаалтанд буцаасан 2 хэрэг байна.

2017 оны жилийн эцсийн үлдэгдэл 10 хэргийг 100 хувь шийдвэрлэж дуусгасан. Нийт шийдвэрлэсэн хэргийн 92.5 хувийг хуульд заасан анхны хугацаанд шалгасан байна. Мөрдөн байцаалт явуулах хугацаа сунгасан 2 хэрэг байгаа нь нийт үлдэгдлийн 15.3 хувь байна. Мөрдөн байцаалт явуулан шүүхэд шилжүүлсэн байсан 2 хэргийн яллагдагч прокурорын шатнаас оргон зайлсан үндэслэлээр ЭХХ шийдвэрлэх тухай хуулийн 31.14.1.2-т заасан үндэслэлээр түдгэлзүүлж ирүүлсэнийг хүлээн авч эрэн сурвалжлах ажиллагаа явуулан баривчилж хэргийг сэргээн шалгаж шүүхэд шилжүүлсэн. Одоо тус тасагт түдгэлзүүлсэн хэрэг байхгүй.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 801.7 сая төгрөгийн хохирол учирсанаас 625.5 сая төгрөгний хохирол мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлөгдөж, 145.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжлэн хамгаалсан байна. Хохирол нөхөн төлүүлэлт 78.0 хувьтай байна. Мөрдөн байцаалтын шатанд 70 хүнийг цагдан хорьж шалгасан ба одоо ажиллагаанд үлдсэн хэргүүдэд 6 хүн хориотой байна. Хууль бусаар цагдан хоригдсон баривчлагдсан хүн байхгүй. Шүүхэд шилжүүлсэн 238 хэрэгт мөрдөгчийн мэдэгдэл бичиж хариуг 100 хувь авсан. Мэдэгдлийн дагуу зохион байгуулсан ажлыг 3 удаа 105 мэдэгдлийг хамруулан шалгасан. Тайлангийн хугацаанд прокуророос 18, шүүхээс 5, нийт 23 хэрэг нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан ба энэ нь нийт шийдвэрлэсэн хэргийн 7.9 хувийг эзэлж байна.

2018 онд тус тасгийн алба хаагчдаас хэрэг бүртгэлтийн 42 хэргийг нөхөн илрүүлж, "ASAP" сангаар эрэн сурвалжлагдаж байсан яллагдагч 2, гэмт хэрэгтсэрдэгдсэн этгээд 12-ийг олж баривчлан хэргийг нь шийдвэрлэсэн.

-Хэрэг бүртгэх албаны чиглэлээр-

Хэрэг бүртгэх албан тушаалтнуудын шалгаж байгаа эрүүгийн хэрэг, гомдол, мэдээлэл, бусад ажилд бүртгэлээр тогтмол хяналт тавьж ажилласан ба 18 хэрэг материалыг биечлэн уншиж танилцаж ээдрээ төвөгтэй, олны анхаарал татсан, хугацаа алдаж удааширч болзошгүй 12 хэрэгт даалгавар бичиж биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан.

Тайлангийн хугацаанд сэжигтнээр баривчлагдсан болон сэжигтнээр цагдан хоригдсон хүнгүй болно.

7 хоног бүр төвийн хэрэг бүртгэх албан тушаалтнуудтай шуурхай зөвлөгөөнийг хийж ажлын явц байдал, Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарч, удирдлагаас тавих хяналтыг сайжруулан Цагдаагийн газрын даргад танилцуулж, эрүүгийн хэрэг өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар туслах прокурортой тулгалт хийж, нийт хэрэг бүртгэх эрх бүхий ажилтнуудаас Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийг шивж оруулж байгаа байдалд тасгийн даргын зүгээс байнгын хяналт тавьж ажиллалаа.

Тус цагдаагийн газрын хэрэг бүртгэх тасаг нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гэмт хэргийн шинжтэй 205 гомдол мэдээлэл хүлээн авснаас 34 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай, 157 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 12 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж прокурорын газраас дугаар авч, харьяалалын дагуу 1 гомдол мэдээллийг хүргүүлж, 1 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Тасгийн хэмжээнд нийт 192 хэрэгт ажиллагаа явуулсан байна. Нийт шалгасан хэргээс 123 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай хүргүүлж, хэрэг бүртгэлтийн 24 хэргийг хаах саналтай хүргүүлээд байна. Одоо нийт хэрэг бүртгэлтийн 39, мөрдөн байцаалтын хэрэг 6 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 138.2 сая төгрөгийн хохирол учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 99.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласнаар хохирол нөхөн төлүүлэлт 71.8 хувьтай байна.

Урьд оны дугаартай хэрэг бүртгэлтийн хэрэг 20, урьд оны дугаартай мөрдөн байцаалтын хэрэг 8, нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн 149, нийт шалгасан мөрдөн байцаалтын хэргийн 125 тус тус гмйдэрлэж хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтүүдийг ханган, шийдвэрлэсэн хэрэг бүртгэлтийн хэргийн 118-ыг шийдвэрлэсэн мөрдөн байцаалтын хэргийн 115 хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн байна.

Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг бүртгэлтийн хэргийн илрүүлэлт 70.3 хувьтай болж хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтээс 20 хувиар давсан байна.

ЭХХШТХ-ийн 31.14-р зүйлийн 1.2 дахь хэсгээр түдгэлзүүлсэн 1 хэрэг байсныг оргон зайлсан этгээдийг олж баривчлан хэргийг сэргээн шалгаж байна.

“Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Мөрөн суманд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг баар, зоогийн газрууд, зочид буудлуудад шалгалт явуулсан ба дээрх арга хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг баар, ресторан, зоогийн газар 15, караоке 3, зочид буудал 8 хамрагдсан. Шалгалтаар хадгалалтын хугацаа дууссан 8 төрлийн 99.0 литр пивийг хураан авч холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн.

Цагдаагийн газрын хүлээлгийн танхимд байршуулсан урсдаг зарын самбараар Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан 7 төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, гэмт хэрэг, зөрчлийн талаарх тоон баримтуудыг, LED дэлгэцээр Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, архи согтууруулах ундааны хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн 9 төрлийн шторк, кентентыг байнгын давтамжтайгаар иргэдэд хүргэж үйлчилж байна.

Хэрэг бүртгэх албанаас ирүүлсэн 4 видео контентыг татаж аван орон нутгийн “Далай ээж” “Хөвсгөл” телевизүүдэд өгч олон нийтэд давтамжтайгаар хүргэн ажиллаж байна.

“Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар”-ын facebook хаяг болон тасгийн алба хаагчдын пейж хуудсанд Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг 6, контент 7 татан байршуулж алба хаагчдаар дэмжүүлэн, иргэдэд сурталчилж байна.

-Замын цагдаагийн албаны
чиглэлээр-

2018 онд аймгийн хэмжээнд нийт 235 осол бүртгэгдсэнээс 44 зам тээврийн осолд эрүүгийн хэргийн дугаар авагдсан. Зам тээврийн 36 осолд зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн. Зам тээврийн ослын улмаас 17 хүн нас барж 18 хүн гэмтсэн байна. Бусад 155 ослыг даатгалын байгууллагаар шийдвэрлүүлсэн.

Хөвсгөл аймагт 2018 онд гарсан зам тээврийн
осол хэргийг 2017 оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт

Харьцуулсан хугацаа	Нийт осол	Хэрэг	Осол	Нас барсан хүн	Гэмтсэн хүн	Даатгалаар
2017 он	382	47	71	19	31	264
2018 он	235	44	36	17	18	155
Тоо	-147	-3	-35	-2	-7	-109
Хувь	-62 хувиар	-6	-97	-11 хувиар	-39	-70 хувиар

		хуви ар	хувиар		хувиар	
--	--	------------	--------	--	--------	--

2018 онд тус тасгийн алба хаагчид гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 13724 зөрчил илрүүлэн, зөрчилтэй явсан 13550 жолоочид 480.150.0 мянган төгрөгөөр бэлэн бусаар торгож, 699 тээврийн хэрэгслийг түр саатуулжээ. Үүнээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 630, эрхийн үнэмлэхгүй болон бусад зөрчил 74 илрүүлсэн байна. Нэгдсэн арга хэмжээ 23, хэсэгчилсэн арга хэмжээ 16, бусад байгууллагатай хамтарсан шалгалт 18-г хийж нийтлэг үүргээр 218 зөрчил илрүүлжээ. АСАП сангаар эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн 12 этгээдийг илрүүлэн баривчлан холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.

Харьцуулсан хугацаа	Илрүүлсэн зөрчил	Согтуугаар т/х жолоодсон	Үүнээс		Түр саатуулагдсан т/х
			Эрх хасагдсан	Баривчлагдсан	
2017 он	9945	9177	346,755,000	768	645
2018 он	13724	13550	480.150.000	630	456
Тоо	+3779	+4373	+133.395.000	-138	-189
Хувь	+28%	+32%	+28%	-22%	-41%

“Шинэ жил-Зорчигч тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Шинэ жилийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилгүй өнгөрүүлэх үүднээс “Үгүй” би жолоо барьж байна. Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн Газрын Замын цагдаагийн тасаг гэсэн санамж бүхий зурагт хуудсыг Мөрөн сумын томоохон цэнгээний болон үйлчилгээний нэгжүүдэд байршууллаа. Хамгаалах бүс” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хамгаалалтын бүсний ашиг тусын талаар, хамгаалах бүсийг хэрэглэж хөдөлгөөнд соёлтой оролцохыг уриалж Хөвсгөл аймагт нэр хүндтэй иргэн болох Монгол улсын гавъяат багш Д.Цогтоогоор үг хэлүүлэн дүрсжүүлж богино хэмжээний шторк бэлтгэн орон нутгийн “Лха” телевизээр нэвтрүүллээ.

“Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний явц байдал хяналт шалгалтын талаар Орон нутгийн Мөрөн, Хөвсгөл, Далай ээж, Түмний телевизүүдээр ахлах зохицуулагч, зохицуулагч нар иргэд жолооч нарт тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ачаа тээвэрлэх дүрэм журмыг баримталж явах талаар санамж сэрэмжлүүлэг өгч олон нийтэд хүргэсэн.

Энэ улиралд “Эрхэс”, “Центр” худалдааны төвүүд болон, “Хот тохижолт”, “Мон ажнай” ХХКомпани, “Могойн гол” ХХКомпаниудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон техник замын хяналтын чиглэлээр мэдэгдэл өгсөн. Эрхэс худалдааны төв, “Мон ажнай” ХХКомпани, “Хот тохижилт”, “Могойн гол” ХХКомпаниуд хариуг өгсөн. “Центр” худалдааны төвийн хариу өгөх хугацаа болоогүй байна.

Тус тасгаас энэ улиралд “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Шинэ жил”, “Хамгаалах бүс”, “Мотоцикль”, “Сар шинэ”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт”, “Согтууруулах ундаа-Хөдөлгөөний аюулгүй байдалд” сэдэвт нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион явуулсан. Аймгийн Засаг даргын “Мотоциклийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох тухай” захирамжийн биелэлтийг хангах үүднээс “Мотоцикль” хэсэгчилсэн арга хэмжээг 5 хоногийн хугацаанд зохион явуулсан.

2018 оны 02 дугаар сард Замын цагдаагийн тасгийн дарга орон нутгийн “Түмний телевиз”, “Хөвсгөл” телевизүүдэд сар шинийн баяр амралтын үеэр замын хөдөлгөөнд соёлтой оролцох талаар 2 удаа 10 минутын яриа өглөө. Замын цагдаагийн тасгийн дарга 2 удаа, Зохицуулагч нар мөн 1 удаа хүйтний эрч чангарч, хальтиргаа гулгаа үүсч байгаа, гол мөрний мөсөн дээгүүр зорчихгүй байх, баталгаат зам маршрутаар тээвэрлэлт хийхийн ач холбогдол, Сар шинийн баяр амралтын үеэр хот хоорондын болон сум хоорондын замд хөдөлгөөнд соёлтой оролцох талаар сэрэмжлүүлгийг өгч ажиллаа.

Сар шинийн баяр ёслолын үеэр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байхыг уриалсан “Үгүй” би жолоо барьж байна??? Гэсэн утга санаа бүхий зурагт хуудсыг 20 ширхгийг, “Хамгаалах бүс-Хамгаалах малгай”, “Тэмдэг тэмдэглэл”, “Улсын дугаар”, “Өнгө үзэмж”, “Хурд-үхэл”, “Сар шинэ” зэрэг сэдвийн нийт 550 ширхэг санамж, сэрэмжлүүлгийн хуудас хэвлүүлэн хэвлэмэл зурагт хуудсуудыг томоохон үйлчилгээний төвүүдэд байрлуулж, санамж сэрэмжлүүлгийг жолооч иргэдэд тарааж ажилласан.

Хилийн 0257 дугаар ангийн бие бүрэлдэхүүн болох 65 алба хаагчдад “Замын хөдөлгөөнд оролцоход анхаарах асуудал” сэдвээр 1 цагийн сургалтыг зохион байгуулж, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зарим заалтуудыг тайлбарлан өглөө.

Хатгал тосгон, Ханх сумдын Засаг даргын Тамгын газрын нийт 68 албан хаагчдад Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зарим заалтуудыг тайлбарлан өглөө. Хатгал тосгон, Ханх сумдын хэсгийн алба хаагчдаар нуур руу орох гарахыг хориглосон, замын аюултай хэсгийг анхааруулсан тэмдгүүд нийт 6 цэгт байршуулж ажиллаа. “Хөх сувд-2018” мөсний баярын арга хэмжээний хүрээнд Хатгал тосгоны хэсэг болон, Замын цагдаагийн тасгаас Хориглох болон заах тэмдэг нийт 5 цэгт, Зогсоолын тэмдэг 2 цэгт 4 ширхэгийг тус тус байрлуулсан. Зам тээврийн яам, Замын цагдаагийн албаны Техник замын хяналтын хэлтсээс ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу “Хөвсгөл зам” ХХКомпаний ажилтнуудтай 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 02 дугаар сарын 01-ний хооронд олон улсын чанартай авто зам болох Хатгал-Мондын чиглэлийн замд шаардлагатай тэмдэг, тэмдэглэл тавих, шаардлагатай зам засвар болон арчлалтын ажил хийх үзлэг шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Замын цагдаагийн тасгаас зам тээврийн гэмт хэрэг, ослын “Хар цэг”-ийн криминологи судалгаанд үндэслэн замын цагдаагийн тасгаас 2018 онд зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөөг гарган “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Шинэ жил”, “Хамгаалах бүс”, “Мотоцикль”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт”, “Согтууруулах ундаа-Хөдөлгөөний аюулгүй байдал”, “Хайс хашлага болон авто замын тоноглол”, “Улсын дугаар бүртгэл”, “Замын зорчих хэсгийн гадаргуу болон замын байгууламж”, “Мотоциклийн бүртгэл”, “Бяцхан зорчигч” сэдэвт нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион явуулаад байна.

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан “Шинэ жил”, “Цагаан сар”, “Хөх сувд-2018”, “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Уул уурхайгүй Хөвсгөл”, “Төгсөлтийн баяр”, “Замын хөдөлгөөний цагаан толгой-2018”, “Автомашингүй өдөр-10000 алхам” өдөрлөг, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” зэрэг арга хэмжээ, Монгол улсын ерөнхийлөгч Х.Баттулга, УИХ-ын дэд дарга, шадар сайд нарыг Хөвсгөл аймагт ажиллах үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хөдөлгөөн зохицуулж хяналт шалгалт хийж ажиллаа.

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Авто тээврийн төвтэй хамтран 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж хот хоорондын замд хууль бус нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхлэж байгаа иргэдийн хор уршгийн талаар иргэдэд мэдээлэл өгч орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр авто тээврийн хяналтын улсын байцаагч М.Амарбаясгалан яриа өгч авто тээврийн үндэсний төв, Хөвсгөл авто тээврийн хяналт гэсэн 2 цахим сайтад байршуулан ажилласан.

Бага насны хүүхдүүдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох зорилгоор тус тасгаас зохион явуулж байгаа “ХҮҮХЭД ХАМГААЛАЛ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Мөрөн сумын 1-р цэцэрлэг, Хөвсгөл ард түмний телевизтэй хамтран 20 минутын нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд сурталчилж ажилласан.

Цагдаагийн газрын ажил үйлчилгээг иргэдэд хүргэх, сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Мөрөн сумын 5 дугаар багт байрлах бараан захын Мөрөн худалдаа үйлчилгээний төвийн гадна талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг пүрэв гаригт зохион явуулан үр дүнг тооцон ажилласан

Бага насны хүүхдүүдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох зорилгоор тус тасгаас зохион явуулж байгаа "БЯЦХАН ЗОРЧИГЧ" 1 сарын аяны хүрээнд Мөрөн сумын цэцэрлэгүүдийн дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2018" тэмцээн зохион явуулах төлөвлөгөө, удирдамжийг гарган аймгийн Боловсролын газар, Улаан загалмайн хороотой хамтран 2018.05.12-ны өдөр Эрдмийн далай цогцолбор сургуулийн спорт зааланд зохион явууллаа.

Уг тэмцээнд 12 цэцэрлэгийн нийт 144 багш, баг, тамирчид хурд хүч, авьяас чадвар, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгээрээ өрсөлдөж Тэргүүн байрыг 1 дүгээр цэцэрлэгийн "Хөх сувд" баг, Дэд байрыг 9 дүгээр цэцэрлэгийн "Зохицуулагч" баг, 3 дугаар байрыг 2 дугаар цэцэрлэгийн "Шонхорууд" баг тус тус эзэлж цом, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. Тэмцээнийг Мөрөн сумын Оргил худалдаа үйлчилгээний төв, Гандандаржаалан хийдийн ловон лам М.Мөнхбат нар ивээн тэтгэж гарын бэлэг гардуулсан.

2018 онд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 456 жолоочийн эрхийг хасаж мэдээллийг Цагдаагийн Ерөнхий Газрын Бүртгэл хяналтын төвийн ТПС санд бүртгэлээ.

Аймгийн хэмжээнд авто жолооны сургалт явуулдаг Асгат манхан, Цуурай, Хариад, Энхбадрах, БХТН, ТЭЦО зэрэг 6 авто сургуулиудаас нийт 4558 элсэгчдийг тушаалаар бүртгэн авч Замын хөдөлгөөний хууль, дүрмийн 3706 хүнээс шалгалт авч 2877 хүн тэнцэж, дромын 3662 хүнээс шалгалт авч 3036 хүн тэнцэж, төвийн жолооны 2836 хүнээс авч 2630 хүн тэнцсэнийг дүнг нэгтгэн Замын цагдаагийн тасгийн даргаар хянуулан Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд материалыг хүргүүлсэн. 2018 онд А ангилалд 283, С ангилалд 430, Д ангилалд 166, Е ангилалд 210 жолооч ангилал ахиулсан байна. Жолоочийн 2008 он хүртэлх хуучин шар үнэмлэх солих ажлыг зохион байгуулан 451 жолоочийн материал, мөн үнэмлэхээ гээгдүүлсэн 402 жолоочийн материалыг тус тус хүлээн аван жагсаалтаар Цагдаагийн Ерөнхий Газрын Бүртгэл хяналтын төвд албан тоотоор явуулсан. Эрх сэргээх шалгалтанд орох хүсэлтээ гаргасан 432 жолоочийг "Хөх дархан" төрийн бус байгууллагатай хамтран сургалтанд хамруулж шалгалтыг цахимаар аван шалгалтанд тэнцсэн 317 жолоочийн материалыг Бүртгэл хяналтын төвд хүргүүлэн эрхийг сэргээсэн.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/79 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын үйл ажиллагаанд магдлан шинжилгээ хийх ажлын удирдамжийн дагуу Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн автозасварын ангийн багш Н.Энхболд, Хөдөлмөр хамгааллын яамны мэргэжил боловсрол сургалтын төвийн менежер М.Энхжаргал нар хяналт шалгалтыг зохион явуулсан. Жолоочийн эрх сэргээх шалгалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Техник замын хяналтын чиглэлээр тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэлд тавих үзлэг, шалгалтын нэгдсэн хуваарийн дагуу "Гэрлэн дохио, хяналтын камерт хяналт шалгалт хийх" нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө гаргаж удирдлагаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Мөрөн сумын гудамж зам дахь явган хүний судалгаа, гэрэлтүүлгийн судалгааг гаргаж хүргүүлсэн. Мөрөн сумын 6 дугаар баг 12 дугаар багийн хооронд 0.8 км хатуу хучилттай замыг "Хүслэнт бүтээмж" ХХК тавьж ашиглалтанд оруулсан. Шинээр ашиглалтанд орсон "Номин" худалдаа үйлчилгээний төвийн урд талын автомашины зогсоол, тээврийн хэрэгсэл орж гарах гарц хийх ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлж зааварчилж ажилласан.

Хөвсгөл аймгийн Гандандаржаалин хийд, Монре даатгал, Гурван-Эрдэнэ жуулчны баазтай хамтран Хатгал чиглэлийн хатуу хучилттай замд зам тээврийн осол ихээр давдагдан үйлдэгдэж хар цэгээр тодорхойлсон газарт жолооч нарт анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх, зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Согтуугаар бүү жолоод", "Хамгаалах бүсээ хэрэглэ" гэсэн бичвэртэй гэрэлтдэг самбар 2 ширхэгийг хийж байрлуулсан ба цаашид зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хар цэгээр тодорхойлсон Тосонцэнгэл, Тариалан сумын чиглэлийн хатуу хучилттай замд "Анхаар ядарч байвал амар", "Анхаар Хурдаа тохируул" гэсэн бичиглэлтэй 1x180 хэмжээтэй 5 ширхэг самбарын байрлуулсан.

“Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2018” аяны хүрээнд “Хамгаалах малгай-Хамгаалах бүс” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд зохион явуулж замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоцикль болон тээврийн хэрэгслийн жолооч нарт “Хамгаалах малгай”, “Хамгаалах бүс” хэрэглэж замын хөдөлгөөнд оролцох талаар 2 төрлийн 100 ширхэг санамжийг хэвлүүлэн тарааж орон нутгийн Мөрөн телевизэд жолооч зорчигч нарт хандаж замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч А.Эрдэнэзул зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл өгч арга хэмжээний талаар Замын цагдаагийн албаны Орон нутгийн замын цагдаа, Хөвсгөлийн цагдаагийн газрын цахим сүлжээнд байршуулан үр дүнг тооцон ажилласан.

Сургуулийн хүүхдүүдийн дунд уламжлал болгон зохион байгуулагддаг “Ногоон гэрэл-цагаан шугам-2018” тэмцээнийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Л.Төмөрбаатарын ивээл дор Боловсролын газар, Улаан загалмайн хороо, Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран зохион байгуулж явууллаа. Тэмцээнд Мөрөн сумын Ерөнхий боловсролын 8 сургуулийн 88 хүүхэд 22 багш төлөвлөгөө, удирдамжийн дагуу өрсөлдөж тэргүүн байрыг Эрдмийн далай сургууль, удаах байруудыг Дэлгэрмөрөн, Титэм, Авьяас сургуулиуд эзэлж цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

- Нийтийн хэв журам хамгаалах
албаны чиглэлээр-

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар-

Цагдаагийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрүүд болон Цагдаагийн Ерөнхий Газар, Цагдаагийн газрын зорилт, бодлого чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай ажлаа уялдуулан явуулахад анхаарч ажиллаа.

Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд сар бүрийн 05-ны өдөр аймгийн хэмжээний эрүү хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээлэл болон үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан судалгааг хүргэж мэдээллээр тогтмол ханган ажиллаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /код 227/ журам”-ын 227.2, 227.3, 227.4 дэхь хэсэгт заасныг үндэслэн Цагдаагийн газрын даргын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах тухай 2018.02.01-ний өдрийн А/16 тоот тушаалаар Цагдаагийн газрын тасгуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах ажлын хуваарийг баталгаажуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.1.1, 12 дугаар зүйлийн 12.1.1,12.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 122 төрийн байгууллага, 2 төрийн бус байгууллага, 23 аж ахуй нэгжийг мэргэжлийн удирдлагаар хангаж хамтран ажилласнаас гадна 1445 иргэн, 90 аж ахуйн нэгж, байгууллагын 1445 ажилтан, алба хаагчдыг нийтийн эргүүлд ажиллуулж үр дүнг тооцож ажиллаа. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулагдсан малчдын бүлэг холбоо, нөхөрлөл 132, хөршийн хяналтын бүлэг 125, өсвөрийн сэргийлэгчдийн бүлгэм 21, эцэг эхийн эргүүл ажилласан 10 сургууль, хамтарсан баг 24 үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 4603 иргэн хамрагдсан ба цагдаагийн байгууллагаас дээрх бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд 170 удаа зөвлөмж өгч хамтран ажилласан.

Тус Цагдаагийн газраас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 27 төрлийн санал хүргүүлж батлуулсан ба дээрх төлөвлөгөөтэй уялдуулан 4 бүлэг 38 заалт бүхий салбар төлөвлөгөө боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газраас “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Хөвсгөл аймгийн 2017 оны эрүү хэв журмын нөхцөл байдал, тодорхой төрлийн гэмт хэргийн өсөлт, бууралт, илрүүлэлтийн түвшин, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа ажлын чанар үр дүнд криминологи судалгаа явуулан “Зөвлөмж” боловсруулж 23 сум, 1 тосгоны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт хүргүүлсэн.

2018 оны 01 дүгээр сарын 26-ний өдөр барьцаалан зээлдүүлэх газруудын бүртгэлийг гаргах, шинэчлэн батлагдсан “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний стандарт “MNS: 5274-2017”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор нэгдсэн шалгалт явуулсан. Шалгалтанд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй 14 байгууллага, иргэн хамрагдсанаас Улаанбаатар хотод төвтэй ломбард -2, Байгууллага аж ахуйн нэгжийн харьяа ломбард -3, Банк бус санхүүгийн байгууллага -2, Иргэн -7 байлаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар Цагдаагийн газрын “албан мэдэгдэл”-ийг 12 ломбарданд бичиж “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний стандарт MNS 5274-2017” стандартыг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд сурталчилж ажиллаа.

2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр “Хуулиа мөрдье-21”, “Сэрэмжилье-нэгдье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нартай хамтран 43 цагдаагийн алба хаагч, 12 олон нийтийн цагдааг оролцуулан Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй 19 шатахуун түгээх станц, 2 хийн газ худалдаалдаг цэг, 14 банкны салбар, 220 архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг салбаруудад үзлэг шалгалт явуулж хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга мэдээлэл хийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 220 зөвлөмж, 180 ухуулга сурталчилгааны материал тарааж хуулийн зөвлөгөөг 145 хүнд өгч ажилласан.

Шалгалтаар 4 шатахуун түгээх станц, 58 архи согтууруулах ундаа зарж борлуулдаг цэгт камер байршуулаагүй байсан зөрчлийг арилгуулахаар мэдэгдэл хүргүүлж биелэлтэнд хяналт тавьж эргүүлийн чиглэлд хамруулан ажиллаа.

Тайлангийн хугацаанд нэгдсэн хяналт шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтран 37 удаа 524 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан зохион явуулж 69 зөрчил илрүүлэн 14 иргэнийг Монгол улсын “Зөрчлийн тухай хууль”-иар 950 000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан. Илэрсэн зөрчлийг арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 205 мэдэгдэл, 11 шаардлага бичиж 100 мэдэгдэл шаардлагын хариуг авч 80 мэдэгдэл шаардлагыг газар дээр нь шалгаж ажиллаа.

Цаашид Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд “Архигүй амгалан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр санал оруулснаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар батлуулж хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлүүлсэн.

2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Хэсгийн ахлагч-3” зөвлөгөөнийг зохион байгуулж Мөрөн сумын эрүү хэв журмын нөхцөл байдлыг танилцуулж “Гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөл”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таны оролцоо” сэдвээр мэдээлэл хийж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Тус зөвлөгөөнд “Хөршийн холбоо”-ны 85 ахлагч, гишүүд холбогдох байгууллагуудын төлөөлөл оролцсон. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд малчдын сайн дурын бүлэг-103, “Хөршийн холбоо-125 байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд тэднийг харьяа сумдын хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нар мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байгаа болно.

Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэлтийг ахиулах чиглэлээр “Отолт” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулан ажиллаж эзэн холбогдогч тогтоогдоогүй байсан эрүүгийн 5 гэмт хэргийг илрүүлэн ажиллаа.

Орон нутагт гэмт хэргийн гаралтыг бууруулах ялангуяа хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд аж ахуйн нэгж, иргэдийн анхаарлыг хандуулах, хулгайн гэмт хэргээс

урьдчилан сэргийлэхэд дохиоллын ач холбогдлыг таниулах зорилгоор “Бамбай секьюрити сервис” ХХК-тай мэдээлэл солилцон цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хамтран ажиллахаар санал солилцлоо.

Архи согтууруулах ундаа зарж борлуулах түүгээр үйлчлэх эрхийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан аж ахуйн нэгж, иргэнд дохиол, камер, гадна орчины гэрэлтүүлгийн ач холбогдлыг таниулж газар дээр нь шалгаж зааварчлан илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2012 оны 352 дугаар тушаалаар баталсан “Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох /код 601/ журам, “Тэнсэгдсэн ялтан, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдэд хяналт тавих /код 619/ журам”-ыг удирдлага болгон хорихоос өөр төрлийн ялаар 79 ялтан захиргааны хяналтанд байсан, хяналтаас хассан 20, одоо хяналтанд байгаа 59, үүнээс шүүхээр тэнсэн суллагдсан 52, хорих ял эдлээд суллагдсан 7, биечлэн уулзаж зөвлөгөө өгсөн 59, дахин гэмт хэрэгт холбогдсон 1,

2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт аймгийн Прокурорын газрын туслах прокурор Б.Болдтой хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/242 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам”, “Хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн ялтанд тавьж буй хяналт, цаашид анхаарах асуудлууд” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад судлан тогтоож, гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар хэрэг бүртгэгч, мөрдөгчийн мэдэгдэл 119-г бичиж 108 мэдэгдэлд хариуг авч ажилласан. 11 мэдэгдлийн хариу ирүүлэх хугацаа болоогүй байна.

2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Мөрөн сумын 10, 11, 14 дүгээр багийн Засаг дарга нарт бичсэн мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр шалгах ажиллагаа явуулсан ба нийт 9 мэдэгдэл хүргүүлсэний 8 мэдэгдлийн хариуг хуулийн хугацаанд ирүүлсэн. 1 мэдэгдлийн хариу ирүүлэх хугацаа болоогүй байв. Багийн засаг дарга нар мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлаа материалжуулсан байлаа.

Төр захиргааны байгууллагуудын дарга нарт сонор сэрэмжээ дээшлүүлэх, гадна орчины гэрэлтүүлгээ сайжруулах, камер байршуулах талаар Цагдаагийн газрын даргын “Албан мэдэгдлийг 38 байгууллагад хүргүүлж биелэлтийг тооцсон. 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд бичсэн мэдэгдлийн мөрөөр шалгах ажиллагаа явуулсан бөгөөд Аймгийн Музей, Номын сан, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газрын гадна гэрэл ажиллахгүй байсныг хэвийн ажиллагаатай болгохыг үүрэг болгосон.

.Аймгийн Прокурорын газраас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх ажил зохиолгохоор бичсэн мэдэгдлийн хариуг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй 9 сумын холбогдох албан тушаалтанд Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар 900 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ноогдуулсан.

”Нээлттэй хаалганы өдөр “ арга хэмжээг 10 удаа зохион байгуулж 6854 иргэнийг хамруулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сурталчилах чиглэлээр 1544 санамж сэрэмжлүүлэг, гарын авлага материал тарааж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон “Хэрэглэгчийн үнэлгээний санал асуулга” авч дүгнэсэн. Иргэдээс 69 санал хүсэлт авч шийдвэрлэсэн болно. Цагдаагийн газрын үйл ажиллагааг сурталчилж, иргэдэд мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа.. Өдөрлөгт оролцсон иргэдэд архидан согтуурах, цахим гэмт хэрэг, пирамид тогтолцооны сүлжээний бизнес, хар тамхи мансууруулах бодис, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлыг эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, хүн худалдаалахтай тэмцэх талаарх гарын авлага, тараах материал 2456 ширхэгийг тараасан. Мөн тус Цагдаагийн газрын үйл ажиллагааны өнөөгийн байдал, цагдаагийн алба хаагчдын ёс зүйн асуудал, үйлчилгээний чанар, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилго бүхий “Цагдаагийн байгууллагын өнөөдөр, маргааш” судалгааг 456 иргэнээс авсан. Орон нутгийн “Мөрөн”, “Хөвсгөл”, “ЛХА” телевизээр “Нээлттэй хаалганы өдөр”-ийн үйл

ажиллагааг иргэдэд сурталчилж шаардлагатай мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллаа. “Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар” фейсбүүк хаягт мэдээ мэдээллүүдийг тухай бүр нь байршуулж ажилласан.

Орон нутгийн “Мөрөөдлийн мөрөн-101,5” FM радиотай хамтран хулгайлах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэг, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн сэрэмжлүүлгийг өдөр бүр байнгын давтамжтайгаар, ярилцлагыг 29 удаа, орон нутгийн “Хөвсгөл”, “ЛХА” “Мөрөн”, телевизүүдээр тодорхой төрлийн /орон байр, мотоцикль, мал хулгайлах, сүлжээний бизнес, залилан мэхлэх, хүн худалдаалах, цахим гэрт хэргийн хохирогч болохгүй байх, стандартын шаардлага хангахгүй архи согтууруулах ундаа худалдан авахгүй байх, учрал золгүй байдал, согтуугаар гэмт хэрэгт өртөж амь нас эрүүл мэндээрээ хохирох, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болон тухайн цаг үе, үйл явдалтай холбогдуулан сэрэмжлүүлэг яриа, мэдээ мэдээллийг 28 удаа /давхардсан тоогоор 84 удаа/, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 4 удаа /давхардсан тоогоор 12 удаа/ иргэд олон нийтэд хүргэж ажиллаа.

2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр орон нутгийн “Хөвсгөл” телевизээр “Гэрч хохирогчийг хамгаалах хуулийн хэрэгжилт” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг бүрэн эхээр нь иргэд олон нийтэд хүргэсэн.

“Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар” facebook хаягт цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах, алдаршуулах чиглэлээр 64 удаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх 40, нийт 104 мэдээ мэдээллийг байршуулж ажиллаа.

Цагдаагийн газрын хүлээлгийн танхимд байршуулсан урсдаг зарын самбараар тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, гэмт хэрэг зөрчлийн талаарх тоон баримтуудыг, LED дэлгэцээр зам тээврийн осол, орон байрны хулгай, цахим, сүлжээний бизнес, хар тамхи мансууруулах бодис, архи согтууруулах ундааны хор уршиг, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн 15 төрлийн шторкыг байнгын давтамжтайгаар иргэдэд хүргэж үйлчилж байна.

Мөн хүлээлгийн заалны самбаруудад тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гарын авлага, тараах материал 650 ширхэгийг байршуулж иргэдэд хүргэсэн.

“Мөрөөдлийн мөрөн-101,5” FM радиотай хамтран хулгайлах гэмт хэрэг, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн сэрэмжлүүлгийг өдөр бүр байнгын давтамжтайгаар, орон нутгийн “Хөвсгөл”, “ЛХА” “Мөрөн”, телевизүүдээр тодорхой төрлийн /орон байр, мотоцикль, мал хулгайлах, архи тамхины хор уршиг, учрал золгүй байдал, согтуугаар гэмт хэрэгт өртөж амь нас эрүүл мэндээрээ хохирох, гол усны үерийн аюул, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болон тухайн цаг үе, үйл явдалтай холбогдуулан сэрэмжлүүлэг яриа, мэдээ мэдээллийг 52 удаа /давхардсан тоогоор 151 удаа/ иргэд олон нийтэд хүргэж ажиллаа.

Цагдаагийн ерөнхий газар-2 аймгийн Засаг дарга, удирдлагуудад 13, Аймгийн ГХУСА33-д 9, сумын Засаг даргад 3, сумын ГХУСА33-д 5 нийт 32 удаагийн танилцуулгаар 34 саналыг хүргүүлж, шийдвэрлэлт 50 хувьтай байна.

Төсөвт төвлөрсөн нийт торгуулийн мөнгөн дүн 575712800, цагдаагийн байгууллагын төсөвт тушаасан мөнгөн дүн 1214507000, үүнээс 40 хувьтай тэнцэх мөнгөн дүн 48580280 төгрөг, ГХУСА33 санхүүжүүлсэн 5938400 төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 5938400 төгрөг зарцуулсан байна.

Сургалт мэдээлэл сурталчилгаа 196, уулзалт хэлэлцүүлэг 37, өдөрлөг 13, уралдаан тэмцээн 2, нийт 248 хуулга яриа, сургалт сурталчилгаа хийсэн ба үүнд 584 байгууллага, аж ахуй нэгж, 36618 иргэн хамрагдсан байна. Иргэдэд 3860 ширхэг гарын авлага, 1588 ширхэг зурагт хуудас, 18085 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, нийт 23538 ширхэгийг тараасан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор 489 мэдэгдэл бичиж, 420 д нь хариуг авч, 69 нь ажиллагаанд байна. Мөн 8 шаардлага бичиж хариуг нь тухай бүрт нь хариуг нь авч биелэлтийг нь шалгаж ажиллаа.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй 102 иргэнийг судалгаа хяналтын санд бүртгэн, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх талаар баталгаа гаргуулан, сар бүр ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгч ажиллаа.

Гарын авлага 25, зурагт хуудас 83, санамж, сэрэмжлүүлэг 21975, нийт 22089 ширхэгийг иргэдэд тарааж, гудамж талбай олон нийтийн газарт байрлуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд зохион явуулсан нэгдсэн арга хэмжээ 30, Цагдаагийн газраас 16, хэсэгчилсэн 50 арга хэмжээ, 84 нэгдсэн үзлэг шалгалтыг зохион явуулан ажиллаа.

Малчдын бүлэг 132, хөршийн хяналтын бүлэг 125, өсвөрийн цагдаагийн бүлэг 33, хамтарсан баг 38, сургуулийн эргүүл 19, нийт гишүүдийн тоо 7243 байна. Мэргэжил арга зүйн удирдлагаар 94 удаа хангаж ажиллаа.

2018 онд орон нутгийн хэмжээнд эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж “Шинэ жил”, “Зорчигч тээвэрлэлт”, “Жагсаал”, “Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис”, “Мотоцикль”, “Бурхан”, “Ачааны автомашин бүрэн бүтэн байдал”, “Архидалт бууруулья-1”, “Архидалт бууруулья-2”, “Ноолуур”, “Төгсөлт”, “Ургац 2018”, “Оюутан тээвэр-2,” “Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл”, “Хамгаалах бүс, хамгаалах малгай”, “Эко 2018”, “Илрүүлэлт оргодол шийдвэрлэлт”, “Хичээлийн шинэ жил”, “Unfriend”, “Хамтдаа сэргийлье” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцон ажиллаа.

- Архидан согтуурахтай тэмцэх талаар-

Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай, Зөрчлийн тухай хуулиудыг олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах, хүүхэд залуучууд, олон нийтэд нөлөөллийн ажлыг өрнүүлэх зорилгоор "Хуулиа мөрдье -21" аяныг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн Хэлтэс, Хүүхэд Гэр Бүл Залуучуудын Хөгжлийн Газар, Мэргэжлийн Хяналтын Газар, “Төгс зохицол” төрийн бус байгууллага, “Сүүн тахилт” төрийн бус байгууллагуудтай хамтран 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд өрнүүллээ.

Цагдаагийн газраас офицер 33, цагдаа 41, олон нийтийн цагдаагийн ажилтан 14 нийт 87 алба хаагч 16 автомашинтай үүрэг гүйцэтгэж ажилласнаас гадна нэгдсэн арга хэмжээний үеэр шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэхээр Цагдаагийн газрын удирдлага болон сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 7 санал оруулж 3428401 төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Аяны хүрээнд хэсэгчилсэн арга хэмжээ 18, өдөрлөг 9, хэлэлцүүлэг 7, сургалт 59, уулзалт 47-г зохион байгуулж 920 оюутан, 4084 сурагч, 925 иргэнд Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, хүнсний аюулгүй байдал, аймгийн эрүү хэв журмын нөхцөл байдал, архины хор хөнөөлийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэж 4415 гарын авлага, зурагт хуудас, санамж сэрэмжлүүлгийг тараасан.

2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд Мөрөн сумын 14 багийн иргэдтэй “Уулзалт” зохион байгуулж архины хор хөнөөлийг таниулахад чиглэсэн яриа таниулга, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийсэн. Өдөрлөгийн ажиллагаанд 14 багийн 667 иргэн хамрагдсан бөгөөд архины хор хөнөөл, насанд хүрээгүй хүүхдэд архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх санамж зөвлөмж 463 ширхэгийг тарааж үйлчилсэн.

2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газрын ажилтнуудтай хамтран Мөрөн суманд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг вар, зоогийн газрууд, зочид буудлуудад шалгалт явуулсан ба дээрх арга хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг вар, ресторан, зоогийн газар 15, караоке 3, зочид буудал 12 хамрагдсан. Шалгалтаар хадгалалтын хугацаа дууссан 8 төрлийн 99,0 литр пивийг хураан авч аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч зөрчил илэрсэн 8 вар, зоогийн газрын эздэд Цагдаагийн газрын “мэдэгдэл” хүргүүлж биелэлтийг тооцож ажиллаа.

Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай, Архидан согтуурах, хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгах, гаралтыг сааруулах зорилгоор “Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээг Мөрөн сумын Засаг даргын тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, “Төгс зохицол”, “Сүүн тахилт”, “Санаа нэгт нөхөд” төрийн бус байгууллагуудтай хамтран 2018 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд өрнүүллээ.

Аяны хүрээнд өдөрлөг 1, сургалт сурталчилгаа 6-г зохион байгуулж төрийн алба хаагч 185, оюутан сурагч 120, хөршийн холбооны ахлагч 85 иргэнд Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, “Хорт зуршлаас сэргийлье”, “Монгол улсын Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйл” “Гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөл”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таны оролцоо”, “Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөл” сэдвээр мэдээллийг хүргэж 440 зурагт хуудас санамж сэрэмжлүүлгийг тараасан.

Арга хэмжээний хүрээнд Мөрөн сумын Засаг даргын тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, “Сүүн тахилт”, “Төгс зохицол”, “Санаа нэгт нөхөд” төрийн бус байгууллагуудтай хамтран гэр орон, орчин тойрондоо хэрүүл маргаан үүсгэж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг болон архины хамааралтай иргэдэд архины хор хөнөөл түүнээс урьдчилан сэргийлэх талаар нөлөөллийн сургалтыг зохион байгуулж сургалтанд хамрагдсан иргэдийг ар гэр асран хамгаалагч нарт нь болон багуудын Иргэд нийтийн хурлын дарга нарт хүлээлгэн өгч 21 иргэнийг “Сүүн тахилт” төрийн бус байгууллагын сайн дурын эмчилгээнд өөрсдийн нь хүсэлтээр хамруулсан.

Гэр орон сууцандаа архидан согтуурч, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг 5 айлыг илрүүлж “Сүүн тахилт” төрийн бус байгууллагын донтолт судлаач багш Б.Бямбажаваар ганцаарчилсан сургалтуудыг зохион явуулсан.

“Хөвсгөл аймгийн нэгдсэн зар” /82031 гишүүнтэй/, “Хөвсгөлчүүд” /12098 гишүүнтэй/, “Хөвсгөлийн залуус бид Мөрөнчүүд” /731 гишүүнтэй/, “Хөвсгөл аймгийн нэгдсэн зар мэдээ” /7662 гишүүнтэй/, “Хөвсгөл аймгийн залуус” /8291 гишүүнтэй/, “Бүх Хөвсгөлчүүд энд” /77464 гишүүнтэй/, “Хөвсгөлийн залуусын нэгдэл” /797 гишүүнтэй/, “Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар” /3386 гишүүнтэй/ Facebook цахим хаягуудад 5 төрлийн шторкуудыг байршуулж /шейрлэж/ иргэд олон нийтэд сурталчилж ажиллаа.

Тайлангийн хугацаанд нэгдсэн хяналт шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтран 39 удаа 524 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан зохион явуулж 69 зөрчил илрүүлснээс архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүй, гар дээрээс архи согтууруулах ундаа худалдан борлуулж байсан “Хэрлэн”, “Хүрмэн”, “Норовлин” хүнсний дэлгүүр, “Сод сүлжээ”, “Жес трейд” ХХК-ны хүнсний дэлгүүрээс 1694 литр архи согтууруулах ундаа хураан авч зөрчил гаргасан 19 иргэнийг Монгол улсын “Зөрчлийн тухай хууль”-ийн 6,5 хэсгийн 13 дахь хэсэгт зааснаар 1 650 000 төгрөгөөр, мөн 21 насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаа худалдаалсан 2 цэгийг 40 000 төгрөгөөр тус тус торгож арга хэмжээ тооцсон. Илэрсэн зөрчлийг арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 205 мэдэгдэл, 11 шаардлага бичиж хүргүүлэн биелэлтийг тооцож ажиллаа.

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тамхи худалдан борлуулах зөвшөөрөлтэй болон Ерөнхий боловсролын сургуулиас 500 метр дотор байрлах 124 хүнсний дэлгүүрт хяналт шалгалт явуулж “Тамхины хяналтын тухай” хуулийн 6,3 дугаар зүйлийн 2,4 дэхь хэсгийг зөрчин тамхи худалдан борлуулж байсан 10 зөрчил илрүүлж 30 хайрцаг тамхийг хураан Мөрөн сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлсэн ба зөрчил гаргасан 10 иргэнийг 3 сая төгрөгөөр тус тус торгож арга хэмжээ тооцсон.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд “Архигүй амгалан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр санал оруулснаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Архигүй амгалан” хөтөлбөрийн хүрээнд “Архидалтыг бууруулах” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 2 үе шаттайгаар аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хууль эрх зүйн хэлтэс, Мөрөн сумын Засаг даргын тамгын газар, “Сүүн тахилт”, “Хоймор сайхан”, “Төгс зохицол” төрийн бус байгууллагууд, аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасагтай хамтран зохион явууллаа.

Архинд донтох эмгэгтэй болон архины хамааралтай сайн дурын эмчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан 75 иргэнийг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн

дотуур байранд байрлуулж 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд вакумжуулсан сургалтанд хамрууллаа. Сургалтанд хамрагдсан иргэдийг сорил болон эрүүл мэндийн үзлэгт хамруулж, өдөрт 1 удаа хордлого тайлах болон эмчийн эмчилгээ хийж 50 иргэнийг рентген шинжилгээнд, 2 иргэнийг нарийн мэргэжлийн шинжилгээнд тус тус хамрууллаа.

Архинаас татгалзах сайн дурын вакумжуулсан сургалтанд хамрагдсан иргэдэд Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасаг, “Сүүн тахилт”, Хоймор сайхан”, “Төгс зохицол” төрийн бус байгууллагуудтай хамтран өрөө өрөөнд болон ганцаарчлан халуун яриа өрнүүлэх, архинаас хэрхэн татгалзах арга замуудын талаар яриа өрнүүлж, хөгжөөнт тоглоом тоглуулах зэрэг нөлөөллийн арга хэмжээг өдөр бүр зохион байгуулж ажиллаа.

Аймгийн Засаг дарга Л.Ганболд сургалтанд хамрагдсан иргэдтэй уулзаж жижиг дунд бизнес эрхлэхэд хөнгөлөлттэй зээл олгох, ажлын байраар хангаж дэмжлэг үзүүлж хамтран ажиллахаа илэрхийлж “Сертификат” гардуулсан.

Хөтөлбөрийн хүрээнд Мөрөн сумын Засаг даргын тамгын газартай хамтран архины хамааралтай, амьжиргааны түвшин доогуур зорилтот бүлгийн 2 иргэнийг очиж ар гэрт нь тусламж үзүүлсэн.

Бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг давхардсан тоогоор 479 цэг салбарыг хамруулан 6 удаа үзлэг шалгалт хийж 6 зөрчлийг илрүүлэн арилгуулж, зөрчил гаргасан 6 хүнд 520.000 мянган төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж, Монгол Улсын архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн нөхцөл шаардлагыг ноцтой зөрчиж хууль бусаар архи согтууруулах ундааны зүйлийг худалдан борлуудаг Мөрөн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Гэрэлтэй цонх” нэртэй үйл ажиллагаа явуулдаг газраас 218.2 литр согтууруулах ундааг хурааж зохих журмын дагуу шалгаж шийдвэрлэжээ.

Архидалтыг бууруулах зорилгоор архины хамааралтай болон архийг хэтрүүлэн хэрэглэдэг 36 иргэнд Цагдаагийн газрын хурлын танхимд “Сүүн тахилт” төрийн бус байгууллагын донтолт судлаач багш Б.Бямбажаваар архины хор хөнөөл түүнээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга, явуулж ар гэр асран хамгаалагч, харгалзан дэмжигч, баг хариуцсан багийн дарга нар, 14 багийн иргэд нийтийн хурлын дарга нартай хамтран нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Архинаас татгалзах сайн дурын эмчилгээнд Мөрөн сумын 11 хүнийг хамруулан ажиллаа. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх, гар дээрээс стандартын бус шаардлага хангахгүй архи согтууруулах ундааг худалдан авахгүй байх, согтуугаар гэмт хэрэг, зөрчил үйлдэх, өртөж хохирох, амь насаа алдах тохиолдолоос урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн “ЛХА”, “Мөрөн” телевизүүдээр сэрэмжүүлэг мэдээллийг хийж, архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэнээс үүдэлтэй сөрөг үр дагаврын талаар 3 төрлийн 620 ширхэг санамж сэрэмжүүлэгийг тараан ажиллалаа.

- Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар-

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдээс үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтарч ажиллах хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор үйл ажиллагаа явуулж байна.

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдээс үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтарч ажиллах хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд, залуучуудын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран “Хуулиа мөрдье “арга хэмжээг зохион байгуулсан. Аяны хүрээнд Мөрөн сумын ерөнхий боловсролын сургууль 11 сум орон нутгийн 4 сургуулийн 475 багш ажилчид, 4789 сурагч оюутан, 743 эцэг эхчүүдийг хамруулан “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт ” гэсэн сэдвийн хүрээнд 36 цагийн сургалт зохион байгууллаа. Тухайлбал 2018 оны 01 дүгээр сарын 29-ний

өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд Аймгийн мэргэжлийн хяналтын газар, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, болон Зөрчлийн тухай хуулиудыг эцэг эх хүүхдүүдэд сурталчилан таниулах, өсвөр үе залуучуудад архины хор уршгийг ойлгуулах, хорт зуршлыг үл тэвчих хандлага, арга барил бий болгох, тэдгээрээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 8-12 ангийн 900 сурагч, 800 гаруй эцэг эхийн төлөөллийг оролцуулсан байна. Тухайн сургалтанд эцэг эхчүүд хамрагдсанаар хүүхэддээ тавих анхаарал, хараа хяналтаа сайжруулж, цахим орчны сөрөг нөлөө, хорт зуршилд автах гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарч ажиллах нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

2018 оны 02 дугаар сарын 08, 26 ны өдрүүдэд Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдтэй хамтран Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа РС, цахим тоглоомын газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд үйл ажиллагаа явуулж байгаа 9 цахим тоглоомын газар хамрагдсан бөгөөд илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй үйл ажиллагаа явуулж байсан 2 цахим тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоосон байна.

2018 оны 02 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар Дэлхийн зөн олон улсын байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтарч Хамтарсан багийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан.

Уулзалтанд “ Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэд , хүүхдүүдэд арга хэмжээ авч ажиллах ” гэсэн сэдвээр мэдээлэл хийсэн. Мөн 2018 оны 02 сарын 28 ны өдөр Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтарч гэр бүл хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд ” Эрүүл аюулгүй гэр бүл” сэдэвт “хамтарсан зөвлөгөөн зохион явууллаа. Зөвлөгөөний үеэр Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хэлэлцэж, цаашид явуулах арга хэмжээний талаар хэлэлцсэн.

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэх, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдөр хуралдсан Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хуралд аймгийн хэмжээнд хүүхдээс үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн шалтгаан нөхцөл, цаашид анхаарч ажиллах талаар мэдээлэл хийсэн.

2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Мөрөн Гурван-Эрдэнэ сургуулийн багш ажилчдад Эрүүгийн, Зөрчлийн, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар 2 цагийн сургалт зохион байгуулж сурталчиллаа. Сургалтанд тухайн сургуулийн 65 багш, ажилчид хамрагдсан.

2018 оны 03 дугаар сарын 12-17-ны өдөр хүртэлх хугацаанд Мөрөн сумын Засаг даргаар ахлуулсан Мөрөн сумын хамтарсан багийн бүрэлдэхүүнийг чадавхижуулах болон туршлага солилцох ажилд оролцож Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй Налайх дүүрэг болон Төв аймгийн Зуун мод сум, Сүхбаатар сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Дархан-Уул аймгийн хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцсан.

Цагдаагийн Ерөнхий газраас ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу Хурдан морины уралдааны үед гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх, ялангуяа унаач хүүхдүүдийг бэртэж гэмтэх, амь нас хохирохоос урьдчилан сэргийлэх, хурдан морины уралдааныг 05 дугаар сарын 01 ний өдрийг хүртэлх хугацаанд аймаг сум, багт зохион байгуулахгүй байх талаар мэдэгдэл бичиж бүх сумдын засаг дарга болон удирдлагуудад хүргүүлж, биелэлтэд нь хяналт тавих ажлыг зохион байгууллаа.

2018 оны 04 дүгээр сарын 01-06 хүртэлх хугацаанд улаанбаатар хотод болсон Хүүхдийн өөрийн удирдлагын сайн туршлага судлах сургалтанд мөн 2018 оны 04 дүгээр сарын 10-14 хүртэлх хугацаанд Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зохион явуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдэвт Үндэсний 2 дугаар чуулганд оролцсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн 23 төрлийн шторк санамж сэрэмжлүүлгийг “Хөвсгөл Хүүхдийн алба”, “ Хөвсгөлийн зар”, “Хөвсгөл аймгийн цагдаагийн газар” гэсэн цахим хаяганд байршуулан иргэдэд сурталчиллаа.

2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн захиргааны “Соёмбо” танхимд сургуулийн захирал, нийгмийн ажилтан, багийн дарга нарт Хамтарсан багийн үйлчилгээн дэх цагдаагийн байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа гэсэн сэдвээр сургалтыг зохион байгууллаа.

2018 оны 04 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтарч Жаргалант, Шинэ-Идэр, Төмөрбулаг, Галт сумын хамтарсан багийн гишүүдийн дунд “Хариуцлагатай хамтарсан баг” бүсийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, сургалтыг зохион байгуулж ажилласан.

“Хүүхэд хамгаалал” арга хэмжээний биелэлт үр дүнг тооцож цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэст хүргүүлсэн.

“Хөгжилд хамтдаа” Аймгийн хүүхдийн чуулганд оролцож Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, Мөрөн сумын нийгмийн ажилтан, Титэм, Эрдмийн далай сургуулийн нийгмийн ажилтан нартай хамтарч Хүүхдийн хамгаалал-хамтын ажиллагаа салбар хуралдааны чиглүүлэгчээр ажилласан.

Замын цагдаагийн тасгийн алба хаагчидтай хамтран “Бяцхан зорчигч” арга хэмжээг зохион байгуулж нээлтийг “Дэлгэрмөрөн” сургуулийн урлаг зааланд зохион явууллаа. Арга хэмжээний нээлтэнд бага, дунд ангийн 240, ахлах ангийн 13, хүүхэд 7 багш сурган хүмүүжүүлэгч, 27 эцэг эх хамрагдсан. Нээлтийн арга хэмжээний хүрээнд “Аюулгүй замын хөдөлгөөнд оролцох нь”, “Бага насны хүүхдийг бие даалган замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх”, хэрэв оролцуулсан бол эцэг эхэд оногдуулах хариуцлага”, “Хүүхдийг тээврийн хэрэгслээр буруу тээвэрлэснээс үүсэх сөрөг үр дагавар” сэдвүүдээр яриа хийж хүүхдүүдэд сэрэмжлүүлэх зорилгоор “Шүгэлхүүгийн адал явдал” шторкийг үзүүлж тайлбар, мэдээллийг өгөх ажлыг зохион байгууллаа. Мөн нээлтийн арга хэмжээг орон нутгийн “ЛХА”, “Мөрөн” телевизээр олон нийтэд сурталчиллаа.

Ерөнхий боловсролын сургууль төгсөх, төгсөлтийн баярын үйл ажиллагааг архи согтууруулах ундааны зүйлгүй, гэмт хэрэг эрх зүйн зөрчилгүй тэмдэглэх, баярын үеэр сургуулийн эцэг эхийн зөвлөл, багш нарын хамтарсан эргүүлийг зохион байгуулах талаар “Мэдэгдэл”, “Санамж”-ыг Мөрөн сумын 10 сургууль, сум орон нутгийн сургуулиудад хүргүүлж, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сургууль төгсөх төгсөлтийн баярын үеэр “Төгсөлт” арга хэмжээг Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Мөрөн сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газрын алба хаагчид, Олон нийтийн цагдаа нартай хамтарсан эргүүлүүдийг ажлуулж, арга хэмжээг ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтарч “1000 хүүхдийн инээмсэглэл” арга хэмжээний хүрээнд Олон улсын Хүүхдийн эрхийн өдрөөр амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн 20 хүүхдэд алба хаагчдаас бэлтгэсэн гарын бэлгийг тарааж өгөх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын газрын мэргэжилтнүүдтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сургууль төгсөх элсэлтийн шалгалтын үеэр сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын багш, нийгмийн ажилтнуудтай хамтарч ажиллаа.

Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүүхэд хамгааллын чиглэлээрх шторк, санамж сэрэмжлүүлгийг хөвсгөл аймгийн хандалт ихтэй Хөвгөл аймгийн нэгдсэн зар, Хоймор нутгийн залуус, Хөвсгөл хүүхдийн алба гэсэн цахим хаягуудад шэйрлэж олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгууллаа.

Хүүхдийг үер усны аюул, аливаа болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамтдаа сэргийлье” аяныг Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын “Хөвсгөл” орон нутгийн хэлтэстэй хамтарч аймгийн хэмжээнд 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс мөн оны 8 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулан ажиллаа.

“Хамтдаа сэргийлье” арга хэмжээний хүрээнд Хатгал, Алаг-Эрдэнэ сум, тосгонд 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “Сарлаг наадам”-ыг

тохиолдуулан Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтарч иргэдэд хүүхэд хамгааллын сэдвээр яриа таниулга хийж, гарын авлага тарааж, Хатгал тосгоны усан онгоцны зогсоол, зам дагуух үйлчилгээний төвүүдэд санамж байршуулж, сэрэмжлүүлэг өгч, 800 ширхэг сэрэмжлүүлэх материалыг тараах ажлыг зохион байгууллаа.

2018 оны 7 дугаар сарын 23-ны өдөр “Уран дөш” хүүхдийн зусланд сургалтанд хамрагдаж буй Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын “Хөвсгөл” орон нутгийн хэлтэстэй “Төгсөлтийн аргачлал”-ын сонгогдсон өрхүүдийн 158 иргэнд Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар хамтран үер ус, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч сургалтыг зохион байгууллаа. Мөн “Авьяас” сургуулийн амрагч 150 хүүхдэд хүүхэд хамгааллын чиглэлээр яриа таниулга хийж, гарын авлага тарааж, зөвлөгөө өгч зуслангийн байруудад санамж байршуулж, сэрэмжлүүлэг өглөө.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Хичээлийн шинэ жил”, “UNFRIEND” арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил арга хэмжээний биелэлт үр дүнг тооцсон.

2018 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Аймгийн Боловсрол соёл урлагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтарч ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрын багш нарт “Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирохоос урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд 2 цагийн сургалт зохион байгуулж, тухайн хичээлийн жилд цагдаагийн газар, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтарч сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдож хохирохоос урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр хамтарч ажиллах ажлын чиглэл өглөө.

Хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаатай холбогдуулан сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор алба хаагчдыг сургууль бүрт хувиарлан сургуулийн орчимд цагдаагийн хөдөлгөөнт эргүүлийг ажлуулсан нь үр дүнгээ өгч тухайн цаг хугацаанд гэмт хэрэг зөрчил бүртгэгдээгүй.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “UNFRIEND” арга хэмжээний хүрээнд аймгийн Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр прэмм 2 ширхэг мөн албан байгууллага, сургуулийн орчмоор наах Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн баннер 100 ширхэгийг хэвлүүлж иргэдэд сурталчлахаас гадна Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээрх шторк, санамж сэрэмжлүүлгийг Хөвсгөл аймгийн хандалт ихтэй Хөвсгөл аймгийн нэгдсэн зар, Хоймор нутгийн залуус, Хөвсгөл хүүхдийн алба, Мөрөн сумын хамтарсан баг гэсэн пэйж хаягуудад шэйрлэж олон нийтэд тогтмол сурталчиллаа.

Арга хэмжээний хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газрын ажилтан, алба хаагчид болон Сод-Эрдэм, Эрдмийн далай, Ирээдүй, 2 дугаар сургууль, Гурван-эрдэнэ, сургуулийн ахлах ангийн 4350 сурагчид unfriend хөдөлгөөн, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр мэдээлэл өглөө.

Мөн хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан оюутан сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 34 сургуулийн захирал удирдлагуудад “Зөвлөмж” бичиж хүргүүллээ.

Гэмт хэрэгт холбогдож болзошгүй 25 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирлоо гэх 13 иргэнтэй нэг бүрчлэн уулзаж зөвлөгөө өглөө.” Хичээлийн шинэ жил ” арга хэмжээний хүрээнд Дэлхийн зөн, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн нартай хамтарч Сод эрдэм сургуулийн 10 б ангийн 27, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны 150, Рашаант сумын 12 жилийн ахлах ангийн 120 сурагчид 4 цагийн сургалт зохион байгуулсан.

Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, сүүн тахилт төрийн бус байгууллагатай хамтран “Хорт зуршил, Хүүхдийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэхэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж явууллаа. Сургалтанд Хилийн 0257 дугаар анги, Хөвсгөл эрчим хүч ХХК, Зэвсэгт

хүчний 0321 дүгээр тусгай салбар, Төрийн банк, Хөвсгөл дулааны станц, ХААН банк, ХАС банк, Татварын хэлтэс, Онцгой байдлын газрын алба хаагчид, Ерөнхий боловсролын сургуулиудын эцэг эхийн төлөөлөл, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн сурагчид хамрагдлаа. Сургалтыг тухайн байгууллага, аж ахуй нэгж бүр дээр 2 цагийн нийт 28 цагийн сургалт зохион байгууллаа.

2018 оны 10 дугаар сарын 17, 18-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлгэрмөрөн цогцолбор сургууль, Авъяас сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдын “Эцэг эхийн зөвлөгөөн”-нд оролцож эцэг эчхүүдэд “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”-аар мэдээлэл хийж насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж хамтран ажиллах талаар анхааруулж ажиллаа. Сургалтанд 9 бүлгийн 315 эцэг эх хамрагдлаа.

2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Хэрэг бүртгэх тасгаас зохион байгуулагдсан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож “Хүүхдийн эрүүл мэндийн халдашгүй байдал” сэдвээр мэдээлэл бэлтгэж илтгэл тавьж оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудтай уулзаж сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирох, архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх талаар сургууль бүр ажил зохион байгуулж хамтарч ажиллах талаар мэдээлэл хийлээ.

2018 оны 10 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтанд хамрагдлаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Цахим орчинг зөв болгоё” гэсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчдыг нэгдүүлж, Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүүхэд хамгааллын чиглэлээрх шторк, санамж сэрэмжлүүлгийг хөвсгөл аймгийн хандалт ихтэй Хөвсгөл аймгийн нэгдсэн зар, Хоймор нутгийн залуус, Хөвсгөл хүүхдийн алба гэсэн пэйж хаягуудад шэйрлэж олон нийтэд тогтмол сурталчиллаа.

2018 оны 11 дүгээр сарын 12-30 ны өдөр хүртэлх хугацаанд Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Камержуулалт” арга хэмжээг зохион явуулсан. Арга хэмжээнд Мөрөн сумын 14 баг, 23 сум, 1 тосгоны 1152 аж ахуй нэгж, байгууллага, дэлгүүр үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийж зөрчил дутагдлыг арилгаж, ажил арга хэмжээ зохион байгуулж хариу мэдэгдэх тухай мэдэгдэл хүргүүлсэн байна.

- Хэсгийн байцаагч нарын
ажлын талаар-

Аймгийн төв Мөрөн сумын хэмжээнд одоогоор 6 хэсгийн байцаагч ажиллаж байна. 2018 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас захиргааны зөрчлийн шинжтэй 1639 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч, 861 зөрчилд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 861 хүнд 62.500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 73 иргэнийг шүүхээр 7-30 хоног баривчлах шийтгэл ногдуулж, 113 зөрчилд зөрчлийн хэрэг нээж, 32 зөрчлийг харъяаллын дагуу шилжүүлж, 199 зөрчлийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэлээ. Хэсгийн байцаагч нар хариуцсан баг, хороонд байгаа хорихоос өөр төрлийн ялтай, захиргааны хяналтанд байгаа 33 ялтанд захиргааны хяналт тогтоож ажиллаа. Аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг захиргааны зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлаж холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд давхардсан тоогоор 145 мэдэгдэл шаардлага өгч 145-д нь хариуг авч үр дүнг тооцсон.

Эргүүл шалгалтын хугацаанд архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн 93 иргэнийг эрүүлжүүлэх, саатуулах байранд хүргэж ажилласан. Гэмт хэрэг учралын газрын хамгаалалтанд 26 удаа, эргүүл шалгалтанд 78 удаа ажиллаж, гэмт хэрэг зөрчлийн талаарх илтгэх хуудас 54-ыг бичиж тоо бүртгэлд оруулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч 6 ажил арга хэмжээг зохион байгуулж, үр дүнгийн талаар иргэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 33 ялтны бүртгэл судалгааг шинэчилэн гаргаж захиргааны хяналт тогтоож, сар тутамд уулзаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж ажилласан.

Хэсгийн байцаагчийн хийвэл зохих 26 төрлийн объектийн судалгааны бүртгэл, дэвтэрт шинэчлэлт хийж, байнга архидан согтуурдаг, орчиндоо түгшүүр төрүүлдэг, архаг архичин, гэр оронгүй тэнэмэл иргэд, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд, гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн болон түр буюу удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэдийн судалгааг гарган хяналт тавьж ажилласан байна.

Томилогдсон 6 олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд өдөр тутамд хяналт тавьж, хийсэн ажлын тайлан мэдээг тухай бүрт нь гаргуулж ажиллаж байна.

Бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран болон дангаараа согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг давхардсан тоогоор 52 цэг салбарыг хамруулан 3 удаа үзлэг шалгалт хийж 6 зөрчлийг илрүүлэн арилгуулж, зөрчил гаргасан 7 хүнд 350.000 мянган төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж, Монгол Улсын архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн нөхцөл шаардлагыг зөрчсөн 3 цэг салбарыг шалгаж хууль бусаар борлуулсан 62.5 литр согтууруулах ундааг хурааж зохих журмын дагуу шалгаж шийдвэрлэлээ.

- Албадан саатуулах байрны
үйл ажиллагааны талаар-

Тус цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байрны алба хаагч нар нийт 337 удаагийн 8088 хүн цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн.

Энэ хугацаанд тус цагдаагийн газарт 1394 хүнийг эрүүлжүүлэх байранд хүлээн авч байрны дотоод журмын дагуу эрүүлжүүлэн 1394 хүнээс эрүүлжүүлэхийн хоногийн шууд зардал 5.785.100 төгрөгний тооцоог хийж, төрийн сангийн 170012001 тоот дансанд тушаан цагдаагийн газрын ня-ботой тооцоог сар бүрийн 30-наар таслан хийсэн. Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг 06 цагт босгож хувцаслан, анкет хөтөлж, Цагдаагийн байгууллагын дотоод сүлжээгээр мэдээллийн санд шивж санг баяжуулж байна. Хоногт эрүүлжүүлэгдсэн иргэдийг бүртгэлд хамруулан цагдаагийн газрын хоногийн нэгдсэн рапортонд оруулан өглөө бүр нийт бие бүрэлдэхүүнд танилцууллаа.

Саатуулах байранд хөтлөгдвөл зохих саатуулах байрны рапорт, баривчилгааны нэгдсэн бүртгэл, албадан саатуулагдсан этгээдийг байранд хүлээн авсан бүртгэл, эрүүлжүүлэгсдын карт, байрны шууд зардал хураан авсан баримт, мэдээ мэдээлэл хийсэн бүртгэл, халуун усанд оруулсан бүртгэл зэргийг журмын дагуу хөтлөн дараагийн ээлжинд хүлээлгэн өгч хэвшсэн.

Жижүүрийн хугацаанд тухай бүр Эрүүлжүүлэх, саатуулах байрны эд хогшлын бүрэн бүтэн байдлыг ханган Эрүүлжүүлэх, саатуулах байрны ариун цэвэрт хяналт тавьж нэг бүрчлэн биеэр үзэн, шалгаж хүлээлцэж байна. Нийт 1394 хүн эрүүлжүүлэгдснээс 1352 эрэгтэй, 42 эмэгтэй, 24 цагийн жижүүрийн хугацаанд 10 цагаас 08 цагийн хооронд хүргэгдэн ирж эрүүлжүүлэгдсэн. Эмнэлэгийн анхны тусламжийг 69 хүнд үзүүлэн, ар гэр асран хамгаалагчид нь 156 иргэнийг хүлээлгэн өгч ажилласан байна.

Зөрчлийн тухай хуулийн хүрээнд сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэрээр баривчлагдаж байгаа иргэдийг Баривчлах байрны дотоод журмын дагуу 09-өөс 21 цагийн хооронд нийт 301 хүнийг хүлээн авч, бүртгэлд хамруулан хувийн хэрэг нээж ажиллаа. Баривчлах байрны шууд зардлыг нийт 301 хүнээс 5.191.950 төгрөгний төлбөрийг 100 хувь хураан авч, тооцоог нягтлан бодогчтой хийсэн. Баривчлагдсан иргэдэд албадан сургалтыг өдөр бүр зохион байгуулж нийт 301 хүнд 3260 цагийн сургалтыг зохион байгууллаа. Тус цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байранд шүүгчийн шийдвэрээр баривчлах шийтгэлийг 7 хоногтой 202 хүн, 8 хоногтой 4 хүн, 10 хоногтой 68 хүн, 14 хоногтой 4 хүн, 15 хоногтой 6 хүн, 20 хоногтой 11 хүн, 30 хоногтой 3 хүн, нийт 301 хүн 2572 хоног хоносон байна.

Эрүүлжүүлэх саатуулах байрны үйл ажиллагааг прокурорын байгууллагаас 48 удаа шалган 8 удаагийн үүрэг, ажлын чиглэл өгч алба хаагч нарт танилцуулан биелэлтийг тухай бүрт нь тооцож ажилласан.

Аймгийн Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0257 дугаар ангиудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах албан мэдэгдэл өгч, Онцгой байдлын газарт эрүүлжүүлэх саатуулах байрнаас сургалтыг зохион байгуулсан. Цагдаагийн газрын нээлттэй хаалганы өдөрлөгт 3 удаа оролцон иргэдийн даралтыг үзэж, архидан согтуурахтай тэмцэх тухай, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, эрүүлжүүлэх тухай хуулиуд болон архины хамаарлын тухай гарын авлага боршуур тарааж ажилласан.

Хонх нэгдсэн арга хэмжээ, хүүхдийн баярын хурдан морины хамгаалалт, цагаан сар нэгдсэн арга хэмжээний хүрээнд эрүүлжүүлэх байрнаас ажлын төлөвлөгөө гарган ажиллаж биелэлтийг цагдаагийн газрын даргад илтгэх хуудсаар танилцуулан ажилласан. Архаг архичин болон түгшүүр төрүүлэгчдын судалгааг шинэчлэн гаргасан.

Эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан иргэдийн камерын хяналтыг эмч нарын өрөөнд салаалж хяналтын сайжруулсан. Эрүүлжүүлэх, саатуулах байрыг хариуцсан хяналтын прокурортой хамтарсан зөвлөгөөнийг 2 удаа хийсэн. Эрүүлжүүлэх байранд урсгал засварын ажлыг 1 удаа хийж, сургалтын өрөө гаргаж номын санг бий болгосон. Жижүүрийн хугацаанд эрүүлжүүлэх саатуулах байрны эд хогшлын бүрэн бүтэн

- Эргүүл шалгалтын талаар-

Мөрөн сумын эрүү болон хэв журмын нөхцөл байдлыг тодорхойлон, гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй газруудыг цагдаагийн байнгын хяналтанд авах зорилгоор өдөр бүр Мөрөн сумын хүнсний болон барааны 6 зах дээр 2 офицер, 2 цагдаа байнга ажиллуулж хүнсний зах дээр зарагдаж байгаа мал, мах бэлтгэн борлуулж байгаа хүмүүсийн худалдан борлуулж байгаа мал, махны гарал үүслийн бичиг байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна.

Энэ хугацаанд 7840 алба хаагч 79580 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн байгаагаас Мөрөн суманд өдөр бүр 5 чиглэлд, 8 цагдаагийн алба хаагч өдөр 12:00 цагаас 18:00 цаг, орой 20 цагаас 02:00 цагийн хооронд автомашинт болон явганаар давхардсан тоогоор 37940 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа ба Монгол банкны гэрээт цагдаа, Саатуулах байрны жижүүрээс буугаад амарч байгаа алба хаагчдыг өдөрт 4 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж давхардсан тоогоор 3210 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаа. Хөвсгөл аймгийн 23 суманд ажиллаж байгаа 22 хэсгийн төлөөлөгч, 25 цагдаа нар давхардсан тоогоор 38430 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж сум, багт иргэдийг гэмт хэрэг, зөрчилгүй амар тайван оршин суух нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажилласан байна.

Өнөөдрийн байдлаар Мөрөн, Тариалан, Цагааннуур, Арбулаг, Рэнчинлхүмбэ, Төмөрбулаг сумдын төвийг телекамераар хяналт тавьж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Алба хаагчдын үүрэг гүйцэтгэж буй байдал, ёс зүйд өдөр бүр ёс журмын эргүүлд ажиллаж байгаа албан тушаалтнууд болон хэв журмын тасгийн дарга, ахлах байцаагч нар тогтмол хяналт тавьж, үүрэг, чиглэл өгч мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллаж байна

-Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр-

Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны 09 дүгэр сарын 12-ны өдрийн А/40, 113 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ыг хэрэгжүүлж, шүүхийн байрыг 24 цагийн хугацаагаар хамгаалалтанд авч, шүүх хуралдааны дэг сахиулах, шүүхэд шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан шүүгдэгчийг хуяглан хүргэх, баривчлах шийтгэл оногдуулсан зөрчилд холбогдогчийг шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийн хамт Цагдаагийн газрын саатуулах байранд хүргэн өгөх, шүүх хуралдаанд оролцогч, шүүхийн байранд

нэвтрэн орогчдыг шалган нэвтрүүлэх, шүүгчийн даалгаснаар тодорхой этгээдийг шүүхэд албадан ирүүлэх, шүүхээс даалгасан этгээдүүдийг эрэн сурвалжлах ажиллагааг гүйцэтгэж ажиллаж байна.

2018 онд шүүхийн байран дахь шүүх хуралдааны 2 танхимд явагдсан эрүүгийн хэргийн 603 шүүх хуралдаан, зөрчил шалган шийдвэрлэх 304 шүүх хуралдаан, иргэний хэргийн 1710 шүүх хуралдаан, захиргааны хэргийн 53, магадлангийн 2 нийт 2619 шүүх хуралдааны дэгийг сахиулан ажилласан. Эдгээр шүүх хуралдаанд давхардсан тоогоор 2875 шүүгч, 891 улсын яллагч, 2695 нарийн бичгийн дарга, 620 өмгөөлөгч, 220 хохирогч, 683 шүүгдэгч, 306 зөрчилд холбогдогч, 351 хариуцагч, 1678 нэхэмжилэгч, 49 гэрч, 3 бусад оролцогч оролцсоны аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Цагдан хорих байрнаас шүүхэд 97 шүүгдэгч 79 удаа, шүүхээс цагдан хорих байр луу 162 шүүгдэгчийг 122 удаа, давхардсан тоогоор 259 яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх ажиллагааг 301 удаа автомашинаар гүйцэтгэж ажилласан болно. Энэ хугацаанд олны анхаарал татсан болон олон холбогдогч, шүүгдэгчийн хэрэг хэлэлцсэн шүүх хуралдаан болоогүй учир хүч нэмэгдүүлсэн хамгаалалт, хуяглан хүргэлтийн ажиллагааг хийгдээгүй болно.

Шүүхийн байранд нэвтрэн орох хүсэлт гаргасан 6465 этгээдийг шалган нэвтрүүлсэн ба ямар нэгэн зөрчил гараагүй. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны завсарлагааны үеэр сонирхогч этгээд С.Оюун нь улсын яллагчаар оролцсон хяналтын прокурорыг доромжилсонд зөрчлийн хэрэг нээх шалгуулж шийтгэл оногдуулуулсан ба энэ төрлийн зөрчлийг гаргуулахгүйн тулд авах арга хэмжээний талаар Шүүхийн тамгын газарт санал хүргүүлж, харуулын цагдаа, хамгаалалтын цагдаа нарт зааварчилга өгч ажиллаж байна.

Шүүхээс 4 гэрч, 3 яллагдагч, 31 хариуцагчийг албадан ирүүлэх захирамж ирүүлсэнийг бүртгэлд авч захирамжид дурьдсан 4 гэрч, 2 яллагдагч, 23 хариуцагч албадан ирүүлэх ажлыг зохион байгуулж байна. “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ын 4.20-д заасны дагуу шүүгчийн захирамжийг үндэслэн албадан ирүүлэх ажиллагааг хэрэгжүүлсэн мэдээллийг сар бүр Шүүхийн тамгын газарт хүргүүлсэн.

Шүүхээс эрэн сурвалжлахыг даалгасан 43 шийдвэрийг хүлээн авч бүртгэн 43 этгээдийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж мэдээлэл цуглуулан “ASAP” санд 40 этгээдийн мэдээллийг оруулан эрэн сурвалжлалтыг зарлан мэдээлж, мэдээлэл цуглуулан нийт алба хаагч нар зарлан мэдээлсэн. Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар болон бусад орон нутаг хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдаас шүүхээс даалгасан эрэн сурвалжилж 38 этгээдийг саатуулах болон хаяг тогтоож мэдэгдсэнийг нэхэмжилэгч нарт албан бичгээр мэдэгдэн эрэн сурвалжлалтыг зогсоосон.

“Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ын 5.2-д заасны дагуу эрэн сурвалжилж байгаа этгээдүүдийн талаар мэдээллийг 14 хоног тутам Шүүхийн тамгын газарт хүргүүлсэн. 2018 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн байдлаар шүүхээс эрэн сурвалжлахыг даалгасан 19 шийдвэрийн дагуу 19 этгээдийг эрэн сурвалжилж байна.

Хөвсгөл аймгийн Ханх суманд Иргэний хэргийн анхан шатны болон Давж заалдах шатны шүүгч, шүүхийн ажилтан нар хууль сурталчилах, иргэний нэхэмжлэл хүлээн авах ажил зохион байгуулахад тус сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт зохих үүргийг өгч аюулгүй байдлыг хангаж ажилласан болно.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын дарга, цагдаагийн хурандаа П.Энхтогтохын 2018.04.04-ны өдрийн 13в/464 албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 2.12-д заасан хамгаалалтыг хийж ашиглах талаар эсвэл хүний биеийн хүчийг тэсвэрлэх шил ашиглах саналыг Хөвсгөл аймаг дахь Шүүхийн тамгын газарт хүргүүлсэн боловч уг хаалтыг хийлгэх хөрөнгийг 2019 оны төсөвт тусгуулахаар Шүүхийн ерөнхий зөвлөлд саналаа хүргүүлэхээр болсон гэсэн хариуг ирүүлээд байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүгч, шүүгчийн туслах нартай уулзалт зохион байгуулж эрэн сурвалжлах шийдвэр, албадан ирүүлэх захирамжийн биелэлтийн талаар мэдээлэл хийж санал солилцон, шүүгч нарт аюулгүй байдлаа хангах талаар зөвлөмжийг өгч, мөн дэг сахиулагчаар ажиллаж байгаа цагдаа нарын биеэ авч явах байдал, сануулга өгч, шүүх хуралдааны дэг зөрчигчийг танхимаас гаргах сургуулилтыг

хийсэн. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчтэй нэг удаа уулзаж зөрчлийн хэргийн учир баривчлах шийтгэл оногдуулж буй зөрчилд холбогдогч нарыг хүлээлгэн өгөх, шийтгэлийг эдлүүлэхэд анхаарах асуудлыг зөвлөлдсөн болно.

- Харуул хамгаалалтын
талаар-

Монгол улсын ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Хөвсгөл аймагт айлчлах үеийн хамгаалалтын зураглал төлөвлөгөөг гарган цагдаагийн газрын даргаар батлуулсан. Зураглал, төлөвлөгөөний дагуу хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан. Хамгаалалтанд цагдаагийн 43 офицер, 30 ахлагч 10 тээврийн хэрэгсэл, 24 гар станц, 110 тусгай хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэсэн.

Тус аймагт 2018 оны 02 дугаар сарын 01-ны өдөр Мөрөн сумын төв Чингүнжавын талбайд зохион байгуулагдсан Хөвсгөл аймгийн Ардчилсан намын хорооноос зохион байгуулсан тайван жагсаал цуглаан, 2018 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Мөрөн сумын төв Чингүнжавын талбайд “Уул уурхайгүй Хөвсгөл” төрийн бус байгууллагаас зохион байгуулагдсан жагсаал, цуглааны үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамгаалалтын төлөвлөгөө зураглал гаргаж цагдаагийн газрын даргаар батлуулж, хамгаалалтыг зураглал, төлөвлөгөөний дагуу зөрчил дутагдалгүй зохион байгуулж дүн мэдээг илтгэх хуудсаар Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд хүргүүлж ажилласан.

Хөрш зэргэлдээ Булган аймгийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт Шүлхий өвчний тохиолдол гарч, хүрээгээ тэлж, цаг үеийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулж Хөвсгөл аймгийн засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/132 дугаартай захирамж гарч ажлын хэсэг томилогдсон.

Аймгийн засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 1/411 дугаартай Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын зөвлөмж, хяналтын постонд ажиллах ажлын удирдамж, хуваарь батлагдан гарсантай холбоотойгоор Тариалан сумын Намнангийн ар, Рашаант сумын Сэлэнгэ голын гүүр “Ацын ам”, Рашаант сумын 3 дугаар баг “Тохойн дөрөлж” зэрэг газруудад Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналтын постууд ажиллаж байна. Цэцэрлэг сумын 2 дугаар баг “Хүүш” гэх газарт үхрийн газлзуу өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбоотойгоор сумын засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/29 дугаартай /Галзуу өвчин гарсан бүсэд хязгаарлалт тогтоох/ захирамжаар 14 хоногийн хяналтын пост ажиллаад 2018 оны 03 дугаар сарын 19-ны өдөр цуцлагдсан байна.

Цэцэрлэг сумын 2 дугаар баг “Хүүш”-ийн постонд Цэцэрлэг сум дахь сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар долоо долоо хоногоор ээлжлэн үүрэг гүйцэтгэсэн. Үүрэг гүйцэтгэх үед гарсан томилолт, хоол, тээврийн хэрэгсэл, шатхууны зардал зэргийг сумын засаг даргын тамгын газраас олгож ажилласан.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналтын 3 постонд Тариалан сум дахь цагдаагийн хэсгийн 2 цагдаа, Тосонцэнгэл сум дахь замын зохицуулагч, хэсгийн цагдаа, Их-Уул сум дахь хэсгийн мөрдөгч, хэсгийн цагдаа, Рашаант сум дахь хэсгийн мөрдөгч, хэсгийн цагдаа, аймгийн төвөөс 2 цагдаа зохицуулагч гэсэн 10 алба хаагчийг хуваарийн дагуу 5 хоногоор ээлжлүүлэн үүрэг гүйцэтгүүлж байна.

Хяналтын постонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нараас сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргаагүй, өгсөн зааварчилгааны хүрээнд үүргээ зохих журмын дагуу гүйцэтгэж байна. Цаашид алба хаагчийн сахилга, ёс зүйн байдалд тавих хяналтыг тогтмолжуулан ажиллах болно. Аймгийн онцгой байдлын газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын томилогдсон алба хаагч нартай хамтран хяналтын постонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарын үүрэг гүйцэтгэлт, үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 7 удаа хийсэн.

Хяналтын постонд үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчийн албан томилолт, хоолны зардлыг аймгийн засаг даргын нөөц сангаас олгож байна.

Хорио цээрийн дэглэм сахиулах хяналтын постонд үүрэг гүйцэтгэхэд стандартын хаалт, гэрэлтүүлэгч /маяк/, хурд хязгаарлагч, төрөл бүрийн замын тэмдэг шаардлагатай байгааг 2018 оны 03 дугаар сарын 9-ны өдрийн аймгийн онцгой комиссийн хуралд төсөв хөрөнгийг гаргаж шийдвэрлэсэн.

Болзошгүй нөхцөл байдал үүссэн нөхцөлд ажиллах ажиллагааны талаар үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудтай 4 удаа хамтарсан уулзалтыг зохион байгуулж ажилласан. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 9 дүгээр сарын 10-наас эхлэн 4 тээврийн хэрэгсэлтэйгээр хөдөлгөөнт хяналт шалгалтын постыг ажлуулсан. Мөн байгалийн гамшиг ослын үед ажиллах төлөвлөгөөг гаргаж Онцгой байдлын газрын даргаар хянуулж Аймгийн засаг даргаар батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. Хүн малын гоц халдварт овчин гарсан 6 тохиолдолын хамгаалалтанд нийт давхардсан тоогоор 20 алба хаагч 24 хоног буюу 3840 цаг үүрэг гүйцэтгэсэн. Халдварт өвчин гарсан талаар мэдээлэл авмагц сум баг хариуцсан алба хаагч нарт утсаар болон биеэр үүрэг чиглэл өгч хэрхэн ажиллах чиглэлээр тухай бүр зааварчлага хүргүүлж ажиллаа. Хүн малын гоц халдварт өвчин гарсан үеийн хамгаалалтын чиглэлээр Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагч нарт 8 цагийн сургалт зохион байгууллаа. Аймагт гарсан байгалийн гамшиг, осол, халдварт өвчний мэдээг сар бүрийн 30-аар тасалбар болгож дараа сарын 05-ны дотор Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд хугацаанд нь хүргүүлэн ажиллаа. Энэ хугацаанд аймгийн сумдын нутаг дэвсгэрт гарсан 7 удаагийн ой хээрийн түймрийн газарт 12 цагдаагийн алба хаагч 22 хоног буюу 532 цаг үүрэг гүйцэтгэж ажилласан.

-Онцлог чиг үүрэгтэй байгууллагууд үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, тоо, хувь. /

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Сар шинэ” “Мөсний баяр-2018” болон бусад нийтийг хамарсан 42 удаагийн арга хэмжээний хэв журам, замын хамгаалалтын төлөвлөгөө зураглал гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулж нийт 644 цагдаагийн алба хаагч 5152 цаг хамгаалалтын үүрэг гүйцэтгэж зөрчил дутагдалгүй зохион байгуулж ажилласан.

Энэ хугацаанд тус цагдаагийн газраас Ерөнхий арга хэмжээ 24, тусгай арга хэмжээ 27, нэг бүрчилсэн арга хэмжээг 51 удаа зохион байгуулж ажилласан. Аймгийн хэмжээнд бүртгэлтэй байгаа 2950 галт зэвсгийг тоолж, шинээр 22 галт зэвсгийг тоолж, нуугдмал 36 галт зэвсгийг хураан авсан.

-Дүгнэлт-

Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, 2018 онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаа.

Хэргийн илрүүлэлт 47.5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.8 хувиар өссөн байна. Хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх тасгийн дарга нарт цагдаагийн газрын даргын ажлын чиглэл, үүргийг тухай бүрт нь өгч биелэлт үр дүнг тооцож ажиллаж байна.

Хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 248 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 94 хэргээр буюу 61.0 хувиар, Мал хулгайлах гэмт хэрэг 95 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 32 хэргээр буюу 50.8 хувиар, Залилах гэмт хэрэг 28 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 9 хэргээр буюу 47.4 хувиар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 41 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 26 хэргээр буюу 173.3 хувиар, Хүчиндэх гэмт хэрэг 24 бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 8 хэргээр буюу 44.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тус цагдаагийн газраас 2018 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, аймгийн хэмжээнд бүртгэгдэж байгаа амиа хорлох гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтарч Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчилан хамба лам Д.Чойжамц, мөн хийдийн гавж н.Нямсамбуу, н.Од, н.Баяраа нарыг урьж “Зөв амьдрахуй” сэдэвт цуврал лекцийг өдөрт 2 удаагийн давтамжтай төрийн болон төр захиргааны байгууллагуудын ажилтан алба хаагчид, иргэд олон нийтэд үнэ төлбөргүй хүргэсэн нь тэдний эрэлт, таашаалд нийцсэн арга хэмжээ болсон.

Уг арга хэмжээнд 14528 алба хаагч иргэд хамрагдсан. Тус цагдаагийн газрын 62 алба хаагч сургалтанд хамрагдсан.

-Санал-

Гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, дэвшүүлсэн зорилтод түвшинг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Аймгийн хэмжээнд статистик тоон үзүүлэлтээр өссөн үзүүлэлттэй байгаа тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, иргэдэд шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах ажлыг чанаржуулах

Шинээр батлагдсан хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх

ТАЙЛАН БИЧСЭН: ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Д.УРТБАЯР

ХЯНАСАН: ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Ц.АДЪЯАЦЭРЭН